





**МОНГОЛ УЛСАД ЖЕНДЭРТ СУУРИЛСАН  
ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ НЬ ТӨСЛИЙН  
1-Р ШАТНЫ АМЖИЛТЫН НОМ  
2020**





## ГАРЧИГ

ЕРӨНХИЙ ТОЙМ	2
ТӨСЛИЙН АМЖИЛТЫГ ТООГООР ИЛЭРХИЙЛЭХ НЬ	6

<b>ҮР ДҮН 1.</b>	9
Бодлого боловсруулахад шаардлагатай ЖСХ/ГБХ-ийн нотолгоо, тоо мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэв.	

<b>ҮР ДҮН 2.</b>	23
Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийт болон шийдвэр гаргагчдын ойлголт нэмэгдэж, ЖСХ/ГБХ-ийг таслан зогсоох үйл ажиллагаа эрчимжив.	

<b>ҮР ДҮН 3.</b>	37
Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааг дэмжсэн орчин бий болж, хохирогчдыг хамгаалах үйлчилгээ институтчлэгдэв.	

<b>ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛОН СУРГАМЖ</b>	85
---------------------------------------	----

## ЕРӨНХИЙ ТОЙМ

Жендэрт Суурилсан Хүчирхийлэл (ЖСХ) гэдэг нь хүмүүний хүйс болон жендэрийн талаарх уламжлалт хэвшмэл ойлголтоос (стереотип) үүдсэн буруу ташаа ойлголт, төсөөлөл, нийгмийн хэм хэмжээ, хүлээлт болон эрх мэдэл, хүчний тэнцвэргүй байдлаас улбаатай хүчирхийллийн аливаа үйлдлийг хэлнэ. ЖСХ нь хүний эрхийн хамгийн түгээмэл зөрчлүүдийн нэг бөгөөд үүний улмаас хүмүүсийн нийгэм, эдийн засаг болон улс төрийн эрх зөрчигдөж, бие махбодын, бэлгийн, сэтгэл зүйн хүчирхийллийн хохирогч болж, сэтгэл хангалуун амьдрах эрхээ эдлэх боломжгүй болдог. Мөн удаан хугацаанд үргэлжлэх биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн тоо томшгүй олон асуудлын шалтгаан болохоос гадна зарим ноцтой тохиолдолд хүний амь нас ч хохирох нь бий.

Гэсэн хэдий ч ЖСХ нь Монгол улсын хувьд олон жилийн туршид нэгдсэн ойлголтгүй, судлагдаагүй асуудал байсаар ирсэн. ЖСХ-ийн талаарх үндэсний цогц мэдээллийн сан байхгүйн улмаас олон нийт ЖСХ Монгол улсад ямар хэмжээний тархалт, цар хүрээг хамарсан талаар мэдэхгүйгээр үл барам зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал мэтээр ташаа ойлгож ирсэн байна. Түүнчлэн ЖСХ, тэр дундаа Гэр бүлийн хүчирхийллийг (ГБХ) хос хоёрын хоорондын хувийн асуудал бөгөөд түүнд хэн нэгэн хөндлөнгөөс оролцох ёсгүй гэж олон хүн үздэг байв. Хэдийгээр ГБХ-тэй тэмцэх 2004 онд батлагдсан анхны

хуульд ГБХ-ийг хүний эрхийн ноцтой зөрчил төдийгүй нийгмийн эрүүл мэндийн асуудал болохыг тунхагласан хэдий ч энэ төрлийн хүчирхийллийн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байсаар байв. Мөн ЖСХ болон ГБХ-ээс урьдчилан сэргийлэх хийгээд хүчирхийллийн даван туулагчдыг хамгаалах чиглэлд маш бага хөрөнгө хуваарилдаг байсан. Олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр зарим ТББ-уудын ажиллуулдаг цөөн хэдэн түр хамгаалах байр л ЖСХ/ГБХ-ийн хохирогч, даван туулагчдын хэрэгцээнд тохирсон тусламж үйлчилгээг үзүүлдэг байв.

ЖСХ нэмэгдэж, улмаар газар авах нь тогтвортой хөгжилд томоохон саад бэрхшээл учруулж, хувь хүн, нийгэм болон улс орны хэмжээнд хүний хөгжил хийгээд нийгэм-эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг. Иймээс Монгол улсад ЖСХ, түүний дотор ГБХ-тэй тэмцэхийн чухлыг ойлгосны үндсэн дээр НҮБ-ын Хүн амын сан (НҮБХАС) болон Швейцарын хөгжлийн агентлагаас (ШХА) Монгол улсад ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслах зогсоох үндэсний чадавхийг бэхжүүлэх цогц төлөвлөгөө боловсруулахаар засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагууд зөвшилцөж эхэлсэн.

Энэхүү хэлэлцүүлгийн дүнд Монгол улсад ЖСХ-ийн бодит байдал ямар байгааг тодорхойлох мэдээллийг бий болгож, ашиглах; шийдвэр гаргагчид болон олон нийтийн ЖСХ-ийн талаарх ойлголтыг

гүнзгийрүүлж, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааг эрчимжүүлэх; мөн хүчирхийллийн даван туулагчдыг хамгаалж, шаардлагатай үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ хүчирхийллийг дахин давтагдахаас урт хугацаанд сэргийлэхэд чиглэсэн салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцдог байх зохицуулалтын механизмууд болон бодлогын тогтолцоог бэхжүүлэх зорилготой дөрвөн жилийн санаачилга болох “Монгол Улсад ЖСХ-тэй тэмцэх нь” төсөл хэрэгжихээр болсон юм.

ЖСХ-тэй тэмцэх нь төслийг 2016-2020 оны хооронд Монгол улсын Засгийн газар болон НҮБХАС хамтран хэрэгжүүлсэн. Төсөл ШХА-ын 4.3 сая ам.доллар, НҮБХАС-ийн 853,000 ам.долларын санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн. Монгол улсын Засгийн газар мөн санаачилгад зориулж 452,000 ам.долларын хувь нэмрээ оруулсан бөгөөд энэ санхүүжилтийн дийлэнх хэсэг нь шийдвэр гаргагчид ЖСХ-тэй тэмцэхэд засгийн газрын үүрэг ямар байх вэ гэдгийг илүү соргоогоор мэдэрч, ойлгож эхэлсэн төслийн сүүлийн жилүүдэд хийгдсэн юм.

## ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД

НҮБХАС нь Монгол улсад жендэрийн тэгш байдлыг тууштай дэмжиж, ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр сүүлийн жилүүдэд тууштай ажиллаж ирсний хувьд энэ бүх хүчин чармайлтыг удирдан зохицуулах, хэрэгжүүлэх гол үүргийг хүлээсэн билээ. Төслийн туршид НҮБХАС нь мэргэжлийн зөвлөмжүүдээр хангахын

зэрэгцээ санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилласан юм. Нөгөө талаас Монгол дахь Швейцарын хөгжлийн агентлагийн стратегийн тэргүүлэх чиглэлүүдийн дотор жендэр багтсан байдаг бөгөөд ШХА-ийн бүхий л үйл ажиллагаанд тусгалаа олдоогоос гадна энэхүү төслөөр ЖСХ болон ГБХ-тэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх санаачилгыг санхүүжүүлсэн. ШХА нь төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна төслийн Удирдах хорооны бүрэлдэхүүнд орж ажиллан, төслийн хэрэгжилттэй холбоотой стратегийн зөвлөмжүүдээр ханган, чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Гэхдээ ЖСХ-тэй тэмцэх нь төсөл нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Монгол улсын хуулийг хэрэгжүүлэх үндэсний чадавхийг бэхжүүлэх замаар ЖСХ болон ГБХ-ийг бууруулах зорилготой бөгөөд төслийн хэрэгжүүлэгчээр засгийн газрын холбогдох яам, агентлагууд болон төрийн бус байгууллагууд хамтран ажилласан.

- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
- Эрүүл мэндийн яам
- Жендэрийн үндэсний хороо
- Үндэсний статистикийн хороо
- Цагдаагийн ерөнхий газар
- Онцгой байдлын ерөнхий газар

- Хүний эрхийн үндэсний комисс
- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв

Түүнчлэн, энэхүү төслийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн төрийн бус байгууллага (ТББ) болон хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан юм.

### ТББ-УУД:

- Хөөрхөн зүрх
- Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэн

- Нийгмийн ажлын хөгжлийн төв
- Хүйсийн тэгш эрхийн төв
- Сайн тус

### ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУД

- Монгол контент
- Засгийн газрын мэдээ
- Монголын хэвлэлийн хүрээлэн
- Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл

ҮР НӨЛӨӨ: МОНГОЛ УЛСАД ЖСХ/ГБХ-ТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ		
<p><b>ҮР ДҮН 1:</b> Цаашид бодлогын орчныг сайжруулахад шаардлагатай ЖСХ/ГБХ-ийн нотолгоо мэдээлэл үүсгэв.</p>	<p><b>ҮР ДҮН 2:</b> Эрх эдлэгчид болон үүрэг хүлээгчид ЖСХ-ийг илүү сайн ойлгож, тэмцэх арга хэмжээ авахад илүү бэлэн болов.</p>	<p><b>ҮР ДҮН 3:</b> Төслийн зорилтот газруудад ЖСХ/ГБХ-д хариу арга хэмжээ авах салбар дундын хамтын ажиллагаа бэхжив.</p>
<p>Үндэсний хэмжээний ЖСХ-ийн судалгаа хийж үр дүнг үндэсний хэмжээнд түгээв.</p>	<p>ЖСХ-ийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгт мэдэгдэхүйц өөрчлөлт гарсанаар ГБХ-ийн тохиолдлыг мэдээлэх явдал нэмэгдсэн.</p>	<p>Даван туулагчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх механизмийг бий болгон, үндэсний хэмжээнд хүчирхийллийн хохирогчдод зориулсан 11 Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг 7 аймаг, 4 дүүрэгт байгуулсан.</p>
<p>ЖСХ-ийн цахим мэдээллийн нэгдсэн сан байгуулагдсан.</p>	<p>ЖСХ-ийн эсрэг хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгосноор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдаж, түүнийг хэрэгжүүлэх 31 журам батлагдан хэрэгжиж байна.</p>	<p>ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг зохицуулах ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаа үндэсний болон орон нутгийн хэмжээнд бэхэжсэн.</p>



# ТӨСЛИЙН АМЖИЛТЫГ ТООГООР ИЛЭРХИЙЛЭХ НЬ

## 1. ХОХИРОГЧ, ДАВАН ТУУЛАГЧДИЙГ ХАМГААЛАХ МЕХАНИЗМ

- Шинээр 11 нэг цэгийн үйлчилгээний төвийг (НЦҮТ) байгуулж, үйл ажиллагаа явуулж байсан 6 НЦҮТ-д дэмжлэг үзүүлж,
- Эрчүүд, хүчирхийлэл үйлдэгчдэд албадан сургалтын төв байгуулж,
- НЦҮТ-үүдээс 9,677 хүн үйлчилгээ авч,
- 1,716 кейсийг хамтарсан багаар шийдвэрлэсэн байна.

## 2. САНХҮҮЖИЛТ

- НЦҮТ байгуулж, үйл ажиллагаа явуулахад орон нутгийн төсвөөс 1 тэрбум төгрөгийн төсөвийг хуваарилж,
- Төслийн зүгээс түүнтэй дүйцэхүйц 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулав.

## 3. ТОО МЭДЭЭЛЭЛ, ҮНЭЛЭГЭЭ

- Үндэсний хэмжээний ЖСХ-ийн тархалтын судалгаа
- 3 мэдээллийн сан:
  - Цагдаагийн ерөнхий газар дээр хүчирхийллийн дуудлага мэдээллийн eGBV нэгдсэн сан,
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэд ЖСХ-ийн үйлчилгээний мэдээллийн сан,

- НҮБ-ын Хүн амын сангийн дэргэд холбогдолтой мэдээлэл сургалт сурталчилгааны материалын төвлөрсөн сан
- ЖСХ-ийн өртгийн 2 судалгаа
  - Үйлчилгээний зардлын тооцоо,
  - Эдийн засгийн өртөг, зардлын тооцоо
- Жижиг хэмжээний 2 судалгаа
  - НЦҮТ-ээр үйлчлүүлэгдийн сэтгэл ханамжийн судалгаа
  - Олон нийтийн мэдлэг хандлагыг өөрчлөх аянуудын судалгаа
- 5 үнэлгээ
  - ЦЕГ дээр урьд нь байсан мэдээллийн сангийн үнэлгээ
  - eGBV мэдээллийн нэгдсэн санг нийгмийн бусад салбарын мэдээллийн сантай холбох боломжийн үнэлгээ
  - НЦҮТ-үүдийн үйл ажиллагааны үнэлгээ
  - Ковид-19 цар тахлын ЖСХ/ГБХ-ийн нөхцөл байдалд хэрхэн нөлөөлж байгаа талаарх түргэвчилсэн үнэлгээ
  - ЖСХ-ийн асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн хөндөж байгаа талаар агуулгын үнэлгээ
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн зүгээс хийсэн 2 мониторингийн тайлан





#### 4. ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- Жендэрийн үндэсний хороон дээр сургалтын танхим байгуулсан.
- 177 сургалт, семинар, чуулганд 13,604 оролцогчид хамрагдсан.
- Олон улсын туршлага судлах 4, дотоодын туршлага судлах 2 аялалыг зохион байгуулж нийт 122 хүн оролцсон.
- Доорх 4 сургалтын байгууллагын төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрт ЖСХ-ийн асуудлыг оруулж өгсөн.

#### Үүнд:

- Монголын Хэвлэлийн Хүрээлэн
- Монгол Улсын Их Сургуулийн Нийгмийн ажлын тэнхим
- Монгол Улсын Их Сургуулийн Сэтгүүлзүйн тэнхим
- Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
- Хууль Сахиулахын Их Сургууль
- ЖСХ-ийн цөм хөтөлбөрийг мөн боловсруулсан.

## 5. БОЛОВСРУУЛСАН ГАРЫН АВЛАГА, УДИРДАМЖУУД

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх 31 журмыг боловсруулж батлуулсан.
- Үйлчилгээний 3 стандарт болон 10 сургалтын гарын авлага, удирдамжийг боловсруулсан. Үүнд:
  - Нэг цэгийн үйлчилгээний төвд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, нийгэм-сэтгэлзүйн, хууль эрхзүйн болон цагдаагийн үйлчилгээний стандартууд
  - Төрийн албанд шинээр орсон албан хаагчдад зориулсан жендэр ба бодлого төлөвлөлт сургалтын модуль
  - Редакциудад зориулсан жендэр ба ЖСХ-ийн асуудлыг мэдрэмжтэй нийтлэх талаар удирдамж
  - ЖСХ-ээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах чиглэлээр нийгмийн ажилчдад зориулсан сургалтын модуль
  - Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх сургалтын гарын авлага
  - Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгчдэд үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээ эмнэлзүйн гарын авлага
  - Хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан зан үйлд нөлөөлөх сургалтын гарын авлага /туршилт/
  - Нийгмийн ажилчдад зориулсан гарын авлага
  - eGBV мэдээллийн нэгдсэн сангийн хэрэглэгчийн гарын авлага

- Ковид-19 цар тахалтай тэмцэх фронт дээр ажиллаж байгаа албан хаагчдад ЖСХ, хүүхдийн хүчирхийллийг хариу арга хэмжээ авахад зориулсан зөвлөмж
- Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны ажилтнууд, хамтарсан багуудын зүгээс Ковид-19 цар тахлын үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамж

## 6. НӨЛӨӨЛЛИЙН АЖЛУУД БОЛОН ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

- Холбогдох хуулиудын шинэчилсэн найрууллагуудыг батлуулах нөлөөлөл:
  - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /батлагдсан/
  - Зөрчлийн тухай хууль /батлагдсан/
  - Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /батлагдсан/
  - Гэр бүлийн тухай хууль /УИХ-д өргөн барьсан/
  - Нийгмийн халамжийн тухай хууль /ажлын хэсэг ажиллаж байгаа/
  - Статистикийн тухай хууль /ажлын хэсэг ажиллаж байгаа/
- Олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх 4 том кампанит ажлууд болон бусад жижиг аянуудыг өрнүүлж давхардсан тоогоор 15,7 сая хүнд хүрсэн.

**ҮР ДҮН**

**1**

Бодлого боловсруулахад  
шаардлагатай ЖСХ/ГБХ-ийн  
нотолгоо, тоо мэдээллийн  
хүртээмжийг нэмэгдүүлэв.



Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй (ЖСХ) тэмцэхэд үнэн зөв, тоо мэдээлэл гол үүрэг гүйцэтгэдэг. Олон нийтийн дунд саяхан болтол ЖСХ, ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн (ГБХ) асуудлыг ил тод ярьдаггүй сэдэв гэсэн ойлголт түгээмэл байсан. Учир нь олон хүн ЖСХ/ГБХ-ийг хосуудын дундах, гэр бүлийн дотоод асуудал гэж үздэг. Түүнчлэн ЖСХ/ГБХ-ийг тойрсон хэвшмэл буруу ойлголт, нийгэмд тогтсон хэм хэмжээ, хандлагын улмаас эл асуудлыг хэр хэмжээнд, хэр ноцтой тархсан талаарх тоо мэдээлэлгүйгээр нарийн тодорхойлоход бэрх байдаг. Ийнхүү тоо мэдээлэл дутмаг байгаа нь олон хүнийг ЖСХ/ГБХ огт байхгүй, эсвэл тийм ч их тохиолдоод байдаггүй асуудал, эсвэл төрөөс анхаарч үзэх хэмжээний ноцтой асуудал биш гэж ойлгоход хүргэх нь бий. Ийм учраас тоо мэдээлэл нь тухайн асуудлын мөн чанарыг ойлгох, түүнийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Монголын нийгэмд ЖСХ/ГБХ нь яахын аргагүй төр засгийн зүгээс анхаарал хандуулж, хөрөнгө хуваарилж шийдвэрлэх, олон нийтийн зүгээс хамтран тэмцэх шаардлагатай асуудал болоод байгаа гэдгийг ойлгуулж, урьдчилан сэргийлэх, таслан зогсооход тоо мэдээлэл чухал үүрэгтэй.

Ийм учраас тоо мэдээллийг бий болгох, хүртээмжийг сайжруулах, ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг “ЖСХ-тэй тэмцэх нь” төслийн чухал нэг зорилго болгож, энэ нь хүрэх үр дүн 1-д тусгалаа олсон юм. Ингэснээр үндэсний хэмжээний ЖСХ-ийн судалгаа хийгдэж, Монгол

улс дахь ЖСХ-ийн тархалтын талаарх мэдээллийг бий болгон, олон нийтэд түгээснээр ЖСХ/ГБХ -ийн асуудал шийдвэр гаргагчид болон олон нийтийн анхаарлыг татсан. Үүний үр дүнд эл асуудлын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг нэмэгдсэн төдийгүй шийдвэр гаргагчдын зүгээс ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох яаралтай арга хэмжээ авах цаг болсон гэдгийг ойлгуулсан. Түүнчлэн, Цагдаагийн ерөнхий газрын (ЦЕГ) дэргэд улс орон даяар ЖСХ/ГБХ-ийн захиргааны мэдээллийг тогтмол цуглуулах тогтолцоо буюу eGBV мэдээллийн нэгдсэн санг байгуулсан. Энэхүү мэдээллийн сан нь ЖСХ/ГБХ-ийн дуудлага мэдээллийг бүртгэн мэдээлэхээс гадна ЖСХ/ГБХ-ийн дуудлагын мөрөөр авах арга хэмжээг сайжруулах, хүчирхийллийн гаралтын нөхцөл байдал болон өсөлт бууралт, хүчирхийллийн шинж чанарт гарч байгаа өөрчлөлт, динамикийг тогтоон сар, улирал, жилээр гардаг мэдээллийн эх сурвалж болсон.

Үндэсний хэмжээний ЖСХ-ийн судалгаа, захиргааны мэдээллийн сан, мөн төслийн хүрээнд хэрэгжсэн бусад судалгааны үр дүнд суурилан хүчирхийллийн гаралт өндөр газруудад болон өндөр эрсдэлтэй бүлгүүдэд зориулсан олон арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Түүнчлэн эдгээр тоо мэдээлэл нь олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны аяныг зохион байгуулахад ашиглах мессежийг илүү амьдралд ойр, хүчирхийллийг таслан зогсооход юу хийх шаардлагатайг тодорхойлоход тустай байсан

байна. Энэхүү төслийн хүрээнд буй болсон тоо мэдээллүүдийг хүчирхийллийг таслан зогсоох үндэсний хэмжээний бодлого журмуудыг боловсруулах, ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад чиглэсэн бусад донорын санхүүжилттэй төслүүдийг боловсруулахад ашигласан. Судалгааны мэдээлэлтэй болж, түүнийг бусад өгөгдөл, мэдээллийн эх сурвалжаар улам баяжуулснаар үндэсний болон орон нутгийн хэмжээнд нотолгоонд суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлсэн юм.

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

### 1 ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН СУДАЛГАА

**2018 онд хэвлэгдсэн “Хүчирхийллийн нүцгэн үнэн:** Монгол дахь жендэрт суурилсан хүчирхийллийн үндэсний судалгаа 2017” нь Монгол улс дахь ЖСХ-ийн тархалт, үүний дотор ойр дотны хамтрагч болон хамтрагч бус хүний зүгээс үйлдсэн хүчирхийллийн тархалт ямар түвшинд байгааг ил болгосон чухал ач холбогдолтой судалгаа болсон юм. Судалгааг Үндэсний статистикийн хороо, Монгол дахь НҮБХАС болон Ази, Номхон Далайн Бүс Нутгийн НҮБХАС-ийн арга зүйн дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн бөгөөд олон улсын тоон болон чанарын судалгааны арга аргачлалуудыг Монголын нөхцөлд тохируулан авч ашигласан. Судалгаагаар ЖСХ-ийн тархалтын хэмжээ, суурь шалтгаан (ЖСХ-ийн суурь шалтгаан болдог хэвшмэл

хандлага, хорт зуршил, итгэл үнэмшил), гэр бүл, эрүүл мэнд болон хүүхдэд үзүүлэх нөлөөлөл, үр дагавар, мөн түүнийг даван туулах механизмийг тодорхойлжээ. Үндэсний хэмжээний судалгааны үр дүнг оролцооны аргад тулгуурласан сургалтаар дамжуулан 21 аймаг болон нийслэл Улаанбаатар хотын 9 дүүрэгт өргөн хүрээнд түгээсэн юм. Түүнчлэн олон нийтэд мультимедиа контент болон нийгмийн сүлжээгээр дамжуулан түгээсэн. Энэхүү судалгаа нь бодлогын нөлөөллийн ажлууд болон олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх олон төрлийн санаачилгуудад суурь мэдээлэл болж өгснөөс гадна жендэрийн талбарт үйл ажиллагаа явуулдаг бусад олон улсын болон үндэсний хэмжээний байгууллагуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг мэдээллээр хангасан.

Энэхүү судалгаа нь 2019 онд дэлхийн хамгийн том мэргэжлийн судалгааны байгууллага болох ESOMAR Хүрээлэнгийн нийгмийн хөгжилд чиглэсэн буяны салбар байгууллага болох ESOMAR сангаас зохион байгуулдаг олон улсын “Өөрчлөлтийг авчрах” уралдааны жендэрийн тэгш байдлын төрөлд ялагчаар шалгарсан юм.

### 2 eGBV ТОО МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн байгууллагаас ГБХ-ийн дуудлага мэдээллийг цуглуулах ЖСХ-ийн eGBV цахим мэдээллийн нэгдсэн санг ЦЕГ-ын дэргэд 2017 онд байгуулсан юм. eGBV мэдээллийн сан нь ЖСХ/ГБХ-ийн дуудлага мэдээллийг бүртгэн,

дуудлагын мөрөөр авах арга хэмжээг сайжруулах зорилготойгоос гадна бодлого төлөвлөлтөд ашиглах, ГБХ-ийн дуудлага аваад хэргийн газарт очих цагдаагийн ажилтнуудад тухайн хаяг дээрх өрхийн хүчирхийллийн түүх, онцлог шинж чанарын талаарх мэдээллийг авч оновчтой шийдвэр гаргах боломжийг олгох төдийгүй хүчирхийлэл гэмт хэргийн шинжтэй нөхцөлд шүүхийн ажиллагаанд нотлох баримтаар хангахад туслах юм.

### 3 ЖСХ-ийн үйлчилгээний мэдээллийн сан

Төслийн хүрээнд ЖСХ-ийн үйлчилгээний мэдээллийн санг хөгжүүлсэн бөгөөд 2020 оноос Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны (ХНХЯ) дэргэд туршиж байна. Уг мэдээллийн сан нь цагдаад мэдээлэгдсэн хүчирхийллийн тохиолдлын хохирогчид дуудлагыг хүлээн авсан цагаас эхлэн үзүүлсэн үйлчилгээ, орон даяар үйл ажиллагаа явуулж байгаа бүх НЦҮТ болон түр хамгаалах байруудад (ТХБ) болон хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг хамтарсан багийнхны зүгээс үзүүлсэн бүхий л үйлчилгээг санд оруулан нэгтгэх юм. Ингэснээр хүчирхийллийн тохиолдол бүрийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийх, алдаа оноог цэгнэх, шаардлагатай тохиолдолд зөвлөмж өгөх, мөн хариуцлага тооцох, бодлого төлөвлөлтийг илүү оновчтой болгоход ашиглах боломжийг олгож байгаагаараа чухал ач холбогдолтой. Мэдээллийн санд аливаа нэг үйлчлүүлэгчийн

тусламж хүссэн тоо, авсан үйлчилгээнүүд болон тэдгээрийн тус бүрийн зардал, мөн хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж болох баримтжуулсан нотолгоо зэрэг хэрэгтэй мэдээллүүдийг хадгална. Энэ нь мөн үйлчилгээний дутагдалтай талыг илрүүлэх болон даван туулагчдад үзүүлж буй үйлчилгээний чанар хийгээд бүрэн цогц байдлыг үнэлэх боломжийг олгодог. Энэхүү мэдээллийн сангийн туршилтын үр дүн болон сургамж дээр үндэслэн цаашид сайжруулан хөгжүүлж, илүү цогц, оновчтой болгохоор төлөвлөж байна.

### 4 ЖСХ-ийн холбогдолтой мэдээлэл сургалт сурталчилгааны материалын төвлөрсөн сан

Төслийн хүрээнд бий болсон ЖСХ-ийн холбогдолтой мэдээлэл сургалт сурталчилгааны материалын төвлөрсөн санг ЖСХ/ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр төслийн хүрээнд боловсруулсан сургалтын болон мэдээллийн материалуудыг багтаан НҮБХАС-ийн дэргэд 2020 онд байгуулсан юм. Уг төвлөрсөн санг олон нийт болон ЖСХ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг болон явуулахаар төлөвлөж байгаа талууд ашиглах боломжтой бөгөөд ЖСХ/ГБХ-ийн талаарх үнэн зөв мэдээллийг авах юм. Одоогоор ЖСХ-ийн мэдээлэл сургалт сурталчилгааны материалын төвлөрсөн сан нь төслийн хүрээнд боловсруулсан материалуудыг багтаасан байгаа бөгөөд цаашид бусад эх үүсвэрүүдийг нэмэн баяжуулж явах юм.

## 5 МОНГОЛ УЛС ДАХЬ ЖСХ-ИЙН ӨРТӨГ ЗАРДЛЫН ТООЦОО

ЖСХ-ийн улмаас улс орны эдийн засаг, хувь хүмүүсийн амьдралд гарах хохирлыг тооцоолох зорилгоор ЖСХ-ийн үйлчилгээний болон эдийн засгийн өртөг, зардлын судалгааг 2018 болон 2020 онуудад тус тус гүйцэтгэж, үр дүнг нь түгээсэн билээ. Эхний судалгаагаар ЖСХ-ийн даван туулагчдад зориулсан үйлчилгээнд засгийн газраас хэр хэмжээний төсөв хуваарилж буй болон хэдий хэмжээний төсөв шаардлагатайг тооцоолох замаар ЖСХ-ийн даван туулагчдад зориулсан үйлчилгээний нийт зардлыг судалсан юм.

Хоёр дахь судалгаагаар ЖСХ-ийн улмаас өрх гэр болон макро эдийн засгийн түвшинд хэдий хэмжээний эдийн засгийн хохирол учирч байгааг тооцоолсон. Уг судалгааны үр дүн нь дан ганц хувь хүмүүсийн хувьд төдийгүй улс орны эдийн засагт урт хугацаанд учрах хохирлыг бууруулах, ЖСХ-ийг таслан зогсоох хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэхэд хөрөнгө оруулалт хийх шаардлагатайг холбогдох талуудад ойлгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.





## ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

### ҮР ДҮН

**ҮР ДҮН 1:** ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоход чиглэсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөхөд шаардлагатай үндэсний хэмжээний нотолгоо мэдээлэлтэй болсон байна.

1.1. ЖСХ-ийн тоо мэдээлэл цуглуулах тогтолцоо бий болж, институтчилэгдсэн байна.

*Суурь үзүүлэлт:* Тархалтын мэдээлэл байгаагүй (2016)

*Хүрэх үр дүн:* Үндэсний хэмжээний судалгааны мэдээлэлтэй болсон (2018)

#### **БҮРЭН ХЭРЭГЖСЭН**

Үндэсний хэмжээний ЖСХ-ийн судалгаа (2017) хийгдэж, eGBV мэдээллийн санг (2018) үүсгэв.

1.2. Үндэсний хэмжээний судалгааны үр дүнг болон нэгдсэн тоо мэдээллийн сангийн мэдээллийг ашигласан бодлогын баримт бичгийн тоо.

*Суурт үзүүлэлт:* 3 (2016)

*Хүрэх үр дүн:* 6 (2020)

#### **БҮРЭН ХЭРЭГЖСЭН**

ГБХТТХ болон 31 журам шинэчлэгдэв.

1.3. Статистикийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон байна.

*Суурь үзүүлэлт:* Статистикийн тухай хуульд ЖСХ-ийн судалгаа ороогүй (2016).

*Хүрэх үр дүн:* Статистикийн тухай хуулийн өөрчлөлтөөр ЖСХ-ийн судалгааг оруулсан байна (2020).

#### **ХЭСЭГЧЛЭН ХЭРЭГЖСЭН**

Нэмэлт өөрчлөлтийн төслийг бэлдэж, УИХ-аар оруулсан. Өгөгдөл мэдээлэл цуглуулах асуудлыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Гэр бүлийн тухай хуульд оруулав.

**ЗОРИЛТ 1.1.:** ЖСХ-ийн, ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол, суурь шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийн талаарх үндэсний хэмжээний судалгаа хийгдэж, үр дүнг тархаасан байна

1.1.1. Үндэсний хэмжээний судалгааны тайлан хэвлэгдсэн байна.

*Суурь үзүүлэлт:* Судалгааны тайлан байхгүй (2016)

*Хүрэх үр дүн:* Судалгааны үр дүнг хэвлэж, түгээсэн байна. (2018)

#### **БҮРЭН ХЭРЭГЖСЭН**

Үндэсний хэмжээний ЖСХ-ийн судалгааг 2018 онд нийтлэсэн бөгөөд үр дүнг нь практик сургалт болон мультимедиа контентээр дамжуулан олон нийтэд түгээсэн.

**ЗОРИЛТ 1.2.:** ЖСХ/ГБХ-ийн талаарх захиргааны мэдээллийн нэгдсэн сан бэхжиж, холбогдох бусад байгууллагуудын мэдээллийг нэгтгэсэн байна.

1.2.1. ЖСХ/ГБХ-ийн мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн байна.

*Суурь үзүүлэлт:* ЦЕГ дээр ГБХ-ийн тоо мэдээллийг бүртгэх сан (2016)

*Хүрэх үр дүн:* Мэдээллийн санг 21 аймаг, 9 дүүргийн цагдаагийн газартай холбож, хууль сахиулах болон нийгмийн салбаруудтай нэгтгэсэн байна (2018)

#### **БҮРЭН ХЭРЭГЖСЭН**

eGBV мэдээллийн санг Цагдаагийн Ерөнхий Газрын дэргэд байгуулсан ба ЖСХ-ийн Үйлчилгээний Мэдээллийн Санг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны дэргэд туршиж байна.



Судалгаанд 21 аймаг,  
9 дүүргийн нийт

**7860**

өрх хамрагдсан.

Судалгаанд

**7319**

эмэгтэйчүүд  
хамрагдсан

Судалгаанд



ажилласан жолооч

**300000** км  
зам туулсан



**120** Сургалтад  
хамрагдсан  
хүн

Ахлагч, ярилцлага  
авагчийн сургалт 21  
хоног үргэлжилсэн

**95** Үүнээс  
судалгаанд  
ажилласан

## МОНГОЛ ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТОО МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН НЬ

2017 оны эхээр Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо нэгэн зочид буудлын хурлын танхимд зуу гаруй эмэгтэй чуулсан юм. Тэд бол “Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлага”-ыг судлах судалгаанд оролцох уриалгыг хүлээн авч, Монгол орон даяар аялж, Үндэсний Статистикийн Хороонд (ҮСХ) тоо мэдээлэл цуглуулж өгөх ярилцлагын ажилтнаар ажиллахаар цугласан хүмүүс байлаа.

Уриалгын зар дээр ажлын гүйцэтгэх үүрэг, шинж чанарын талаар маш бага мэдээлэл оруулсан байсан ч, ҮСХ-оос охид, эмэгтэйчүүдийн амьдралдаа туулж байж магадгүй янз бүрийн хэлбэрийн хүчирхийллийн талаар анхааралтай бөгөөд чин сэтгэлээсээ асууж ярилцаж чадах эмэгтэйчүүдийг хайж байсан юм.

Зарын дагуу хүрэлцэн ирж хуралд суусан эмэгтэйчүүдийн нэг болох Лхагважав (тэрээр ихэнх Монголчуудын нэгэн адил зөвхөн өөрийн нэрийг хэлсэн юм), “Байдаг л нэг судалгаа гэж бодсон. Төрөөс судалгааны ярилцлага авах ажлын зар үе үе тавьж байдаг. Гэхдээ энэ судалгааны сургалтад сууж эхлэх мөчид огт өөр, маш чухал ажил гэдгийг нь ойлгосон” гэж ярьсан юм.

Лхагважав ийнхүү бусад эмэгтэйчүүдийн хамтаар үндэсний болон олон улсын мэргэжилтнүүдийн явуулсан сургалтад сууж, Монгол дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх үндэсний хэмжээний анхны судалгаанд мордохоор болсон юм. Эмэгтэйчүүд

маань Монголын өргөн уудам, ихэнхдээ бартаа саадтай байдаг нутаг дэвсгэрээр нийт 350 мянган километр аялах байлаа. Судалгааны аялал маань оролцогч эмэгтэйчүүдэд ч гэсэн их өөрчлөлтийг авчрахаас гадна Монгол улсад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг шийдүүлэхээр засгийн газрыг уйгагүй лоббидож ирсэн үйл хэрэг амжилтад хүрсний 20 жилийн ойг тохиолдуулсан үйл явдал байлаа.

Судалгааны мэдээлэл цуглуулагч нар Улаанбаатар хотод 21 хоногийн эрчимжүүлсэн сургалтад суув. Уг гурван долоо хоногийн сургалтаар жендэр болон жендэрт суурилсан хүчирхийллийн (ЖСХ) талаар, мөн ёс зүйн болон хувийн нууцын асуудлуудын талаар чухал мэдээллүүд өгсөн юм. Мөн эмэгтэйчүүдэд өөрсдөд нь, судалгаа өгөх хүмүүст нь ч нээлттэй байдаг дэмжлэг болон үйлчилгээний эх сурвалжийн талаар мэдээлэл өгсөн. Учир нь эмэгтэйчүүдийн багагүй хувь анх удаагаа эсвэл олон дахин туулсан сэтгэлийн гэмтлээ ярьснаар асуудал нь сэдэрх эрсдэлтэй байдаг байна.

Судалгааны ажилтнуудыг эмэгтэйчүүдээс хэрхэн мэдрэмжтэй, үр дүнтэй байдлаар ярилцлага авахад сургасан бөгөөд судалгаа өгөх хүмүүсийн хамгийн гүний нууцуудыг яриулах нь тэдний ур чадвараас шууд хамаарахаар байлаа. Энэхүү судалгааны амжилт нь аль болох хамгийн үнэн зөв мэдээллийг цуглуулахаас хамаарч байв.

Талбар дээрх ажлыг Улаанбаатар хотын зах хэсгээс эхэлсэн бөгөөд эмэгтэйчүүд жижиг багуудад хуваагдаж ажиллав. Ажилтайгаа танилцаж, хувийн шинжтэй болон сэтгэл хөдлөлтэй хариултууд

ихэвчлэн ирдэг гэдгийг мэдсэнийх нь дараа шинээр сургагдсан мэдээлэл цуглуулагчдыг Монгол улсын 331 суманд хуваарилж, ҮСХ-ноос багуудад санамсаргүй түүврийн аргаар хуваарилж өгсөн эмэгтэйчүүдийг олж уулзаж, ярилцлага авах ажлын даалгаврыг өгсөн юм. Ийнхүү судалгааны багийнхан нийтдээ 7,319 эмэгтэйгээс ярилцлага авсан билээ.

Судалгааны талбараас тоо мэдээлэл цуглуулах ажлыг өгөгдөл мэдээлэл цуглуулах таблет ашиглан 2017 оны 5-6 сард дуусгасан. Энэ нь өгөгдөл мэдээллийг үнэн зөв оруулж, өдөр тутам Улаанбаатар дахь ҮСХ-нд илгээх боломжтой болгосон юм.

Монгол шиг өргөн уудам оронд ҮСХ нь олон бэрхшээлтэй тулгардаг. Судалгааг зуны саруудад авсан боловч цаг агаарын урьдчилан таамаглашгүй үзэгдлүүд судалгаанд саад учруулсаар байв. Судалгааны багууд Монголын үзэсгэлэнтэй боловч бартаа саад ихтэй газар нутгийг туулж байв. Цас, элсэн шуурга, манан будан байгалийн үзэгдэлүүд зохион байгуулалтын хувьд багагүй бэрхшээл учруулж байлаа.


Цаг агаар болон зам харгуйн бэрхшээл нь мэдээлэл цуглуулагчдад ихээхэн хүндрэл учруулж, судалгааны газраа хүрэхийн тулд тойруу замаар явахад хүргэх нь элбэг байв. Мэдээлэл цуглуулагчдын нэг нь, “Нэг орой манай машин шаварт суугаад би мотоциклтой хүнд дайгдаж явахаар болсон.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийллийн хэлбэрээр, дүнд эзлэх хувиар



### Бие махбодын хүчирхийллийн үйлдлүүд



Бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бэртэл, гэмтэл авсан байдал, хувиар



— Сүүлийн 12 сар — Амьдралдаа

Судалгааны газраа очиход цааш явах замгүй болоод би уул давж алхсан. Айлдаа очих үед шөнө дөл болсон байсан учраас бүгд унтаж байлаа. Тэгээд би судалгаа өгөх эмэгтэйгээ сэрээж судалгаа авахаас өөр аргагүй болсон” гэж ярьсан юм.

Судалгаагаар эмэгтэйчүүдээс бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн болон эдийн засгийн гээд хүчирхийллийн олон хэлбэрийн талаар асуусан юм. ҮСХ-ноос өмнө нь ЖСХ-тэй холбогдох хувийн, нарийн мэдээлэл цуглуулах ийм нарийвчилсан судалгаа хийж байгаагүй билээ. Ийм учраас энэ төрлийн судалгаан дээр ажиллаж байсан туршлагатай олон улсын мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч ажилласан юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн (НҮБХАС) kNOwVAWdata санаачилгын арга зүйн дэмжлэгтэйгээр түншлэл байгуулж ажилласан бөгөөд Австралийн олон улсын хөгжлийн агентлагаас санхүүжүүлсэн kNOwVAWdata төсөл нь Ази, Номхон Далайн орнуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тархалтыг хэмжихэд нь дэмжлэг үзүүлж, чадавхийг нь бэхжүүлэх төсөл юм.

Монгол улсад гэр бүлийн хэлхээ холбоо ойр байдаг учраас олон эмэгтэй ойр, холын төрөл садантайгаа ойр амьдардаг. Гэвч гэр бүлийн энэхүү ойр харилцаа нь төрөл садан, хадам аав ээж нарын зүгээс ирэх хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй эмэгтэйчүүдэд хүнд

дарамт учруулах магадлалтай. Ахимаг насны эмэгтэйчүүдийн хувьд хүүхдүүд болон хүүхдүүдийнх нь хань ижил хүчирхийлэлд өртөх эрсдэл үүсдэг.

Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ нь мөн хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйл болж болно. Өөрөөр хэлбэл хямдхан олддог архи нь эл асуудлыг дэвэргэж болно. Монгол улсад архинаас хамааралтай хүний тоо нийт хүн амтай харьцуулахад өндөр гардаг. Үүний шалтгаан нь сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд олон үйлдвэр хаагдаж, ажлын байраа алдсан хүний тоо нэмэгдсэнээр ажилгүйдэл, ядуурал газар авсан явдал юм. Монгол улс нэгэн цагт төвлөрсөн засгийн газартай социалист улс байсны хувьд өмнө нь социалист байсан бусад улсуудтай адил төрлийн асуудал ихтэй байдаг. Тогтвортой ажиллаж чадаагүй үйлдвэрүүд хаагдаж, төрийн дэмжлэг байхгүй болж, хоршоололд түшиглэсэн хөдөө аж ахуй зогссоны дүнд ажил хайсан хүмүүс том хотуудруу нүүх болж, хотжилт түргэссэн юм.

## МОНГОЛЫН НУТАГ НУТГИЙН ИРГЭДЭД ХҮРЧ АЖИЛЛАСАН НЬ

Улаанбаатар хотын захын дүүрэг болох Налайх дүүрэгт дээрх олон асуудал газар авсан байдаг. Эл дүүрэг нь 37,000 хүн амтай ядуу дүүрэг бөгөөд сүүлийн 30 жилийн хугацаанд нийслэл хотруу нүүн одсон 600,000 гаруй малчин иргэдийн төрөлх дүүрэг юм.



Тус дүүрэгт социализмын үеийн орон сууцнууд Монголын уламжлалт сууц болох гэртэй хаяа залган оршдог. Гэр нь өвлийн цагт -50 хэм, зуны цагт +50 хэм хүрдэг эрс тэрс уур амьсгалаас хамгаалж чаддаг өвөрмөц сууц.

Хуучны, орхигдсон нүүрсний уурхайн олборлогдоогүй үлдсэн, аюултай судлыг даган ухаж, өвлийн хүйтэн саруудад өрх айлууд түлж, хотыг өтгөн хар утаагаар хучиж орхидог түүхий нүүрсийг “нинжа уурхайчид” олборлодог.

Монголын алс баруун зүгт голчлон нүүдэллэн амьдардаг байсан амьдралаа орхиж шилжин ирсэн казак хүмүүс Налайх дүүрэгт олноороо оршин суух болсон.

Казакууд бол Монголын хамгийн том үндэстний цөөнх. Энэхүү олон бүрэлдэхүүнт хүн амын бүтэц нь ҮСХ-нд нэмэлт бэрхшээл учруулдаг. Өөрөөр хэлбэл үндэсний хэмжээний судалгаанд эмэгтэйчүүдийг бүрэн хамруулж, нийгмийн бүх бүлгийг хэрхэн төлөөлүүлэх вэ гэдэг асуудал ярвигтай болж ирдэг.

Монголын казакчуудын дийлэнх нь Орос, Хятад хоёртой хиллэж, Казакстантай хэдхэн километрийн зайд орших хамгийн баруун хязгаарт голчлон амьдарсан хэвээр байгаа юм.

Монголын алс баруун хязгаарт нүүдэлчин казакууд мал сүргээ өсгөж, хоёр хүчирхэг хөрштэйгөө худалдаа наймааны түүхэн замаар бараа бүтээгдэхүүн арилжин аж төрсөөр байна. Цаг уурын хатуу ширүүн нөхцөлийг ажрахгүйгээр амьдарч чадсан нэгэнд энэхүү амьдралын хэв маяг санхүүгийн хувьд их өгөөжтэй байдаг. Энэ нутгийн казакууд хотын казакуудаас илүү чинээлэг амьдрах талтай байдаг ч харьцангуй алслагдмал амьдардаг. Өөр ястантай гэрлэх нь ховор бөгөөд ойр холын төрөл садангаараа нэгдэн амьдарч, багагүй хувь нь зөвхөн казак хэлээрээ ярьдаг.

Казак иргэдийн дийлэнх олонх нь Исламын шашинтай. Том хотуудад шашны зан үйл илүү чөлөөтэй байдаг ч, алс баруун хязгаарт судалгаа авахын тулд шашны гүн сүсэг бишрэлийг нь сайн ойлгох нь манай судалгааны багийнхан болон судалгаа авагч нарт хэрэгтэй соёлын ойлголтын нэг байсан юм. Иймд казак мэдээлэл цуглуулагч нар соёлын болон шашны мэдлэг, түүнчлэн нутгийн хэлээр ярих ур чадвараар хангасан юм.

## ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨӨХ ЗҮТГЭЛ: ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ТӨВ

Даваасүрэнгийн Энхжаргал эмэгтэйчүүдийн хүчирхийллээс ангид амьдрах эрхийн төлөө 20 гаруй жил тэмцэж байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийг (ХЭҮТ) үүсгэн байгуулагч, хуульч мэргэжилтэй тэрээр байгууллагаараа дамжуулан хүүхэд,

эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэж, эмэгтэйчүүдийн эрхийг хуульчлан хамгаалах асуудлаар засгийн газарт нөлөөлөх ажил хийхийн зэрэгцээ Монгол орон даяар хүчирхийлэл, бэлгийн дарамтаас зугтаж буй хүүхэд, эмэгтэйчүүдэд шууд үйлчилгээ үзүүлж ажилладаг. ХЭҮТ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2016 онд шинэчлэн батлуулах ажилд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Төрөөс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхэд хүчин чармайлт гаргаж эхэлсэн явдлыг Энхжаргал найдлага тавин харж сууна. 2016 онд шинэчлэн баталсан хуулиар гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцсон бөгөөд үндэсний хэмжээний хүчирхийллийн судалгаа одоогоор эхлээд байна. Хүчирхийллийн талаарх олон нийтийн ойлголт мөн өөрчлөгдөж байна. Үүнд эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг хүчирхийлж, амь насыг хохироосон онц ноцтой хэргүүдийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр их шуугиж, олон нийтийг хамарсан уур бухимдал үүссэн нь түлхэц болсон юм.

Хүчирхийллийн талаарх үндэсний судалгаагаар цуглуулсан тоо мэдээлэл нь үйлчилгээг хамгийн хэрэгцээт хүмүүст чиглүүлэхэд хэрэгтэй чухал мэдээллээр хангана гэж Энхжаргал итгэж байна. Тэрээр хэлэхдээ, “Бид залуус, хотын болон хөдөөгийн хүмүүс, мөн нүүдэлчид зэрэг нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг бодолцож үзэх хэрэгтэй. Тэдний хэрэгцээ чухам юунд байна? Бидэнд энэ талаар мэдээлэл хэрэгтэй. Учир нь Монголд янз бүрийн амьдралын

нөхцөлтэй, янз бүрийн соёл уламжлалтай хүмүүс амьдарч байна” гэсэн юм.

Гэвч энэ ажлыг Энхжаргал багийнхантайгаа төрөөс ямар нэгэн санхүүгийн дэмжлэг авахгүйгээр хийж ирсэн юм. Тэдний ажлыг олон улсын байгууллагууд, гадны элчин сайдын яамдууд болон НҮБХАС санхүүжүүлдэг. “ХЭҮТ-ийн мөрөөдөл бол төр энэ бүх ажлыг гардан авч, иргэддээ амин чухал хэрэгтэй байгаа эдгээр үйлчилгээг үзүүлж эхлэх явдал” гэж Энхжаргал хэлсэн юм.


## УЯЛДААТАЙ АРГА ХЭМЖЭЭ: МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо (ҮСХ) бол Монгол орон даяар судалгаа, мэдээлэл цуглуулах туршлагатай байгууллага. Гэвч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгааг явуулахад шинэ сорилтууд тулгарсан юм.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг судлах анхны үндэсний хэмжээний судалгаанд ҮСХ тоо мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ

## БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛ

Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлгээр



7 эмэгтэй тутмын 1 нь амьдралдаа / багадаа нэг удаа/ бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байхад сүүлийн 12 сард 2.6 % нь өртсөн байна.

15 наснаас өмнө  
10 эмэгтэй тутмын 1  
Хүүхэд байхдаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна.



Хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 10.2% хүчирхийллийн талаар цагдаад мэдэгдсэн байна.



хийх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлал буюу Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын аргачлалыг ашигласан юм. Уг аргачлал нь бүтэцлэгдсэн асуумжаас бүрдэх тоон судалгаа, мөн фокус бүлгийн хэлэлцүүлэг, бусад оролцогч талуудтай хийх нарийвчилсан ярилцлага зэрэг чанарын бүрэлдэхүүнээс бүрддэг. Судалгааны чанарын бүрэлдэхүүн нь эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ЛГБТ хүмүүсээс мэдээлэл цуглуулсан бөгөөд бодлого төлөвлөлтийг сайжруулж, нөөцийг илүү үр дүнтэй хуваарилахад туслах нарийвчилсан мэдээлэл олж авахаар зорьсон юм.

ҮСХ-ны дарга Аюушийн Ариунзаяа тайлбарлахдаа, «Бидэнд энэ судалгааг бие дааж хийх туршлага байгаагүй. Тиймээс бид НҮБХАС-аас арга зүйн дэмжлэг хүссэн бөгөөд Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА) биднийг санхүүгээр дэмжсэн» гэсэн юм.


Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үндэсний хэмжээний судалгаа шиг өргөн цар хүрээтэй, мэдрэмтгий асуудлыг хөндсөн төслийг хэрэгжүүлэхэд засгийн газрын агентлагууд, гадны донор байгууллагууд зэрэг олон түнш байгууллагын хамтын зүтгэл, уялдаатай ажиллагаа, мөн арга зүйн дэмжлэг шаардагдана.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын аргачлалыг ашиглан НҮБХАС kNOwVAWdata төслийн турш арга зүйн дэмжлэгээр хангаж ажилласан бөгөөд Австралийн Гадаад хэрэг, худалдааны яамнаас (DFAT) санхүүжилтээр хангасан. Мөн Монгол улсад хийсэн судалгаанд Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА) санхүүгийн амин чухал дэмжлэг үзүүлсэн билээ.


Монгол улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгааны дүн 2018 онд нийтлэгдсэн билээ.

*Энэхүү нийтлэлийг Ази, Номхон Далайн НҮБХАС болон kNOwVAWdata-д зориулж Anneliese McAuliffe бичив.*


## ХҮЧИРХИЙЛЛИЙГ ДАВАН ТУУЛЖ БУЙ БАЙДАЛ: Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд тусалсан байдал




Найз, нөхөд




Эцэг, эх



Ах, эгч



Хадам, түүний  
хамаатнууд



Хэн ч туслаагүй



## ҮР ДҮН

---

# 2

---

Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийт болон шийдвэр гаргагчдын ойлголт нэмэгдэж, ЖСХ/ГБХ-ийг таслан зогсоох үйл ажиллагаа эрчимжив.





Үндэсний хэмжээний ЖСХ-ийн судалгаа нь Монгол улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдал, тархалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэсэн бөгөөд шинэчлэн баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (ГБХТТХ) нь энэхүү ноцтой асуудлыг салбар хоорондын олон талт хамтын ажиллагааны үр дүнд шийдвэрлэх боломжийг олгосон. Харин одоо Монгол улсад ЖСХ-ийн талаарх ойлголтыг өргөн хүрээнд дээшлүүлж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр илүү их ажиллах шаардлага байна. Ийм учраас ухуулга нөлөөлөл, сурталчилгааг эрчимжүүлэх, олон нийт төдийгүй шийдвэр гаргагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх замаар ЖСХ нь гэмт хэрэг төдийгүй хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд түүний суурь шалтгаан нь болсон уламжлалт сэтгэлгээ, хэвшмэл хандлага, итгэл үнэмшлийг нийгэм даяар өөрчилж байж л бүрэн шийдэх боломжтой олон талт ярвигтай асуудал гэдгийг ойлгуулах нь чухал болсон.

Олон нийтийн болон шийдвэр гаргагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх мэдээлэл, сурталчилгааны өргөн хүрээтэй үйл ажиллагаа болон бусад салбар хоорондын олон талт үйл ажиллагааг зохицуулах болон хохирогч хамгааллын тогтолцоог бий болгох, ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үндэсний чадавхийг бэхжүүлэх хүчин чармайлтуудын үр дүнд улсын болон орон нутгийн

төсвөөс энэ чиглэлд зарцуулах хөрөнгийн хэмжээ өмнөх үетэй харьцуулбал мэдэгдэхүйц өссөн.

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

### 1 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

2016 оны 5-р сард анхлан батлагдсаныхаа дараахан 9-р сард нь УИХ-аас хүчингүй болгосон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн (ГБХТТХ) шинэчилсэн найруулгыг эцэстээ 2016 оны 12-р сард дахин баталж, 2017 оны 2-р сараас хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хуулийг батлуулахад өнгөрсөн хорь гаруй жилийн туршид тасралтгүй өрнөсөн олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх болон шийдвэр гаргагчдын дэмжлэгийг дээшлүүлэх, үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх өргөн хүрээтэй олон хэлбэрийн үйл ажиллагаа, оролцогч талуудын хамтын хүчин чармайлтууд нөлөөлсөн билээ. ГБХТТХ-аар ГБХ-ийг гэмт хэрэгт тооцож, даван туулагчийг хамгаалах механизмийг бий болгоход төрийн гүйцэтгэх үүрэг болон хүчирхийлэл үйлдэгчдэд оноох хуулийн арга хэмжээг тодорхойлсон нь үр дүнтэй урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах маш чухал алхам болсон. Энэ нь мөн ГБХ-ийн үйлдэлд ял шийтгэл хүлээдэггүй байсан хуучин байдлыг халахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Учир нь ГБХ-ийн үйлдлийг гэмт хэрэгт тооцон

ял шийтгэл оноох болсноор хүчирхийлэгч аливаа хүчирхийлэл үйлдэхээсээ өмнө үр дагаврыг нь бодон хүчирхийлэл үйлдэхээс татгалзах боломжтой болсон.

Түүнчлэн, ЖСХ-тэй тэмцэх төслийн хүрээнд нийт 31 журам, үйлчилгээний 3 стандарт, 12 зөвлөмж болон гарын авлага боловсруулж, батлуулсан нь салбарын яамдууд болон агентлагуудад ГБХТТХ-ийг хэрэгжүүлэх арга зүйн удирдамж болсон.

## 2 ТӨГСӨЛТИЙН ӨМНӨХ СУРГАЛТ

ЖСХ-ийн модулийг мэргэжилтэн бэлтгэх сургуулиуд болох Хууль сахиулахын их сургууль, МУИС-ийн Нийгмийн ажил болон Сэтгүүл зүйн тэнхим, АШУҮИС-ийн сургалтын хөтөлбөрүүдэд оруулсан. Ингэснээр тухайн мэргэжлээр их дээд сургууль төгсөн гарч байгаа хүмүүс ЖСХ болон жендэрийн асуудлаар ойлголт мэдлэгтэй болж төгсөх бөгөөд мэргэжилтний хувьд холбогдох хууль дүрэм, үйлчилгээний ур чадвар арга зүйд суралцах боломжоор хангагдах юм.

## 3 ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ КАМПАНИТ АЖЛУУД

ЖСХ-ийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж, хандлагыг өөрчлөх зорилгоор олон хэлбэрийн үйл ажиллагааг сүүлийн жилүүдэд нилээд зохион байгуулах болсон ч өөр өөр

messeжийг олон нийтэд хүргэх нь зарим тохиолдолд олон нийтийг төөрөлдүүлэх эрсдэлтэй байгааг харгалзан ЖСХ-тэй тэмцэх төслийн Удирдах хорооны дэргэд төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын ухуулга нөлөөллийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс бүрдсэн Хэвлэл мэдээллийн дэд хороог байгуулсан. Энэхүү дэд хорооны зорилго нь ухуулга нөлөөллийн үйл ажиллагааны нэгдсэн messeжийг хамтран боловсруулж, бүхий л төрлийн нөлөөллийн ажилдаа ашиглах, олон нийтэд зориулсан аянуудыг хамтран төлөвлөж, төслийн мэдээлэл сурталчилгааны стратегийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх явдал байсан.

Үүний дүнд, сүүлийн жилүүдэд олон нийтийг хамарсан жендэр, жендэрийн тэгш байдал, ЖСХ-ийн талаарх үнэн зөв мэдлэг мэдээллийг олгох, хэвшмэл ойлголтыг арилгах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх эерэг хандлагыг бий болгоход чиглэсэн хэд хэдэн аяныг дээрх дэд хорооны удирдлага доор хамтран зохион байгуулсан нь үр дүнд хүрсэн. 2016, 2017 онуудад зохион байгуулсан ухуулга нөлөөллийн үйл ажиллагаанд зонхилж байсан ЖСХ/ГБХ-ийн хор хөнөөл, үр дагаврыг ойлгуулах “олон нийтийн анхаарлыг хандуулах стратеги” буюу “shok factor strategy”-ыг 2018, 2019 онуудад өөрчлөн ЖСХ/ГБХ нь гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчил, маш олон хэлбэрийн сөрөг үр дагаварыг дагуулдаг үзэгдэл юм бол түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход хувь хүн өөрийн зүгээс юу хийх шаардлагатай болохыг сануулах, эерэг харилцаа, хандлага, үйлдлийг дэмжих “эерэг” стратегийг аяны үйл ажиллагаанд баримтлан messeжийг боловсруулан олон сувгаар өргөн хүрээнд

түгээсэн нь олон нийтийн таашаалд нийцсэн үйл ажиллагаа болсон. Тухайлбал 2018 онд “ЭерэгболГОЁ” аяны хүрээнд жендэрийн талаарх ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА, ҮЙЛДЛИЙГ эерэг болгосноор хүчирхийллээс зайлсхийх боломжтой гэдэг мессежийг олон нийтэд хүргэхийг зорьсон. Дараа нь 2019 оны аяныг “ОйлГОЁ ХҮНдэлье” уриан доор өрнүүлж, 2020 оны Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр “Хайр Өвтгөдөггүй” аяныг тус тус зохион байгуулсан. Олон нийтэд чиглэсэн эдгээр аяныг зохион байгуулахад ЖСХ-тэй тэмцэх төслийн дэргэдэх Хэвлэл мэдээллийн дэд хорооны удирдлага доор бүх хэрэгжүүлэгч талууд оролцсон бөгөөд олон нийтэд чиглэсэн хэд хэдэн аяныг амжилттай зохион байгуулсан Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэс манлайлан ажилласан.

Үүний үр дүнд давхардсан тоогоор 15.7 сая хүнд хүрч, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох эерэг мессежүүдийг хүргэсэн. Олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх эдгээр хүчин чармайлтууд болон төслийн хүрээнд бий болсон бусад тогтолцоо, чадавхийн үр дүнд ГБХ-ийн гэмт хэргийн бүртгэгдсэн тохиолдол 32.1%-иар буурсан бөгөөд ГБХ-ийн зөрчлийн бүртгэгдсэн тохиолдол гурав дахин өссөн. Энэ үр дүн нь ГБХ-ийг хувийн асуудал гэхээсээ илүүтэй тэвчиж үл болох хүний эрхийн зөрчил гэсэн олон нийтийн ойлголт нэмэгдэж, мэдээлэх явдал ихэссэнээр хүчирхийллийг гэмт хэрэг болохоос өмнө эрт илрүүлж таслан зогсоож байгааг харуулж байна.

Түүнчлэн хүмүүсийн сэтгэлгээ, оюун санааг жендэрийн тэгш эрхийг дэмжих хандлагатай болгон өөрчлөх ажлыг бага наснаас нь эхлэх хэрэгтэй гэж үзсэний үндсэн дээр жендэр болон ЖСХ-ийн модулийг багтаасан Бэлгийн цогц боловсролын (БЦБ) хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт оруулсан нь чухал амжилт болсон. Мөн БЦБ-ын хичээл бүхий видео хичээлийг бүтээж, КОВИД-19-ийн хөл хорионы үед теле-хичээл болгон үндэсний телевизээр цацахад төслийн зүгээс мэргэжлийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

## 4 ИРГЭНИЙ НИЙГЭМ БОЛОН ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ТҮНШИЛСЭН НЬ

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн болон хэвлэл, мэдээллийн байгууллагууд, Засгийн газрын төдийгүй орон нутгийн удирдлагыг чадавхжуулахын зэрэгцээ тэдний үүсгэл санаачилгыг дэмжих зорилгоор төслийн зүгээс санхүүгийн болон мэргэжлийн дэмжлэг үзүүлэн ажилласан. Тухайлбал, Хөөрхөн Зүрх ТББ-тай хамтран шинэлэг санаачилгаар дамжуулан залуу хүмүүст мэдээлэл хүргэн тэдний оролцоог нь хангах төслийг; Нийгмийн ажлын хөгжлийн төвтэй хамтран эрэгтэйчүүд, ялангуяа аавуудыг оролцуулан эцэг эх, хүүхдүүд хоорондын эрүүл харилцааг дэмжих замаар ЖСХ-ийг таслан зогсооход хувь нэмрээ оруулах төслийг; Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлийг сайжруулан өөрчлөх замаар сэргээн засах төслийг;

Хүйсийн тэгш эрхийн төвтэй хамтран сургуулийн хүүхдүүд болон сургуулийн нийгмийн ажилтнуудад ЖСХ-ийн асуудлаар боловсрол олгох төслийг; Сайн тус ТББ-тай хамтран орон нутгийн иргэдэд ЖСХ/ГБХ-ийн хор уршиг, үр дагавар, урьдчилан сэргийлэх арга замын талаарх төслийг тус тус хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлснээр тодорхой зорилтот бүлгүүдэд хүрч ажиллах болон ТББ-уудын энэ зорилтот бүлгүүдтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах чадавхийг бэхжүүлэхэд чухал хувь нэмрээ оруулсан. Түүнчлэн, Засгийн газрын мэдээ өдөр тутмын сонин, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монгол контент ХХК-тай хамтран ЖСХ/ГБХ-ийн асуудлаар олон нийтэд хандсан мэдээллийн контент бүтээх замаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлснээр ийм хэлбэрийн эмзэг асуудлуудыг олон нийтэд хэрхэн хүргэх арга зүйг эзэмшихэд хэвлэл мэдээллийн байгууллагуудад дэмжлэг үзүүлсэн. Мөн Монголын хэвлэлийн хүрээлэнтэй хамтран ажиллаж, ЖСХ болон жендэрийн асуудлыг уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн мэдээлж байгаад үнэлгээ, хяналт-шинжилгээ хийж, цаашлаад сэтгүүлчдийг ийм төрлийн мэдээ, мэдээллийг мэдрэмжтэй байдлаар мэдээлэхэд сургах сургалт зохион байгуулах, сэтгүүлчдийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан.



## ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

### ҮР ДҮН

**ҮР ДҮН 2:** Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийт болон шийдвэр гаргагчдын ойлголт нэмэгдэж, ЖСХ/ГБХ-ийг таслан зогсоох үйл ажиллагаа эрчимжинэ.

2.1. ГБХТТХ-ийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар батлуулсан байна.

*Суурь үзүүлэлт:* ГБХТТХ-ийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас буцаав (2016 оны 9-р сар)

*Хүрэх үр дүн:* ГБХТТХ-ийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар батлуулсан байна. (2020)

#### БҮРЭН ХЭРЭГЖСЭН

ГБХТТХ 2016 оны 12-р сард батлагдаж, 2017 оны 2-р сараас хэрэгжиж эхэлсэн.

2.2. ГБХТТХ-ийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмуудыг боловсруулж, хэрэгжүүлнэ.

*Суурь үзүүлэлт:* 0 (2016)

*Хүрэх үр дүн:* 3 (2019)

#### БҮРЭН ХЭРЭГЖСЭН

31 журмыг боловсруулж, батлуулан хэрэгжүүлж байна.

2.3. ЖСХ-ийн бүртгэгдсэн тохиолдол өснө.

*Суурь үзүүлэлт:* 1,713 (2016)

*Хүрэх үр дүн:* 2,055 буюу 20% өссөн байна (2020)

#### БҮРЭН ХЭРЭГЖСЭН

2019 онд нийт 9,947 тохиолдол бүртгэгдэв. (985 гэмт хэрэг + 8,962 зөрчил)

**ЗОРИЛТ 2.1.:** ЖСХ, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл, түүний үр дагаврын талаар олон нийтийн мэдлэг ойлголт нэмэгдсэн байна.

2.1.1. Хамтарсан баг болон иргэний нийгмийн оролцоотойгоор олон нийтийн болон дэмжих бүлгүүдийн тоо.

*Суурь үзүүлэлт:* 3 (2016)

*Хүрэх үр дүн:* 7 (2019)

#### БҮРЭН ХЭРЭГЖСЭН

7 ТББ болон хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай нийт 11 жижиг төсөл хэрэгжүүлэв.

**ЗОРИЛТ 2.2.:** ЖСХ, ялангуяа ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хууль эрх зүйн орчинг бий болгоход шийдвэр гаргагчдын дэмжлэг нэмэгдсэн байна.

2.2.1.1. ГБХТТХ болон бусад холбогдох хуулиудыг хэрэгжүүлэх журмуудыг боловсруулсан байна.

*Суурь үзүүлэлт:* 0 (2016)

*Хүрэх үр дүн:* 6 (2020)

#### БҮРЭН ХЭРЭГЖСЭН

ГБХТТХ-ийг хэрэгжүүлэх 31 журамыг боловсруулан, батлуулсан.



## ХӨӨРХӨН ЗҮРХ ТББ

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ (ЖСХ) ШИГ НАРИЙН ТӨВӨГТЭЙ, УЖГИРСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД УЛС ОРОН ДАЯАРАА ХАМТРАН ХИЧЭЭХ ШААРДЛАГАТАЙ.


Энэ л зарчмыг Монгол улсад ЖСХ-тэй тэмцэх нь төслийн төлөвлөлт хийгээд хэрэгжилтийн туршид баримталж ажилласан юм. Төслийн үндсэн зорилго болох ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үндэсний чадавхийг бэхжүүлэхийн тулд дан ганц засгийн газар болон орон нутгийн засаг захиргааг оролцуулах нь хангалтгүй бөгөөд иргэний нийгэм, хувийн хэвшил болон олон нийтийг мөн оролцуулах шаардлагатай. Ийм учраас ЖСХ-тэй тэмцэх нь төслийн хүрээнд төрийн бус байгууллагуудыг (ТББ) оролцуулж, ЖСХ-тэй тэмцэх чадавхийг нь нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүчирхийллээс ангид нийгмийг бий болгохын тулд тэдний мэдлэг, туршлага дээр тулгуурлан хамтын ажиллагааг бэхжүүлсэн юм.

ЖСХ, ялангуяа бэлгийн хүчирхийллийн эсрэг залуусыг уриалж, оролцуулахад нэн чухал үүрэг гүйцэтгэсэн ТББ-уудын нэг бол Хөөрхөн Зүрх ТББ юм. Хөөрхөн Зүрх бол Монголд ЖСХ, ялангуяа хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл болон ГБХ-ийн бүх хэлбэрийг эцэслэхийн төлөө 2012 оноос хойш ажиллаж буй эмэгтэйчүүдээр удирдуулсан ТББ билээ. Тэдний үйл ажиллагаа 4 цөм хөтөлбөрөөс бүрддэг. Тэдгээр нь: (1) жендэрийн эрх тэгш бодлого, эрх зүйн орчныг бий болгоход нөлөөлөх; (2) үйлчилгээ үзүүлэх, ялангуяа

эмэгтэйчүүд, хүүхдүүд болон залуу хүмүүсийн бэрхшээлийг даван туулах чадварыг хөгжүүлэх, ЖСХ-д өртсөн сэтгэл зүйн гэмтлээ даван туулах, илааршихад нь туслах нийгэм-сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх; (3) ЖСХ болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлд олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх; мөн (4) ЖСХ-д өртсөн залуу даван туулагчидтай ажилладаг мэргэжилтнүүдийн ойлголт, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх юм.

ЖСХ-тэй тэмцэх нь төслийн хүрээнд Хөөрхөн Зүрхнүүдээс «Гинжийг тасал» аяныг хоёр удаа зохион байгуулсан юм. Эхний аяныг ГБХТТХ-ийн шинэчилсэн найруулгыг таниулах зорилгоор 2017 онд хийсэн ухуулга сурталчилгааны аяны хүрээнд хийж байсан бол энэ амжилтдаа тулгуурлан хоёр дахь аянаа 2019 онд олон нийтийн анхаарлыг ЖСХ-рүү дахин нэг чиглүүлэх зорилгоор эхлүүлсэн билээ. Art therapy буюу урлагаар дамжуулан нөлөөлөх арга барилыг ашигласнаар Хөөрхөн Зүрхнүүд цуврал подкаст, телевизийн ток шоу, стэнд-ап комеди болон зурагт ном, онлайн хэлэлцүүлэг, гар зургийн үзэсгэлэн зэрэг үйл ажиллагаануудаараа 1.3 сая гаруй хүнд хүрч чадсан байна.

# ГИНЖИЙГ ТАСАЛ



Хөөрхөн Зүрхнүүд ТББ-ын Тэргүүн А.Хонгорзул хэлэхдээ, “Урлаг бол олон нийтэд хүрч, ГБХ-ийн уг шалтгаан болоод үйлдэгддэг хэлбэрүүдийн талаар, мөн түүнийг олон үндэстэн, ястан амьдардаг Монгол улсад таслан зогсоох цогц сорилтын талаар мэдээлэл өгөх маш сайн хэрэгсэл юм. Урлаг нь хэлэлцүүлэг өрнүүлэх үүд хаалга болдог бөгөөд уг хаалгаар Монгол улс дахь жендэрийн хөгжил болон жендэрийн шударга ёсны үйл явцын нэг хэсэг болохыг хүссэн хэн бүхэн чөлөөтэй нэвтрэх боломжтой байдаг” гэсэн юм.

“Гинжийг тасал” аянд залуучууд асар идэвхтэй оролцсон юм. Подкастуудыг бэлтгэхэд залуус сайн дурын үндсэн дээр оролцсон бөгөөд гар зургийн үзэсгэлэнг гаргахад сургуулийн бүх насны хүүхдүүд оролцож, ЖСХ-ийн асуудлаар өөрсдийн ойлголтыг илэрхийлж, түүнийг шийдвэрлэх талаар үзэл бодлоо дэлгэн харуулсан байна. Хөөрхөн Зүрхнүүд мөн кампанит ажлууддаа хот, хөдөөгийн оршин суугчид, мөн нас, үндэс, нийгмийн байдлыг харгалзалгүй бүхий л давхаргын хүмүүсийг хамруулж, хүрч ажилласан бөгөөд нийгмийн янз бүрийн давхаргын хүмүүсийн амьдралыг тусгасан, тэдэнд хүрч чадахуйц түүхийг хуваалцаж, мөн хүн ам зүйн янз бүрийн бүлэгт хүрэх олон хэлбэрийн сувгуудыг ашиглаж ажилласан нь үр дүнд хүрэхэд нөлөөлсөн.



Энэхүү аяны дүнд Хөөрхөн Зүрхнүүд ТББ-аас ЖСХ-ийн улмаас тусламж дэмжлэг, үйлчилгээ хүсэж ирсэн эмэгтэйчүүд болон хүүхдүүдийн тоо 20%-иар өссөн байна. Аянаараа дамжуулан олж авсан амжилт, олон нийтэд танигдсан байдал нь уг төрийн бус байгууллагад сайн дураар ажиллах хүмүүсийн тоо өсөхөд нөлөөлснөөр, жилд 300-400 сайн дурын ажилтантай хамтран ажилладаг болжээ. Тэдний дунд ирээдүйд нийгмийн ажилтан, хуульч, сэтгэл зүйч болох зорилготой оюутан залуус олон байжээ. Сайн дурынхны зарим нь “Гинжийг тасал” аяны хүрээнд сургалтад хамрагдаж, Хөөрхөн Зүрхнүүд ТББ-ын тэргүүн фронтын, бүтэн цагийн ажилтан болсон бөгөөд нэг нь бүр НҮБ-ын Залуучуудын Зөвлөлдөх Хороонд төлөөллөөр сонгогдсон байна.

Өнөөдрийн байдлаар Хөөрхөн Зүрхнүүд ЖСХ-тэй тэмцэх нь төслийн хүрээнд эхлүүлсэн ажлаа өргөжүүлэхээр ажиллаж байна. Сурталчилгааны аяныг өрнүүлэх явцдаа хуримтлуулсан туршлага, сургамж, олонд танигдсан байдал дээрээ үндэслэн тэд нөлөөллийн ажил болон үйлчилгээгээ үндэсний хэмжээнд өргөжүүлэх боломжтой болжээ. Тэд мөн ЖСХ-д хариу арга хэмжээ авах, түүнээс урьдчилан сэргийлэхэд урлагийн сэтгэл заслын аргачлалыг ашигласаар байгаа бөгөөд бүр олон сэтгэл зүйч, нийгмийн ажилтан,

хүүхдийн эрхийн мэргэжилтнүүдийг хамруулж, ажилд нь урлагийн сэтгэл заслын арга барилыг нэвтрүүлсээр байна. Мөн өөр олон байгууллага Хөөрхөн Зүрхнүүдтэй холбогдож, сурталчилгааны аяныг амжилттай явуулсан сайн туршлагаас нь суралцаж байна. “Гинжийг тасал” аяны хүрээнд эхлүүлсэн цуврал подкаст нь амжилттай болсон тул подкастын багийнхан цаашдаа ГБХ болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголтыг дээшлүүлэхэд подкастаа үргэлжлүүлэн ашиглахаар болсон бөгөөд өдгөө онлайн талбарууд болон орон нутгийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан подкастаа цацсаар байна.

“Монголын ТББ-ууд жендэрийн тэгш байдлыг бий болгож, ЖСХ-ийг таслан зогсоохын төлөөх тэмцэлд 1990-ээд оноос хойш чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Тэд хүний эрхийг хамгаалах төрийн хариуцлагыг сануулж, нийгмийн хортой хэм хэмжээг таслан зогсоож, хүн нэг бүрд илүү таатай орчинг бүрдүүлэхийн төлөө ард иргэдтэй хамтран ажилласаар ирсэн юм. Ийм учраас бид ЖСХ-д цэг тавихын тулд дотоодын ТББ-уудаа, ялангуяа Монгол улсын онцлогт тохирсон арга барилаар хөрсөнд бууж ажилладаг (grassroots) байгууллагуудаа үргэлжлүүлэн чадавхжуулсаар байх хэрэгтэй” хэмээн Хонгорзул ярив.



## ХАЙР ӨВТГӨДӨГГҮЙ:

Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хэмжээний аян

2020 оны 3-р сараас эхлэн олон нийтийн цахим сүлжээнд нийгмийн бүх давхаргын иргэд хайрын түүх болон гэр бүлийн харилцааныхаа

талаар олноороо хуваалцаж эхэлсэн билээ. Тухайлбал Монгол улсын филармоний гоцлол дуучин Наранбаатар хадмуудтайгаа хамт амьдардаг байхдаа гэрлэлтийн эхэн үеийн зөрчлүүдийг эхнэртэйгээ хамт хэрхэн даван туулснаа хуваалцсан юм. Сэтгэлд илч нэмэх тэрхүү түүх бүр өөр өөрийнхөөрөө өвөрмөц, онцгой байсан ч, олон нийтэд ганц л мессежийг ахин дахин хүргэж байлаа: Хайр Өвтгөдөггүй.

Монгол улсад ЖСХ-тэй тэмцэх үндэсний хэмжээний сурталчилгааны аян болох “Хайр Өвтгөдөггүй” аянд олон нийт дуу хоолойгоо нэгтгэх, идэвхитэй оролцох нэг хэлбэр нь хувийн түүхээ харамгүй хуваалцах явдал байв. ЖСХ-ийн эсрэг олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх, мэдээлэл сурталчилгааны ажлын хамгийн том санаачилгуудын нэг болсон уг аяныг Цагдаагийн Ерөнхий Газар (ЦЕГ) Монгол улсад ЖСХ-тэй тэмцэх нь төслийн дэргэдэх хэвлэл мэдээллийн дэд хороотой хамтран зохион байгуулсан юм. Уг аяныг Монгол улсад Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон Зэвсэгт хүчний ойн баяр буюу цэргийн баярыг (сүүлийн үед эрчүүдийн өдөр болгож бүх нийтээр тэмдэглэх болсон) тохиолдуулан 2020 оны 3-р сарын 6-28-ны хооронд явуулсан. Гэвч түүний дараа КОВИД-19-ийн цар тахалын хөл хорио тогтоосонтой холбоотой ГБХ-ийн тохиолдол нэмэгдэж, шуурхай арга хэмжээ авах шаардлагатай болсноор НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Японы засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн жижиг төслийн хүрээнд тус аяныг 2020 оны 4-р сарын 20-ноос 5-р сарын 20 хүртэл үргэлжлүүлэн явуулсан юм.

Өнгөрсөн хугацаанд олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх чиглэлийн сурталчилгааны үйл ажиллагаанууд ЖСХ-ийн үр дагаврыг онцолдог байсан бол “Хайр Өвтгөдөггүй” аян хосуудын хоорондох болон гэр бүлийн доторх эрүүл харилцааг дэмжих замаар ГБХ-ээс урьдчилан сэргийлэх зорилгыг агуулснаараа онцлог. Ингэснээр Монголд ЖСХ-ийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд хувь хүний хариуцлага чухал гэсэн ойлголтыг олон нийтэд хүргэж, олон нийтийг өөрсдийн амьдралаа аз жаргалтай, амар амгалан байлгахын төлөө өөрчлөлтийг өөрсдөөсөө эхлэхэд уриалсан.

Монгол дахь НҮБХАС-ийн Жендэрийн хөтөлбөрийн зохицуулагч Б.Оюун хэлэхдээ, “Эхлээд бид ЖСХ-ийн сөрөг үр дагаврыг олон нийтэд ойлгуулж, ЖСХ-ийн хохирогчдод зайлшгүй шаардлагатай байгаа хэрэгцээг хангах, даван туулагчдыг хамгаалах механизмийг Монголд бий болгож, сайжруулахыг зорьж ажилласан. Одоо бидний ажил дараагийн шатандаа гарч, олон нийтийн оюун санааг өөрчлөн хүчирхийлэл, тэр дундаа ЖСХ-ийг үл тэвчих хандлагатай болгохыг зорин ажиллаж байна. Монголд ЖСХ-тэй тэмцэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагууд идэвхтэй ажиллаж, үүний үр дүнд гарсан томоохон амжилтуудын нэг нь ГБХТТХ-д нэмэлт өөрчлөлт оруулан баталж, түүнийг олон нийтэд өргөн хүрээнд танилцуулж, хэрэгжүүлэх ажлыг бодитойгоор эхлүүлэхэд энэхүү төсөл чухал үүрэг гүйцэтгэсэн явдал юм. Үүний дүнд ЖСХ-ийн талаарх хүмүүсийн хандлагад өөрчлөлт орж эхэлж байгаа ч ЖСХ-ээс урьдчилан сэргийлэхэд далайцтай өөрчлөлт хийхийн тулд энэ эрчийг алдалгүй

цаашид үргэлжлүүлэн ажилласаар байх шаардлага байсаар байна” гэсэн юм.

Олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх аянуудаар дамжуулан ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлэх, мөн нэгдмэл мессежийг олон нийтэд хүргэх шаардлагын үүднээс ЖСХ-тэй тэмцэх нь төслийн дэргэд хэвлэл мэдээллийн дэд хороог байгуулсан юм. Энэхүү дэд хороог НҮБХАС-аас чиглүүлж ажилласан бөгөөд бүрэлдэхүүнд нь төслийн хэрэгжүүлэгч засгийн газрын яам, агентлагууд, мөн түнш ТББ-ууд орсон байна. Ингэснээр ЖСХ-ийн асуудлаар өөр өөр байгууллагууд өөр хоорондоо өрсөлдсөн эсвэл бүр зөрчилдсөн агуулгатай мессежийг түгээж олон нийтийг төөрөгдүүлэхээс сэргийлэх боломж бүрдсэн. Түүнчлэн энэхүү хороо нь төслийн хэрэгжүүлэгч байгууллагууд үндэсний хэмжээний мэдээлэл сурталчилгааны аян зэрэг олон хэлбэрийн үйл ажиллагаан дээр хамтран ажиллах боломжийг улам бүр хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан юм.

Сүүлийн хоёр жилд дэд хорооны гишүүд ЖСХ-тэй тэмцэх гурван том хэмжээний аян дээр хамтарч ажиллаа. Эхнийх нь, 2018 онд ЖСХ-ийн эсрэг 16 хоногийн аяныг тохиолдуулан “ЭерэгБолГОЁ” (Жендэрийн харилцаа, хандлага, үйлдлийг эерэг болгоё) гэсэн нэгдсэн уриан доор олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Хоёр дахь том хэмжээний аян нь 2019 оны ЖСХ-ийн эсрэг 16 хоногийн аянаар “ойлГОЁХҮНдэлье”

(Бие биенээ ойлгож, хүндэлье) уриа бүхий аяныг хамтран зохион байгуулж, дараа нь 2020 оны Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хайр өвтгөдөггүй” аяныг зохион байгуулсан.

Ойлголт хандлагыг эерэг болгон өөрчлөх, ЖСХ/ГБХ-ийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх аяныг зохион байгуулах арвин туршлага дээрээ үндэслэн ЦЕГ сүүлийн хоёр том хэмжээний аяныг зохион байгуулахад тэргүүлэх үүрэгтэй ажилласан. Гэхдээ тэд ЖСХ шиг эмзэг асуудлыг хөндсөн мэдээлэл сурталчилгааны аяныг зохион байгуулах нь согтуугаар жолоо барих, хурд хэтрүүлэх зэрэг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн буруу зан үйлийг өөрчлөх аянтай харьцуулахад илүү бэрхшээлтэй бөгөөд амаргүй гэдгийг сайн ойлгож, энэ асуудлаарх олон нийтийн хандлага, ойлголт, хохирогч болон хүчирхийлэгчдийн сэтгэгдэл, бусад орнуудад энэ асуудлыг хэрхэн хөндөж, олон нийтэд хандсан үйл ажиллагаа явуулдаг туршлага зэргийг сайтар судалсны үндсэн дээр мэргэжлийн маркетингийн компаниудтай хамтран ажилласан. Түүнчлэн өмнө нь зохион байгуулсан олон нийтэд хандсан мэдээлэл сурталчилгааны олон аяны туршлага нь ЦЕГ-т ЖСХ-ийн эсрэг олон нийтийн кампанит ажлыг зохион байгуулахад маш сайн суурь туршлага болж өгсөн юм. ЖСХ-ийн даван туулагчид болон хүчирхийлэгчидтэй тулж ажилладаг тэргүүн фронтын байгууллага болохын хувьд ЦЕГ-ынхан хүчирхийллийн ноцтой хор хохирлыг байнга ойроос мэдэрч байдаг. Ийм учраас ЦЕГ-ын нийт бие бүрэлдэхүүн, түүний дотор Гэр бүлийн

хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн ажилтнууд ЖСХ-ийг таслан зогсоох урьдчилан сэргийлэх санаачилгуудын чухлыг сайн ойлгодог.

ЖСХ бол хувь хүмүүсийн хоорондын буюу тэвчиж болох асуудал биш, харин гэмт хэрэг бөгөөд хүний эрхийн зөрчил болохыг олон нийтэд ойлгуулах үйл ажиллагаа өнгөрсөн үед сургалт, семинараар хязгаарлагддаг байсан бол сүүлийн жилүүдэд сурталчилгаа мэдээллийн өргөн хүрээтэй аян дээрх үйл ажиллагаатай хамтдаа үр дүнгээ өгч байна. ЦЕГ-ын ГБХ-тэй тэмцэх хэлтсийн ажилтнууд мэдээлэл сурталчилгааны аяныг зохион байгуулахад онцлон анхаарч, олон нийтийн сурталчилгааны маркетингийн мэргэжлийн компаниудтай нягт хамтран ажилласнаар олон нийтэд хүргэх мессежийг үр дүнтэй, олон нийтэд нөлөөлж чадахуйц байдлаар боловсруулан, өргөн хүрээнд хүргэхэд илүүтэй анхааран ажилласан. Тэд мөн дэд хорооны бусад гишүүдтэй, ялангуяа НҮБХАС болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй нягт уялдаатай ажиллаж, сурталчилгааны аяны үндсэн уриа, мессежийг боловсруулахад арга зүйн дэмжлэг, санал зөвлөмжийг авч ажилласан нь илүү үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад тус болсон байна.

Монголчуудыг хайрын түүхээ онлайн орчинд нийтлэн аянд идэвхитэй оролцохыг уриалахаас гадна мөн олны танил хүмүүсийг оролцуулсан видео контент, харилцааны эрүүл дадал болон ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл агуулсан постер, хэвлэлийн мэдээ, тусгай булангийн мэдээ, олон нийтийн цахим

сүлжээний нийтлэл зэргийг бэлтгэсэн нь мөн үр дүнгээ өгсөн юм. Энэ бүх үйл ажиллагаа нь олон нийтийн цахим сүлжээнд нийт 3.7 сая хандалт авсан бөгөөд КОВИД-19-ийн улмаас хугацааг нь сунгасан “Хайр Өвтгөдөггүй” аян нь нэг сая гаруй үзэлттэй байсан байна. Энэхүү мэдээллийн аян нь мөн өргөн нэвтрүүлэг, хэвлэмэл мэдээ, хэвлэмэл постер, брошур, тараах нугалбар, зарын самбар, замын дэргэдэх самбар, автобусны буудал болон бусад олон нийтийн газрын мэдээллийн самбар зэрэг уламжлалт хэвлэл мэдээллийн сувгуудаар олон нийтэд хүрсэн болно.

Эл мэдээллийн аян нь дэлхийн өнцөг булан бүрт амьдарч байгаа Монголчуудад хүрсэн гайхалтай амжилтыг дагуулсан бөгөөд үүний гавьяа нь дан ганц бэлтгэсэн контентын тоо ширхэг, нэр төрөл бус, харин зөв мессежийг зөв сувгаар хүргэх стратеги барьж ажилласны үр дүн юм. Олон улсын сайн туршлага болон мэдээлэл сурталчилгааны салбар дахь судлаачдын баталж буйгаар зорилтот бүлэгт зохист зан үйлийг төлөвшүүлэхийн тулд мессежээр дамжуулан 1) тухайн зан үйлийг нийгмийн хэм хэмжээ болгох төдийгүй 2) өөрсдөдөө төлөвшүүлэх боломжтой гэдгийг ойлгуулахын зэрэгцээ 3) олон нийтэд эерэг сэтгэл хөдлөл, хандлага үүсгэх байдлаар хүргэх нь чухал болохыг аяны үр дүн харуулсан юм. “Хайр Өвтгөдөггүй” аян нь хамтрагчаа ойлгож, хүндлэх нь тэгш харилцааг үүсгэх, аливаа үл ойлголцлоос зайлсхийх боломжийг олгох зан үйл юм гэдгийг онцолсноороо амжилттай мэдээлэл сурталчилгааны



аяны дээрх гурван үндсэн шинжийг агуулж чадсан. Эрүүл харилцааг чухалчилж байгаа нь мөн ЖСХ-ийг таслан зогсоох нь хүн бүрийн хариуцлага бөгөөд хүн бүр өөрийн амьдралдаа өөрчлөлт хийх замаар энэхүү том зорилгод хувь нэмрээ оруулж болно гэдэг санааг нийтэд хүргэж байгаа явдал байсан.

«Хайр Өвтгөдөггүй» аян амжилттай, үндэсний хэмжээний аян болсон боловч нийгмийн болон зан үйлийн өөрчлөлтийг авчрахад засгийн газар төдийгүй, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил болон олон нийтийн чин зүтгэл, тасралтгүй хичээл чармайлт шаардлагатай байдаг утгаараа ийм хэлбэрийн аянуудыг илүү олноор өрнүүлэх шаардлагатай юм. Энэ үүднээс ирэх гурван жилд хэрэгжих ЖСХ-тэй тэмцэх нь төслийн хоёрдугаар шатанд мэдээлэл сурталчилгаа, боловсрол болон зан үйлийн өөрчлөлтийг авчрах арга хэмжээнүүдэд илүүтэй анхаарах юм.

ЦЕГ-ын ГБХ-тэй тэмцэх хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Цэнгэлбаяр хэлэхдээ, “ЖСХ-тэй тэмцэх нь төслийн ачаар ГБХ-тэй тэмцэх, олон нийтийн ЖСХ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, нийгмийн хандлага, итгэл үнэмшлийг өөрчлөх, даван туулагчдын эрхийг хамгаалах чиглэлээрх бидний өмнө хийдэг байсан үйл ажиллагаа улам бүр өргөжиж, дараагийн шатанд гарч чадсан. Бид эдгээр төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн туршлагаасаа үргэлжлүүлэн суралцахын хажуугаар ЖСХ-тэй тэмцэхэд олон нийтэд хүрч, тэднийг энэ тэмцэлд оролцуулж ажиллах илүү үр дүнтэй, шинэлэг аргуудыг эрэлхийлсээр байх болно” гэсэн юм.

## ҮР ДҮН

---



Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааг дэмжсэн орчин бий болж, хохирогчдыг хамгаалах үйлчилгээ институтчлэгдэв.



## ТОЙМ

Төслийн хүрээнд хохирогч хамгааллын болон салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг зохицуулах механизмийг бэхжүүлэх, бодлогын баримт бичгүүд болон журам удирдамжуудыг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлснээр бодлогын орчин, үйл ажиллагааны зохицуулалт, үр дүнтэй хамтын ажиллагаа, хамгааллын болон нөхөн сэргээх үйлчилгээний бүтэц бэхжиж, үйлчлүүлэгчдийн тоо, сэтгэл ханамж нэмэгдсэн.



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

### 1 ҮНДЭСНИЙ БОЛОН ОРОН НУТГИЙН ТҮВШИН ДЭХ САЛБАР ХООРОНДЫН ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН МЕХАНИЗМ

Шинэчлэн батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар (ГБХТТХ) ЖСХ болон ГБХ-тэй тэмцэх салбар хоорондын олон талт үйл ажиллагааг зохицуулах үүргийг Хууль зүйн сайдаар удирдуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүлээлгэсэн бөгөөд энэхүү зохицуулалтын механизмийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд бэхжүүлэх, чадавхжуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэхэд ЖСХ-тэй тэмцэх төсөл чухал хувь нэмрээ оруулсан.

ГБХТТХ-д заасны дагуу ЖСХ/ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг орон нутгийн засаг захиргааны анхан шатны нэгжийн хүрээнд (баг, хороо, сум) зохицуулах, олон нийтэд шууд хүрч ажиллах хамтарсан багуудыг (ХБ) чадавхжуулах, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх арга зүйгээр хангахад үе шаттай сургалтууд, бүсийн зөвлөгөөн, орон нутгийн туршлага солилцох танилцах аялал зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан төсөл чухал хувь нэмрээ оруулсан.

### 2 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД ЗОРИУЛСАН НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВҮҮД

Хүчирхийлэлд өртөгсдөд болон тусламж шаардлагатай хүн амд хамгааллын болон шаардлагатай бүх төрлийн үйлчилгээг үзүүлэхэд төслийн хүрээнд байгуулагдсан Нэг цэгийн үйлчилгээний төвүүд (НЦҮТ) чухал үүрэг гүйцэтгэсэн. НЦҮТ-үүд нь хүчирхийллийн хохирогч, даван туулагчдыг байрлуулан аюулгүй, тохь тухтай байраар хангаж, эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль зүй, зөвлөх болон хамгаалах үйлчилгээ үзүүлэхээс гадна сэтгэл зүйн хямралаа даван туулж, амьдралаа цаашид шинээр үргэлжлүүлэх ур чадвар эзэмшиж, эрч хүчтэй болоход нь туслах бусад төрлийн үйлчилгээнд холбон зуучилж, орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа амьжиргааг дээшлүүлэх, орлогоо нэмэгдүүлэх, шинэ ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрүүдтэй холбож өгдөг. Төслийн хүрээнд ЖСХ-ийн тархалт хамгийн өндөртэй 7 аймаг (Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Хэнтий,



Хөвсгөл, Өмнөговь, Өвөрхангай) болон нийслэл Улаанбаатар хотын 2 дүүрэгт (Хан-Уул, Баянзүрх), түүнчлэн КОВИД-19-ийн цар тахлын үед үйлчилгээ тусламж хамгийн их хэрэгтэй байгаа 2 дүүрэгт (Чингэлтэй, Сүхбаатар) нийт 11 НЦҮТ-ийг шинээр байгуулсан юм. Үүнээс гадна өмнө нь байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 6 НЦҮТ болон 2 түр хамгаалах байранд төслийн зүгээс санхүүгийн болон арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

Мөн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны салшгүй хэсэг болох хүчирхийлэгчийн зан үйлийг өөрчлөх чиглэлээр санаачлага гарган Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн байранд Эрэгтэйчүүдэд зориулсан сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвийг байгуулсан нь ялангуяа анх удаа хүчирхийлэл үйлдсэний улмаас баривчлагдсан хүмүүст цаашид хүчирхийлэл дахин үйлдэхээс хэрхэн зайлсхийх, мөн өөрийн сэтгэл зүй, сэтгэл хөдлөлөө хэрхэн удирдах, гэр бүлийн харилцаа, халуун дотно уур амьсгалыг хэрхэн хадгалах зэрэг олон асуудлаар мэдээлэл авч өөрийн амьдралд хэрэгжүүлэн дахин хүчирхийлэл үйлдэхээс зайлсхийх боломжийг олгосон. Энэхүү төв нь энэ төрлийн үйл ажиллагааг явуулж байгаа анхны төв бөгөөд ГБХТТХ-иар хуульчилж өгсөн зан үйл нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг турших, үр дүнтэй хэрэгжүүлэхэд туслах байгууллага болсон юм.

### 3 ШИЙДВЭР ГАРГАГЧДАД ЗОРИУЛСАН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ САНААЧИЛГУУД

Төслийн хүрээнд ГБХТТХ-иар үүрэг хүлээсэн салбаруудын шийдвэр гаргагчдын мэдлэг ойлголт, хандлага, дэмжлэгийг дээшлүүлэх зорилгоор олон хэлбэрийн ажлуудыг хийж ирсэн нь тодорхой үр дүнгээ өгсөн. Тэдгээрийн дотор сургалт, семинар болон дотоодын туршлага судлах аялал зохион байгуулсан нь үр дүнтэй ажлууд болсон төдийгүй, хохирогч хамгааллын болон нөхөн сэргээх үйлчилгээний олон улсын наад захын стандартад нийцсэн үйлчилгээг бий болгон үзүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангахуйц стандарт, зөвлөмж, гарын авлага, тараах материал зэргийг боловсруулан гаргасан нь энэ чиглэлийн үйл ажиллагааг мэдээлэлд тулгуурлан удирдах мөн шаардлагатай дэмжлэгийг үзүүлэхэд шийдвэр гаргагч нарт ихээхэн тус болсон. Төслийн дэмжлэгтэйгээр тулгамдсан асуудлуудыг хамтдаа хэлэлцэж, сайн туршлагаа хуваалцаж, хохирогч хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээний олон улсын чиг хандлага, бодлогын талаарх мэдээллийг хуваалцах, салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдааг бэхжүүлэх зорилгоор ЖСХ-тэй тэмцэх салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх нь сэдэвт Үндэсний хэмжээний чуулганыг жил бүр уламжлал болгон зохион байгуулсан нь үндэсний хэмжээнд ЖСХ-тэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, нэгдмэл ойлголттойгоор хамтран ажиллахад чухал түлхэц болсон бөгөөд бүсийн чуулганыг нэг удаа зохион байгуулж, сум, хорооны түвшний хамтарсан багуудыг оролцуулсан нь шийдвэр

гаргагчдын түүний дотроос иргэдтэй илүү ойр тулж ажилладаг ажилтнуудын мэдлэг ойлголт, чадавхийг бэхжүүлэхэд тустай чухал арга хэмжээ болсон.

## 4 КОВИД-19-ИЙН ЦАР ТАХЛЫН ҮЕД ЖСХ-Д ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НЬ

КОВИД-19 вирусийн халдвар дэлхий даяар тархаж эхлэх үед Монгол улсын Засгийн газар халдвар тархахаас сэргийлэх зорилгоор олон нийтийн цугларалтыг хориглох, мөн орон нутгийн болон олон улсын зорчих хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг олон төрлийн арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээ нь тархалтаас сэргийлэхэд чухал ач холбогдолтой байсан хэдий ч төсөл төлөвлөсөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний саад тулгарсан. Түүнчлэн үүссэн нөхцөл байдал нь мөн ГБХ-ийн тоо огцом өсөхөд нөлөөлсөн төдийгүй хохирогч хамгааллын болон нөхөн сэргээх үйлчилгээг аюулгүй бас үр дүнтэй үзүүлэхэд бэрхшээл тулгарсан.

Энэ нөхцөл байдлыг харгалзан төслийн үлдсэн хугацааны төсөв, төлөвлөгөөнд тодотгол хийж цар тахалтай холбогдон бий болсон шинэ нөхцөл байдалд тохируулан шаардлагатай арга хэмжээнд хөрөнгө нөөцийг зарцуулах шийдвэрийг төслийн зүгээс гаргасан нь цаг үеэ олсон оновчтой шийдвэр болсон. Мөн үүссэн нөхцөл байдлын шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс болон нэн даруй анхаарах шаардлагатай асуудлуудыг тодорхойлох зорилгоор ЖСХ-ийн нөхцөл байдал болон үйлчилгээнд КОВИД-19 хэрхэн нөлөөлж буйг үнэлэх түргэвчилсэн үнэлгээг хийж гүйцэтгэв. Түүнчлэн цар тахлын үед ГБХ-ийн гаралт өсч, тусламж шаардлагатай хүмүүсийн тоо ихэссэнтэй холбогдуулан Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийн гэр хорооллын дунд 2 НЦҮТ-ийг шинээр байгуулсан. Сэтгэл зүйн болон хямралын үеийн үйлчилгээг тасралтгүй үзүүлэх шаардлагын үүднээс алсын зайнаас сэтгэл зүй болон хууль зүйн зөвлөгөө өгөх загваруудыг (тусламжийн утас болон онлайн тусламж) бий болгон ажиллуулсан нь тусламж шаардлагатай олон эмэгтэйчүүд, хүүхдүүдэд ихээхэн тустай үйлчилгээ болсон.





## ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ҮР ДҮН
<b>ҮР ДҮН 3:</b> Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааг дэмжсэн орчин бий болж, хохирогчдыг хамгаалах үйлчилгээ институтчлэгдсэн байна.	
3.1. Хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг институтчилэх шийдвэр үндэсний хэмжээнд гарсан байна. <i>Суурь үзүүлэлт:</i> Үндэсний түвшинд гарсан шийдвэр байхгүй (2016) <i>Хүрэх үр дүн:</i> Үндэсний түвшинд шийдвэр гарсан байна (2020)	<b>БҮРЭН ХЭРЭГЖСЭН</b> 11 НЦҮТ болон 1 Эрэгтэйчүүдийн Төвийг байгуулж 6 НЦҮТ, 2 түр хамгаалах байранд дэмжлэг үзүүлэв.
3.2 ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө нэмэгдсэн байна. <i>Суурь үзүүлэлт:</i> 20 сая төгрөг (2016) <i>Хүрэх үр дүн:</i> 100 сая төгрөг (2019)	<b>БҮРЭН ХЭРЭГЖСЭН</b> Орон нутгийн төсвөөс 1 тэрбум төгрөгийг ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлд зарцуулав.
<b>ҮР ДҮН 3.1.:</b> ЖСХ-ийн хохирогчдыг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг дэмжих бодлогын орчин сайжрав.	
3.1.1 Олон улсын стандартын дагуу үйлчилгээ үзүүлж байгаа НЦҮТ-ийн тоо <i>Суурь үзүүлэлт:</i> 6 (2016) <i>Хүрэх үр дүн:</i> 16 (2020)	<b>БҮРЭН ХЭРЭГЖСЭН</b> Төслийн зүгээс үйлчлүүлэгчдэд чанартай үйлчилгээ үзүүлэх нийт 11 шинэ НЦҮТ байгуулж, 6 төвд дэмжлэг үзүүлэн ажиллав.
<b>ҮР ДҮН 3.2.:</b> ЖСХ/ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох салбар хоорондын хамтын ажиллагаа боловсронгуй болов.	
3.2.1. НЦҮТ-үүдээр үйлчлүүлсэн хүний тоо нэмэгдсэн байна. <i>Суурь үзүүлэлт:</i> 1,713 (2016) <i>Хүрэх үр дүн:</i> 2,399 (2020)	<b>БҮРЭН ХЭРЭГЖСЭН</b> 2019 онд НЦҮТ-үүдээс нийт 2054 даван туулагч үйлчилгээ авсан бол 2020 оны эхний хагас жилийн байдлаар 1889 даван туулагч үйлчилгээ авсан байна.
3.2.2. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн байдал нэмэгдсэн байна. <i>Суурь үзүүлэлт:</i> Мэдээлэл байхгүй (2016) <i>Хүрэх үр дүн:</i> Мэдээлэлтэй болсон (2020)	<b>БҮРЭН ХЭРЭГЖСЭН</b> Үндэсний статистикийн хорооноос судалгаа явуулж үзэхэд үйлчлүүлэгчдийн 56.3-61.5% нь дундаас дээш сэтгэл ханамжтай гэж гарсан.
3.2.3. Хамтарсан багийн шийдвэрлэсэн ЖСХ-ийн тохиолдлын хувь нэмэгдсэн байна. <i>Суурь үзүүлэлт:</i> 182 (2016) <i>Хүрэх үр дүн:</i> 219 (2020)	<b>БҮРЭН ХЭРЭГЖСЭН</b> 2019 онд 758 кейсийг хамтарсан багаар шийдвэрлэсэн бол 2020 оны эхний хагас жилийн байдлаар 447 кейсийг шийдвэрлэсэн байна.

## НАРААГИЙН ТҮҮХ

*\*Даван туулагчийг хамгаалах үүднээс нэр болон зарим баримтыг өөрчлөн бичсэн болно.*

Монгол улсад ЖСХ-тэй тэмцэх нь төслийн хүрээнд Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг (НЦҮТ) төлөвлөж, барьж байгуулах үед гол үйлчлүүлэгчид нь хүчирхийлэлтэй орон гэрээсээ хүүхдүүдээ аваад зугтан ирэх насанд хүрсэн эмэгтэйчүүд байх болов уу гэсэн төсөөлөл давамгайлж байлаа. Гэвч өр өвтгөмөөр нь, НЦҮТ-үүдийн туршлагаас харахад үйлчлүүлэгчдийн багагүй хувь нь хүүхдүүд байсны дотор бэлгийн хүчирхийллийн даван туулагчид цөөнгүй байв. Тодруулбал, 2020 оны 8-р сарын байдлаар ... аймаг дахь НЦҮТ-өөс үйлчилгээ авсан 55 үйлчлүүлэгчийн дотор 9 нь хүүхэд байсан юм.

11 настай Нараа\* хойд эцэг нь бэлгийн дарамт учруулж байгаа тухай нагац эгчдээ хэлснээр ээжтэйгээ хамт аймгийн төвд байдаг НЦҮТ-д очсон байна. Тэрээр гэртээ юу туулж байгаагаа бусдад хэлэх гэж олон сар болжээ. Энэхүү сэтгэлийн дарамт гэмтэл хийгээд амийг нь хорооно гэх хүчирхийлэгчийн сүрдүүлгээс айх айдас нь Нарааг туулж байсан зовлонгоо бусдаас нуухад хүргэсэн байна.

Харамсалтай нь Нараагийн түүх бусад түүхийн адил байв. Үндэсний Хэмжээний ЖСХ-ийн Судалгаанаас үзэхэд охид, эмэгтэйчүүдийн нас залуу байх тусам хамтрагч бус хүний зүгээс үйлдсэн биеийн эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөх магадлал өндөрсдөг байна. 15-19 настай охидын 17% нь амьдралдаа дор хаяж нэг удаа хамтрагч бус хүний зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байхад 39% нь хамтрагч бус хүний зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна.

Энэ төрлийн хүчирхийллийг ихэвчлэн гэр бүлийн гишүүн нь эсвэл даван туулагчтай ойр хүн үйлддэг учраас хохирогчдын хувьд хэргийг цагдаад мэдэгдэхэд улам бүр хүндрэлтэй болдог. Гэмт хэрэгтнүүд даван туулагчдын толгойг эргүүлж, хүчирхийлээ хайрын илэрхийлэл гэж ойлгуулах арга заль их ашигладаг. Мөн хүчирхийллийн талаар ам нээвэл өөрсдийг нь болон гэр бүлийнхнийг нь зовооно гэж сүрдүүлдэг байна. Монгол улсын Ерөнхий прокурорын газраас бэлгийн хүчирхийллийн даван туулагч хүүхдүүдийн 26.3% хүчирхийлэлд нэгээс олон удаа өртсөн байдаг гэж мэдээлжээ. Хүчирхийллийн шинж тэмдгийг хэн нэгэн хүн илрүүлэх эсвэл

даван туулагч өөрөө ам нээж, тусламж эрэх хүртэл хүчирхийлэл үргэлжилсээр байх магадлал өндөр байдаг нь харамсалтай бодит байдал юм. Нараагийн тохиолдол дээр сургуулийн амралтаараа нагац эгчийндээ очсон байхдаа зориг гаргаж бүгдийг хэлснээр хүчирхийллийг таслан зогсоосон байна.

Аймгийн төвд НЦҮТ байж таарсан нь олзуурхууштай. Нараа, Нараагийн ээж Хулан\* хоёр орлого багатай амьдардаг байсан учраас хүчирхийллээс бие даан зугтах боломж бололцоогүй байжээ. Нараагийн нагац эгч хэргийн талаар цагдаад мэдэгдэхэд цагдаагийн газраас Нараа, Хулан хоёрыг хамгаалуулахаар НЦҮТ-тэй холбож өгсөн байна. Төвд очсон хойноо Нараа туулж өнгөрүүлсэн бие махбодын болон сэтгэл санааны гэмтлээсээ илаарших аяллаа эхлүүлэх боломжтой болжээ.

Ээж охин хоёрыг ирсэн даруйд төвийн ажилтнууд Нараагийн сэтгэцийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд хүчирхийлэл хэрхэн нөлөөлсөн талаар, мөн уг гэр бүлийн санхүүгийн нөхцөл байдлын талаар Хулантай ярилцсаны үндсэн дээр хэрэг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулсан байна. Хэрэг шийдвэрлэх төлөвлөгөө гаргах нь даван туулагчдад цогц үйлчилгээ үзүүлэх хамгийн эхний алхам байдаг. Учир нь төлөвлөгөө гаргаснаар НЦҮТ-ийн ажилтнууд тухайн хүний тусгай хэрэгцээг үнэлж, үйлчилгээгээ тухайн нөхцөл байдалд тохируулах боломжтой болдог. Нараагийн тохиолдолд, ээж охин хоёр бэлгийн замаар дамжих халдварын эмчилгээ болон сэтгэл зүйн зөвлөгөө авах шаардлагатай байжээ. НЦҮТ-ийн ажилтнууд

КОВИД-19-ийн цар тахлын үед ч Нараагийн хичээл сургуулийг тасалдуулалгүй, хэрэгцээт сурах бичиг болон зайн сургалтын тоног төхөөрөмжөөр хангасан байна.

Нараа бол аймаг дахь НЦҮТ 2018 онд байгуулагдсанаас хойш тусламж авсан олон даван туулагчийн нэг юм. Төвөөс аюулгүй байр, эрүүл мэнд, нийгэм-сэтгэлзүйн, хууль эрх зүйн болон хамгааллын үйлчилгээ зэрэг цогц үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ иргэдэд нээлттэй бусад нийгмийн үйлчилгээнд зуучилж өгдөг. Энэхүү иж бүрэн, цогц үйлчилгээ нь зайлшгүй чухал байдаг. Учир нь ЖСХ-ийн даван туулагчдыг хамгаалж, сэргээн засахад олон салбарын арга барил шаардлагатай. Энэ бүх үйлчилгээг төвлөрсөн нэг цэгээс үзүүлэх болсноор даван туулагчдыг хэрэгцээт үйлчилгээгээ авахын тулд ийш тийш явах шаардлагагүй болгож, аюулгүй байдлыг нь нэмэгдүүлдэг. Мөн болсон явдлаа ахин дахин ярьж, сэтгэлийн гэмтлээ сэдрээхээс сэргийлдэг. Түүнчлэн нөхцөл байдлынх нь талаар тоотой хэдэн хүн л мэдэж байдаг учраас хувийн нууцыг нь илүү сайн хамгаалж чаддаг.

Хүүхдүүд ЖСХ-ийн гэрч болсон ч, өөрсдөө хохирогч болсон ч ялгаагүй урт хугацаанд үргэлжлэх хохирлыг даван туулах болдог. ЖСХ-ийн даван туулагчид нь сэтгэлийн гэмтлийн дараах стрессийн эмгэг, сэтгэл гутрал, түгшүүр, гэм буруутай мэт мэдрэмж, ичгүүр, уур болон өөрийгөө доогуур үнэлэх зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг үр дагаврыг мэдэрдэг. Нараагийн тохиолдол ч мөн ялгаагүй байв. Нараа уг харамсалтай үйл явдлаасаа болж сэтгэлийн гүн шарх

авсан боловч аз болоход төвийн ажилтнууд энэ байдлыг нь цаг алдалгүй анзаарч, сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд хамруулсан байна. Гэхдээ Нараагийн хувьд уг явдлаас болж эрүүл мэндийн хэд хэдэн асуудалтай болсон бөгөөд нэг удаа бүр түргэн тусламж авах шаардлагатай болтлоо дордож байсан юм.

Нараа, Хулан хоёр өөрсдийн гэсэн амьдрах газар олох хүртлээ НЦҮТ-д байрлажээ. Үнэндээ НЦҮТ-ийн ажилтнууд тэр хоёрын өмнөөс орон нутгийн удирдлагууд болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай холбогдож амьдрах орон гэрээр дэмжлэг үзүүлэхийг хүсэж том тус болжээ. Харин хойд эцэг нь хийсэн хэрэгтээ эрүүгийн хариуцлага хүлээсэн бөгөөд хэргийг нь саяхан орон нутгийн шүүхэд шилжүүлсэн байна.

Нараа, Хулан хоёр одоо аймгийн төвд амьдарч байна. Нараа сургуульдаа эргэн орж, ээж нь НЦҮТ-ийн багийнхны тусламжтайгаар ажил хайж байгаа юм. Тэд энэ бүх хичээл зүтгэл нь хэзээ нэгэн өдөр гэр бүлд нь гэрэлт ирээдүйг авчирна хэмээн итгэж буй.



## ДОЛЖИНГИЙН ТҮҮХ

*\*Даван туулагчийг хамгаалах үүднээс нэр болон зарим баримтыг өөрчлөн бичсэн болно.*

Должин\*, нөхрийн хамт арваад жилийн өмнө Улаанбаатарт нүүж иржээ. Хөл толгой нь солигдсон хоёр мянгаад оны үед залуу гэр бүл, нялх үрийнхээ хамт захгүй их бэрхшээлийн хаяанд тулж ирээд байлаа. Монгол улсын хөгжил дэвшил байнгын алдагдалтай ажилладаг эдийн засгаасаа болж хөдөлгөөнгүй гацсан тэдгээр он жилүүдэд ядуурал болон нийгмийн бусад цогц асуудлууд газар авч байв. Үүнд хамгийн их өртөж байсан нь сумын төвүүд бөгөөд алс бөглүү орших тэдгээр суурин газруудад ажилгүйдэл, хэр тааруухан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанаргүй боловсрол, газар авсаар буй архидалт болон гэр бүлийн хүчирхийлэл гэсэн асуудлууд тулгараад байсан юм.

Нийслэл хотруу шилжих бодол Должин болон түүний нөхөр Батаад\* хоёуланд нь зэрэг төрсөн байна. Төрөл садан, найз нөхдийнх нь ихэнх нь хэдийнээ нүүн одож, тэднээс хавь илүү амьдарч байгаа юм шиг санагдсан тул залуу хосууд дотроо шилжих тухай олон сар бодож явсны дараа бие биедээ хэлжээ. Гайхалтай нь тэд хоёулаа энэ боломжийг ашиглахаар шийдсэн байна. Гэхдээ шилжинэ гэдэг, ялангуяа эхэн үедээ амаргүй гэдгийг тэд хоёул мэдэж байлаа.

Должин ярихдаа, “Биднийг анх Улаанбаатарт ирэхэд холын хамаатнууд маань тусалдаг байсан. Гэхдээ бид тэдний дэмжлэгийг байнга гуйгаад байж чадаагүй” гэсэн юм.

Аав ээжийнхээ 200 орчим хонь, ямааг зарж олсон багахан мөнгө нь ганц хашаа (жижиг байшинтай хашаа) аваад, суурьшихад хэрэгтэй эхний зардлуудаа гаргахад дуусаж орхижээ. Хоол хүнс, хувцас хунар, түлээ нүүрс, ус болон бусад үндсэн хэрэгцээний зардал гэр хороололд орон сууцнаас 7 дахин өндөр тусдаг. Должин дахиад бие давхар болсноо мэдэх үед гэр бүлийн амьдрал нь хэдийнээ хүнд байдалд ороод байсан юм.

Должин хэлэхдээ, “Бидэнд жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл авах мөнгө байгаагүй. НҮБХАС-ийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөр гэж байдгийг мэдсэн бол, хамрагдах байсан юм” гэв.

Нийгмийн дэмжлэгийн дутмаг байдал, мэдээлэл олж авах боломжгүй байдал, танихгүй мэдэхгүй газарт хаягдсан гэх мэдрэмж



– энэ бүх асуудал хосуудын өдөр тутмын амьдрал дээр нэрмээс болж, өмнөхөөсөө илүү хэрүүл уруултай амьдрах болжээ.

“Би өдөржингөө хүүхдүүдээ харж гэртээ өнждөг байсан. Манай хүүхдүүдийг Улаанбаатарт бүртгэлгүй гээд ямар ч цэцэрлэгт хүлээж аваагүй” гэж хэлэхдээ Должингийн хоолой нь зангирч, нулимс нь цийлгэнэж байлаа.

Мөн, “Манай нөхөр эцэстээ гэр бүлээ тэжээх гэж хог түүдэг болсон. Бас архианд орж, шөнө орой шал согтуу, ууртай, түрэмгий болчихсон гэртээ ирдэг болсон” гэж дурсамжаа хуваалцахдаа Должин чичирч байлаа. Сэтгэл нь тавгүйтэж, гартаа барьсан даавууны өөдсөө сэмлэх зуур нулимс нь тогтохгүй байсан Должин, “Тэр үед л бүх гай эхэлсэн” гэсэн юм.

Должингийн түүх өр өвтгөм хэдий ч, харамсалтай нь ийм түүх олон хүнд тохиолддог. Монгол дахь НҮБХАС-ийн Жендэрийн хөтөлбөрийн зохицуулагч Б.Оюун хэлэхдээ, “Ихэвчлэн амьдралын үндсэн хэрэгцээ нь хангагдаагүй, нийгмийн үйлчилгээ дутмаг, гэр бүл төлөвлөлтгүй байдлаас болж жендэрийн тэгш бус байдал хурцадсанаар гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж байна” гэсэн юм.

Должин, хүүхдүүдтэйгээ амьдын тамыг туулж байсан бөгөөд яс нь хугарсан, толгой нь хагарсан, арьс нь шилэнд зүсэгдсэн байдалтай Гэмтлийн эмнэлэгт хэд хэдэн удаа очсон байна. Гэхдээ тэд Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг дэх Нэг цэгийн үйлчилгээний төвд (НЦҮТ) очоогүй бол энэ бүхэн бүр муугаар төгсөж болох байлаа.

## НЦҮТ итгэл найдвар өгч, хамгаалж, дэмжиж байна.

Баянзүрх дүүрэг дэх НЦҮТ нь 2019 оны 3-р сард үүдээ нээжээ. Төв байгуулах ажилд Дүүргийн зүгээс төв зам дагуу байрлах хашаатай жижигхэн байшинг хандивласан бөгөөд түүнийг дүүргээс гаргасан 1 сая төгрөг, мөн НҮБХАС болон Швейцарын хөгжлийн агентлагийн (ШХА) 63 сая төгрөгөөр засаж, тохижуулан ЖСХ-ийн даван туулагчдын байр болгожээ.

2019 онд Баянзүрх дүүргийн НЦҮТ-ийн нээлтэн дээр Монгол дахь НҮБХАС-ийн Тэргүүн Каори Ишикава хэлэхдээ “ЖСХ-ийг эцэслэхэд эмэгтэйчүүдэд үйлчилж, эрэгтэйчүүдтэй ажиллах нь нэгэн адил, туйлын ач холбогдолтой” гэсэн юм. ГБХ-ийн даван туулагчдын 88% нь охид, эмэгтэйчүүд байгаа учраас хүчирхийллийг голлон үйлдэгч болох эрэгтэйчүүдтэй ажиллах нь ЖСХ-ээс урьдчилан сэргийлэхэд нэн чухал болно. Тэрээр мөн, “Даван туулагчдад зориулсан дэмжлэгийг сайжруулах болон хүчирхийллийн үйлдлийн үр дагаврыг бууруулах ажлыг хийхтэйгээ зэрэгцүүлээд ЖСХ-ийн уг шалтгааныг ойлгож, түүнийг шийдвэрлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах ёстой” гэсэн юм.

Энэ л үйл хэргийн ачаар Должин хүүхдүүдийн хамт аврагдаж, гэр бүлээ дахин нэгтгэх боломж нээгджээ.

Баянзүрх дүүргийн НЦҮТ-ийн нийгмийн ажилтан, “Бид хамтарсан баг гэж нэрлэдэг олон салбарын багуудыг НЦҮТ-ийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, түүнчлэн эмч мэргэжилтнүүд, цагдаагийнхан

болон хорооны бусад нийгмийн ажилтнууд гэсэн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй байгуулж боломжит хамгийн сайн үр дүнд хүрэх байдлаар кейсүүдийг цогцоор нь шийдвэрлэх болсон” хэмээн ярьж байв.

ЖСХ-ийн цогц хариу арга хэмжээний нэг чухал бүрэлдэхүүн нь хүчирхийлэл үйлдэгчидтэй ажиллах явдал юм. Зарим хүчирхийлэгчид үйлдсэн хэргийнхээ хэмжээнээс хамаараад түр саатуулагдсан байдаг ба тэдэнд зориулсан сургалтуудад суух ёстой байдаг. Уг сургалтаар тэдэнд хүчирхийллийн шалтгааныг тайлбарлаж ойлгуулахаас гадна сэтгэл хөдлөлөө удирдаж, хүчирхийллээс ангид байдлаар биеэ авч явах арга замуудыг заадаг. Үүнтэй төстэй сургалт болон зөвлөгөөг хосуудад мөн ордог бөгөөд хүчирхийллийн бус аргаар сэтгэл хөдлөлөө илэрхийлж, гэр бүлийн зөрчлөө шийдвэрлэх арга замуудыг сургадаг байна.

Должин, нөхрийн хамт эдгээр сургалтын заримд нь суусан байна. Сургалтын эцэст Должин ичингүйрэн инээмсэглэнгээ, «Өмнө нь бид хоёр ер нь хэзээ ч тайвширч, асуудлыг хамтдаа ярилцаж шийдье гэж оролддоггүй байж. Нөхцөл байдалдаа дүн шинжилгээ хийх боломжтой орчинг бүрдүүлж, юмны учир ойлгодог улс шиг асуудлаа даван туулах арга замуудыг хэзээ ч эрэлхийлдэггүй байжээ» хэмээн ярьсан юм.

Тайвширч, нөхцөл байдлаа хамтдаа даван туулахын төлөө хичээх арга замуудад суралцсанаар амьдрал болон харилцаа нь шинэ шатанд гарсан гэж Должин хэлсэн юм. Тэрээр мөн, “Одоо л бид хоёр бие биедээ итгэж, бие биенээ дэмжиж хамтран амьдарч байна. Гайхалтай нь бидний харилцаа нэлээн сайжирснаас гадна санхүүгийн байдал маань ч дээрдсэн шүү. Учир нь бид асуудлуудаа нэгэн өнөр гэр бүлийн хүчээр шийдэж эхэлсэн. Гэр бүлийн шийдвэр гаргалтад жаахан хүүхдүүдээ хүртэл оролцуулдаг болсон” гэсэн юм.

Ийн оролцуулах болсноор хүүхдүүдийнх нь өөртөө итгэх итгэл нэмэгдсэн байна. Энэхүү амар тайван, эерэг уур амьсгалтай орчин төд удалгүй хүүхдүүдийн сурлагад сайнаар нөлөөлж, сургуульдаа дасан зохицоход нь нэмэр болж эхэлжээ.



*«НЦҮТ миний гэр бүлийг аварсан. Энэ төв байгаагүй бол манайх гэр бүлээрээ амьдарч чадахгүй байх байлаа»*



Мөн төвөөс Должинд хоёр бага хүүхдээ цэцэрлэгт хамруулахад тусалсан бөгөөд нөхөрт нь ажил олоход тусалжээ. Хамтарсан багаар амжилттай ажиллаж, хүртэх ёстой нийгмийн халамж дэмжлэг болон хүн хоорондын харилцаа холбоо, энэ бүхнийг хамтатгаж чадвал гайхамшгийг бүтээж болно гэдгийг тус төв батлан харуулсан юм.

“Бидний тусламж, дэмжлэг шаардлагатай байгаа бүр олон гэр бүл манай дүүрэгт амьдарч байгаа” гэж Баянзүрх дүүргийн НЦҮТ-ийн зохицуулагч хэлсэн юм. Өмнө нь цагдаагийн ажилтан байсан тэрээр ядуурал, ажилгүйдлийн түвшнээрээ нийслэл хотод тэргүүлдэг Баянзүрх дүүрэгт ийм төрлийн үйлчилгээ хэчнээн чухал болохыг дэндүү сайн ойлгодог нэгэн билээ. Тэрээр мөн хэлэхдээ, “Манай НЦҮТ-д нэг удаадаа 4 хүнийг л хүлээн авах боломжтой байдаг. Харамсалтай нь бид тэдгээр даван туулагчдыг 3-5 хоногоос илүү удаан хугацаагаар байлгаж чаддаггүй” гэсэн юм.

Даван туулагчдад цаашид дэмжлэг шаардлагатай байгаа тохиолдолд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дэргэдэх Түр хамгаалах байрлуу шилжүүлж, хүчирхийлэл үйлдэгчийн хэргийг шүүхээс шийдвэрлэх хүртэл байрлуулдаг байна. Зарим тохиолдолд ГБХ-ийн даван туулагчид тус байранд олон сараар байрлах нь бий.

“Ийм учраас ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг нийгэм даяар, ялангуяа залуусын дунд тасралтгүй хийх нь тун чухал” гэж НҮБХАС-

ийн Жендэрийн хөтөлбөрийн зохицуулагч Б.Оюун хэлсэн юм. Энэ нь НҮБХАС-ийн ажилладаг зорилтот бүлгүүдийн нэг бөгөөд Залуучуудын хөгжлийн хөтөлбөр нь залуучуудад зориулан гэр бүл төлөвлөлт хийгээд гэр бүлийн амьдралын бусад асуудал, эрүүл харилцаа, зөрчлийг шийдвэрлэх тухай боловсрол олгох сургалт явуулдаг. Уг сургалтууд нь шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан 13 цуврал гарын авлага дээр суурилсан байдаг бөгөөд Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн Залуучуудын Хөгжлийн Төвүүдэд явуулдаг. Энэхүү сургалтад хамрагдсан Залуучуудын Хөгжлийн Зөвлөл нь эргээд бусдадаа мөн сургалт явуулж, илүү олуулаа болсоор байна.

НҮБХАС-ийн Тэргүүн Каори Ишикава хэлэхдээ “Монгол улсад ЖСХ болон ГБХ тархсан байдлаас дүгнэж хэлэхэд НЦҮТ-үүдийг нээх ажил нь ЖСХ-ийг орон даяар таслан зогсоох энэхүү тэмцлийн зөвхөн эхлэл нь байх учиртай. Бидэнд хийх ажил их байна. Гэхдээ гол нь энэхүү аяллыг бид Монгол хүмүүстэй, Монгол улсын Засгийн газартай хамт эхлүүлсэн гэдэг нь чухал. Бид хамтдаа Монгол улсыг эмэгтэй, эрэгтэй хүн бүрийн, мөн хүүхэд бүрийн эрхийг хүндэтгэж, хамгаалдаг, амар тайван, цэцэглэн хөгжсөн нийгэм болгож чадна” гэсэн юм.

## ДУЛАМЫН ТҮҮХ

*\*Даван туулагчийг хамгаалах үүднээс нэр болон зарим баримтыг өөрчлөн бичсэн болно.*

Дулам\* анх Монгол орны хойд хэсэгт байрлах нэгэн аймгийн Нэг цэгийн үйлчилгээний төвөөс (НЦҮТ) тусламж хүсэхдээ сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн эмгэгээр (PTSD) шаналж байжээ. Тэр үед 38 настай байсан Дулам дөрвөн хүүхдийн хамт олон жил нөхрийнхөө гарт зовж амьдарсан байв. Ирээдүйдээ итгэх итгэлээ алдсаны дээр, амиа хорлох тухай бодол хүртэл үе үе төрдөг болсон байжээ.

Дуламын амьдрал уг нь ийм хүнд хэцүү байгаагүй аж. 18 жил ханилсан хань Самбуутайгаа\* 2-16 насны дөрвөн хүүхдийн хамт амар жимэр аж төрж байжээ. Гэвч 2014 онд нөхөр нь нэгэн ойрын садангаа алдсан цагаас хойш бүх зүйл өөрчлөгдсөн байна. Уй гашуугаа даван туулахын тулд архи уух болж, удалгүй огт өөр хүн болж хувирчээ. Эхнэр, хүүхдүүддээ гар хүрч эхэлсэн бөгөөд үе үе гэр бүлээ гутаан доромжлох болжээ.

Самбуу мөн мэргэжлийн ажлаа тогтвор суурьшилтай хийж чадахаа больсноор Дулам гэр бүлээ ганцаар тэжээх ёстой болсон байна. Тэрээр гэнэт халагдсаны тэтгэмж болон сар бүрийн 50,000 төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжээс өөр орлогогүй байсан тул хэдийнээ үүсээд байсан гэр бүлийн асар их стресс нь улам бүр нэмэгдсэн байна.

Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр нөхөр нь эхнэр, хүүхдүүддээ улам бүр хүчирхийлэнгүй хандаж эхэлжээ. Хаалттай хаалганы цаана гэр бүлд тохиолдож байгаа явдлаас болж хүүхдүүд нь ичгэвтэр байдалд орж, ялгаварлан гадуурхагдах вий гэж айсандаа Дулам болж буй явдлын талаар тусламж ч хүсэж чадахгүй, найз нөхөд болон хамаатан садангууддаа ч ярьж зүрхлэхгүй байв. Дулам амьдрал нь эргээд сайжирна гэсэн итгэлээ өм цөм алдаж байлаа.

Эцэстээ том хүү нь шийдвэр гаргаснаар Дулам, хүүхдүүдээ аваад зугтсан байна. Энэ явдал хөхөө өвлийн хүйтэн шөнөөр болжээ. Самбуу гэртээ согтуу ирж, Дуламыг доромжилж, харааж, чирч,

зодож эхэлсэн байна. Ээжийнхээ амь насанд санаа зовсон том хүү нь тусламжийн 102 дугаарт залгасан байна. Ингэснээр тэд аймгийн төвийн НЦҮТ-өөс тусламж авах болжээ.

Дулам дөрвөн хүүхдийн хамт НЦҮТ-д нэг сар амьдарсан бөгөөд сэтгэл зүйн гэмтлээсээ ангижирч, амьдралаа цаашид үргэлжлүүлэхэд нь туслах олон төрлийн дэмжлэгийг авсан байна. Тэд эрчимт сэтгэл заслын эмчилгээ хийлгэхийн хажуугаар амьдралын ур чадвараа сайжруулахад нь туслах олон төрлийн сургалтад суужээ. Эдгээр сургалт нь тэдний өөртөө итгэх итгэл, өөрийгөө хүндлэх сэтгэлийг сэргээж, харилцаагаа илүү сайн зохицуулж, цаашдын сорилтуудыг даван туулахад туслах үндсэн арга барилд сургасан байна.

Даван туулагчдыг хүчирхийлэлтэй орон гэрээсээ явахад саад болдог эсвэл тусламж авсан хойноо хүчирхийлэл үйлдэгч нарын эрхшээлд буцан очиход хүргэдэг гол хүчин зүйл нь санхүүгийн чадамжгүй байдал гэдгийг ойлгосны үндсэн дээр НЦҮТ Дуламд “Ээжүүдэд зориулсан” хөтөлбөрт хамрагдаж, төгсөх боломж олгосон юм. НЦҮТ мөн хүүхдүүдэд нь туслуулахаар сургуулийн нийгмийн ажилтнууд томилж өгсөн бөгөөд гэрийн багш боловсролын хөтөлбөрт хамруулж, төвд байх хугацаанд хичээл сургуулийг нь завсардуулаагүй байна.

Дулам болон хүүхдүүдэд нь үзүүлсэн дэмжлэгээр зогсохгүй НЦҮТ Самбууд хүртэл өөрийн амьдралаа дахин хяналтдаа авахад нь тусалжээ. Гэр бүлийнхэн нь НЦҮТ-д байрлах зуур Самбуу архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээний эмчилгээнд хамрагдаж, НЦҮТ-ийн сэтгэл засалчтай долоо хоног бүр уулзаж, архины зохисгүй

хэрэглээгээ даван туулахад, мөн гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн хүчирхийлэл үйлдэхэд нь хүргэсэн өөр олон асуудал дээр тусламж авч байсан юм.

Дулам нөхөртэйгөө эргэн эвлэрч, дөрвөн хүүхэддээ амар тайван, эерэг гэр бүл цогцлоож өгөхийн төлөө хамтдаа хичээхээр шийдсэнээс хойш нэг жил орчмын хугацаа өнгөрчээ. Өөртөө итгэх итгэл нь сэргэж, ирээдүйгээ өөдрөгөөр хардаг болсны дээр НЦҮТ-ийн ажилтнуудын тусламж, дэмжлэгийн ачаар Дулам нөхөртэйгөө хамт бизнес эрхлэх төлөвлөгөө гаргах зэрэг боломжуудыг ашиглаж эхэлсэн бөгөөд аймгийн Хөдөлмөр, халамжийн хэлтсийн Амьжиргаа дэмжих хөтөлбөрөөс 6 сая төгрөгийн тэтгэлэг авч чадсан байна. Түүнээс хойш Дулам гэр бүлээрээ модон тавилга үйлдвэрлэдэг хувийн бизнестэй болсон бөгөөд КОВИД-19-ийн цар тахлын улмаас эдийн засаг хямарсан энэ үед ч тэд бизнесээ эрхлэн ажрахгүй амьдарч байна.

Өөрөө туулж өнгөрсөн учраас Дулам орон нутагтаа ЖСХ-ийн талаарх ойлголтыг дээшлүүлэх болон ЖСХ-тэй тэмцэх нөлөөллийн ажлуудад идэвхтэй оролцож эхэлсэн юм. Тэрээр даван туулагчдад нөхцөл байдлаа даван туулахад нь тусалсаар байгаа бөгөөд үүний дүнд 2020 оны 4-р сараас аймгийнхаа нэгэн хувийн эмнэлэгт бүтэн цагийн туслах сувилалчаар ажиллаж эхэлжээ.

Дулам НЦҮТ-тэй холбогдсон туршлагаа нэгтгэн дүгнэж, “Тэд [НЦҮТ-ийн баг] надад амьдрал болон гэрлэлтээ сэргээн босгоход тусалсан. Тэр бүх үйлчилгээ, эмчилгээ байгаагүй бол миний хувьд гэр бүлээ эргүүлэн нэгтгэх ямар ч боломжгүй байх байлаа. Нөхөр маань засарч, гэр бүл маань эргэн нийлсэн болохоор аль аль талдаа хожоотой үйл явдал болсон” гэж ярьсан юм.

«Одоо би өмнөхөөсөө илүү их инээмсэглэдэг болсон. Ирээдүйдээ бат итгэлтэй байгаа. НЦҮТ-ийн багийнхны дэмжлэгтэйгээр би өөрийгөө шинээр нээж, дахин төрсөн юм шиг л санагдаж байна»



## КОВИД-19-ийн үед ЖСХ-ийн даван туулагчдад амьдрал аврах, амин чухал үйлчилгээ үзүүлэх нь

Дуламынх шиг түүхүүд ЖСХ-ийн даван туулагчдад зориулсан үйлчилгээний амьдрал аврах, амин чухал мөн чанарыг батлан харуулж байдаг. КОВИД-19-ийн цар тахлын улмаас дэлхий даяар ихэнх үйл ажиллагаа зогсолтын байдалд ороод байгаа энэ үед ЖСХ, тэр дундаа ГБХ дэлхийн өнцөг булан бүрт сая сая эмэгтэйчүүдэд нөлөөлсөн хэвээр байхын дээр энэ цаг үед нөхцөл байдлыг улам бүр дордуулж байна.

Өдгөө дэгдээд буй цар тахал шиг олон нийтийг хамарсан онц нөхцөл байдлын үед ЖСХ ихэвчлэн өсдөг гэдгийг олон улсын хэмжээний олон судалгаа нотолсон байдаг. Стрессийн түвшин огцом өссөнөөс гадна олон хүн орлогоо гэнэт алдаж, хөл хөдөлгөөн хязгаарлагдаж, хямралаас улбаатай бусад нийгмийн асуудлууд нэмэгдсэнээр жендэрийн тэгш бус байдал өмнөхөөсөө илүү хурцдаж, ЖСХ-ийн гэмт хэрэг өсч байна. Жилийн эхний улирлаас авахуулаад дэлхий даяар ЖСХ болон ГБХ-ийн тохиолдол өссөөр байгаа үзүүлэлттэй байна.

Монгол улс КОВИД-19-ийг дотооддоо дэгдэхээс амжилттай сэргийлж чадсан ч, Монголд ЖСХ-ийн бүртгэгдсэн тохиолдол огцом өссөн юм. КОВИД-19-ийн хөл хорио хамгийн чанга байсан 2020 оны эхний улиралд НҮБХАС-ийн дэмжлэгтэй ажиллаж буй НЦҮТ-д ирсэн үйлчлүүлэгчдийн тоо 2019 оны мөн үетэй харьцуулахад 87%-

иар өссөн үзүүлэлттэй байв. Үүний нэгэн адил Цагдаагийн ерөнхий газраас (ЦЕГ) нийт ГБХ-ийн бүртгэгдсэн тохиолдол 47%-иар өссөн гэж мэдээлсэн бөгөөд энэхүү огцом өсөлт нь ГБХ-ийн жижиг зөрчил хийгээд анх удаа ГБХ үйлдсэн тохиолдол зэрэг зөрчлийн шинжтэй хүчирхийллийн огцом өсөлттэй (62%) холбоотой юм.

Дулам, гэр бүлийн хамт жилийн өмнө тусламж эрж очсон НЦҮТ-ийн ахлах нийгмийн ажилтан 2020 оны 3-р сард өмнөх оны 3-р сартай харьцуулахад үйлчлүүлэгчдийнх нь тоо бараг хоёр дахин өссөнийг ярьж байлаа. Тэрээр хэлэхдээ, “Бид ердийн үеэс илүү олон үйлчлүүлэгч хүлээж авч байна. Сургууль, цэцэрлэг хаагдсанаас болж хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдол бас өсөж байна. Түүнчлэн олон бизнесийн байгууллага үүдээ барьсан учраас стресс болон тодорхой бус байдлаас түгшсэн айдсаа даван туулах гэж илүү олон хүн гэртээ архи уух болсон” гэсэн юм.

Тэрээр мөн КОВИД-19-ийн хөл хорионоос болж олон даван туулагч цаг ямагт гэртээ, хүчирхийлэгчтэй хамт байх болсноор сүүлийн үед хосуудын хоорондын зөрчлийн давтамж болоод далайц нэмэгдэж байна гэж ярьсан юм.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) болон НҮБХАС-аас явуулсан 2017 оны Үндэсний хэмжээний ЖСХ-ийн судалгаанаас үзэхэд Монгол эмэгтэйчүүдийн 60 орчим хувь нь амьдралдаа дор хаяж нэг удаа дотны хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртсөн байгаа бөгөөд 35% нь сүүлийн 12 сарын

хугацаанд дотны хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн байна. КОВИД-19-ийн цар тахал шиг онцгой нөхцөл байдал нь хүчирхийлэлд өртөх эрсдлийг нэмэгдүүлэхээс гадна даван туулагчдад хүчирхийллээс зугтаж, тусламж эрэхэд нэн хүндрэлтэй болгодог.

НЦҮТ-ийн ахлах нийгмийн ажилтан хэлэхдээ, “Манай үйлчлүүлэгч нар КОВИД-19-ийн халдвар авахаас айж байгаа. Гэвч тэд мөн хөл хорио болон эдийн засгийн тодорхой бус байдлаас болж зүдэрч байгаа” гэсэн юм. Гэхдээ энэ айдас хийгээд тодорхой бус байдлыг үйлчилгээ үзүүлэгч нар ч мөн мэдэрч байгаа билээ. Тэрээр цааш үргэлжлүүлэн ярихдаа, “Үйлчилгээ үзүүлэгч нар ЖСХ-ийн даван туулагчдыг амны хаалт зүүгээгүй байвал анхан шатны тусламж үзүүлэхээс их цааргалдаг байсан. Дээрээс нь зөвөрлөгдөн орж ирсэн тохиолдлууд өсөж, хөл хорионы хугацааг сунгах болсноор амны хаалтын үнэ өссөн. Өөрөөр хэлбэл бид амны хаалт худалдаж авч чадахааргүй болсон гэсэн үг” гэсэн юм.

ЖСХ-ийн үйлчилгээ нь амин чухал бөгөөд магадгүй амьдрал аврах боломжтой гэдгийг ойлгосны үндсэн дээр аймгийн НЦҮТ үйлчилгээгээ хүргэх өөр бусад арга замуудыг судалж эхэлсэн байна. НЦҮТ-ийн ахлах нийгмийн ажилтан хэлэхдээ, “Даван туулагчдад зориулсан үйлчилгээ ерөнхийдөө нээлттэй хэвээр байгаа ч одоогоор зөвлөх үйлчилгээний багагүй хувийг онлайнгаар болон утсаар өгч байна. Онлайн зөвлөгөө болон уулзалтууд нь хамтарсан багуудын дунд түгээмэл болсон бөгөөд ингэснээрээ тэд даван туулагчдад

үзүүлэх дэмжлэгээ тасалдуулахгүй ажиллаж чадаж байгаа” гэсэн юм.

Түүнчлэн КОВИД-19-ийн халдвар дотоодод тархахаас сэргийлэх, мөн цар тахлын дагавар үр нөлөө болж үүсдэг нийгмийн олон асуудлаас хүн амыг хамгаалах зорилго бүхий засгийн газрын өөр өөр агентлаг хоорондын хамтын ажиллагааг бүх түвшинд нэмэгдүүлсэн талаар ахлах нийгмийн ажилтан ярьж байлаа. Аймгийн НЦҮТ нь мөн засаг захиргааны хамгийн бага нэгж болох багуудын иргэдийн төлөөлөгчидтэй хамтран ажиллаж байна. Багийн нийгмийн ажилтнууд болон сургуулийн нийгмийн ажилтнууд хариуцсан хэсэг дээрээ эрсдэлтэй айлуудын жагсаалтыг гаргасан бөгөөд НЦҮТ-ийн ажилтнуудтай хамтарч уг айлуудаар орж, авах боломжтой үйлчилгээнүүдийнх нь талаар танилцуулахын зэрэгцээ үл хайхрах хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдүүд болон ГБХ-д өртөх эрсдэлтэй хүмүүсийг шалгасан юм. Энэ санаачилгын үрээр НЦҮТ-ийн ажилтнууд хууль бус хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй гурван хүүхдийг илрүүлжээ. Үүнтэй холбогдуулаад ГБХ болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажил дээр баг болон аймгийн удирдлагуудтай илүү нягт хамтран ажиллахыг багийн цагдаа нараас хүссэн байна.

КОВИД-19-ийн цар тахал дэгдсэн цагаас хойш НҮБХАС Монгол улсын Засгийн газар болон НҮБ-ын бусад агентлагууд, мөн Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА) зэрэг хөгжлийн болон донор байгууллагууд, түүнчлэн Япон улсын Засгийн газартай илүү

ойр хамтран ажиллаж, өсөн нэмэгдэж буй ЖСХ-ийн асуудлын талаарх ойлголтыг дээшлүүлж, энэ цаг үед ЖСХ-ийн үйлчилгээний хүртээмжийг тасалдуулахгүй байж, ЖСХ гарахаас бүр мөсөн сэргийлэхэд туслах эрүүл даван туулах механизмийг дэмжих ажлаа үргэлжлүүлсээр байна.

НҮБХАС алсын зайн зөвлөх үйлчилгээ болон бусад үйлчилгээг 7 хоногийн 24 цагаар шууд утас болон бусад онлайн сувгаар хүргэхийн тулд 2020 оны 3-р сараас хойш Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам (ЭМЯ) болон Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй (ХЭҮТ) хамтран ажиллаж байна. Түүнчлэн НҮБХАС, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран НЦҮТ-ийн ажилтнуудад зориулан КОВИД-19-ийн цар тахлын үед үйлчилгээг тасралтгүй, аюулгүй байдлаар хүргэх зөвлөмж, мөн КОВИД-19-ийн тэргүүн фронтод ажиллаж буй ажилтнуудад зориулан ЖСХ болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах үндсэн зөвлөмжийг боловсруулсан юм.

Монгол улсад КОВИД-19-ийн халдварыг хяналтдаа авах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх зорилгоор засгийн газраас хатуу хяналтын арга хэмжээ авч хэрэгжүүлснээс хойш ЖСХ-ийн тохиолдол огцом өссөнтэй холбоотойгоор 2020 оны 6-р сарын дундуур нийслэл Улаанбаатар хотын Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд хоёр шинэ НЦҮТ байгуулсан билээ. Dignity Kit буюу ариун цэвэр, эрүүл ахуйн багцыг мөн хүнд хэцүү цаг үед хүмүүсийн эрүүл ахуй, өөртөө итгэх итгэл, эрхэм чанарыг хамгаалах, түүнчлэн амин хэрэгцээт зүйлс



дутсанаас болж бэлгийн мөлжлөгт өртөх зэрэг ЖСХ-ийн эрсдэлийг бууруулахад тун хэрэгтэй хангамж болгон тусгаарлалтад байгаа хүмүүс, НЦҮТ-үүд болон түр хамгаалах байруудад түгээсэн юм. Эцэст нь НҮБХАС ЦЕГ-тай хамтран давтагдсан тоогоор 1 сая гаруй хүнд хүрсэн “Хайр Өвтгөдөггүй” гурван сарын хугацаатай үндэсний хэмжээний аяныг зохион байгуулж, дуусаад байна.

Монгол улс дотооддоо халдвар алдаагүй цөөн хэдэн орны нэг хэвээр байна. Засгийн газар ийнхүү халдвараас амжилттай сэргийлж чадаж байгаад НЦҮТ-ийн ахлах нийгмийн ажилтан талархалтай хандаж байгаа хэдий ч вирусийн халдвартай дэлхий даяар тэмцэж буй энэ цаг үед ирээдүйдээ санаа зовнисон хэвээр байгаа юм. Тэрээр хэлэхдээ, “Би үйлчилгээгээ аюулгүй хүргэхийн зэрэгцээ өөрийн эрүүл мэндэд анхаарах хэрэгтэй байгаа ч НЦҮТ-ийн ажилтнуудын хувьд нийгмийн зай барих арга хэмжээ авах ямар ч боломжгүйг ойлгож байгаа. Бид үйлчлүүлэгчидтэйгээ биечлэн уулзах шаардлагатай байдаг” гэсэн юм.

Одоогийн байдлаар тус НЦҮТ-д аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас олгосон хоёрхон багц хувийн хамгаалах хэрэгсэл (PPE) байгаа юм. НЦҮТ-ийн ажилтнууд мөн КОВИД-19-ийн бэлэн байдлын сургалтад хамрагджээ. Үйлчилгээгээ аюулгүй бөгөөд тасралтгүй хүргэхэд юу хамгийн шаардлагатай байгаа талаар түүнээс асуухад тэрээр, “ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, мөн

ажилтнууд болон үйлчлүүлэгчдээ КОВИД-19-өөс хамгаалах нь одоогоор тэргүүн зорилго болж байна. Бид хүчирхийллийн даван туулагчдад, ялангуяа хөл хорио тогтоосон энэ цаг үед, амин чухал үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлсээр байх хэрэгтэй. Гар утасны апп, вебсайт болон телевизийн нэвтрүүлэг зэрэг технологийг ашиглаж алсын зайнаас дэмжлэг үзүүлэх байдлаар хэрэгцээт хүмүүстээ хүрч ажилласаар байх хэрэгтэй” гэсэн юм.



## САРААГИЙН ТҮҮХ

*\*Даван туулагчийг хамгаалах үүднээс нэр болон зарим баримтыг өөрчлөн бичсэн болно.*

Өсвөр насны охин Сараа\*, гэр бүлийнхээ хамт өлмөн зэлмэн, хүндхэн нөхцөл байдалд амьдардаг байв. Сараагийн ээж Алтан\* архаг архичин бөгөөд сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаасаа болж тогтвор суурьшилтай ажил хийж чаддаггүй. Үүний улмаас Сараа дүү, ээж, ээжийнхээ үе үе хамтран амьдардаг хөндлөнгийн эрчүүдээс бүрдэх тэдний гэр бүлийн хувьд ямарч орлогогүй, тогтвортой тайван амьдрах боломжгүй. Түүгээр үл барам, Алтан хүүхдүүддээ анхаарал тавьдаггүй төдийгүй, тэднийг юм сурах чадваргүй, оюуны хомсдолтой гэж итгэсний улмаас Сараа болон түүний дүүг ямар ч албан боловсролд хамруулаагүй байна.

Ядуурлын түвшин өндөр аймгуудын нэгт оршин суух Сараагийн гэр бүл ийм их бэрхшээл сорилт дунд амьдарч байсан тул эмзэг өрх гэж бүртгэгджээ. Энэ нь тэднийг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас (ГБХЗХГ) ядуу өрхүүдийг боловсрол, амьжиргаа болон орон гэрээр дэмжих зорилгоор санаачлан хэрэгжүүлдэг Гэр бүлийн хөгжил дэвшил хөтөлбөрийн (ГБХДХ) 2020 оны хөтөлбөрт хамрагдах боломжтой болгожээ. ГБХДХ-өөс ирэх тусламж нь тэдний гэр бүлийн нийгмийн халамжаас сар бүр авдаг төгрөг болон хүнсний талон дээр нэмэгдэнэ.

Гэсэн хэдий ч, ийм боломж олгосоор байтал тэдний гэр бүлийн амьдралын чанар бараг дээшилсэнгүй. Тухайлбал, нийгмийн халамжаас өгдөг мөнгийг архинд зарцуулдаг төдийгүй удаа дараа дэмжлэг тусалцаа үзүүлж байсан ч амьдралаа сайжруулах бодол огт байсангүй. Аз болоход ГБХЗХГ-ын баг эдгээр бэрхшээлийг үл харгалзан тэдний гэр бүлд үргэлжлүүлэн тусалсаар иржээ. Тэдэнд бүрэн тавилгатай шинэ гэр бэлэглэснээс гадна ГБХЗХГ-ын баг уг өрхийн гишүүдтэй ойр дотно ажиллаж, эрүүл ахуй, гэрийн ажил зэрэг амьдралын суурь ур чадваруудыг зааж, Сараа болон дүүгийнх нь хөгжлийг харилцааны хичээлээр дамжуулан сайжруулахад тусалсаар ирсэн байна.

Ийнхүү тэднийд байнга очдог болсноор ГБХЗХГ-ын баг Сарааг бэлгийн хүчирхийлэлд өртдөг боловч түүнийгээ нууж байгааг олж мэдсэн байна. Багийнхан анхандаа Сарааг зарим үед хойд эцэгтэйгээ хоёулахнаа гэртээ үлддэг гэдгийг мэдээд эрсдэлийн

үнэлгээ хийхээр шийдсэн. Гэвч ээж нь шууд хориглож, Сарааг хөгжлийн хоцрогдолтой учраас өөрийгөө илэрхийлж чадахгүй, бүр худал хэлж ч байж магадгүй гэсэн байна. Багийнхан үнэлгээ хийх хэрэгтэй гэж зүтгэсний хүчинд эцэстээ байдал Алтангийн ярьдгаас тэс ондоо буюу Сараа болон түүний дүү нь сэргээн засаж болох хөгжлийн асуудлаас өөр хөгжлийн хоцрогдолгүй болохыг олж илрүүлсэн. Тэд мөн Сарааг ээжийнхээ хамтран амьдардаг байсан эрчүүдэд хүчиндүүлж ирснийг, мөн Сараа болон дүү нь Алтангийн зүгээс бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд ч өртдөг байж болзошгүйг илрүүлсэн байна.

Ийн мэдсэн даруйдаа ГБХЗХГ-ын баг яаралтай цагдаатай холбогджээ. Энэ үйлдлийг ч мөн Алтан нийгмийн халамжийн дэмжлэгээ алдаж магадгүй гэж санаа зовсний улмаас хориглож Сараагийн сэтгэцийн байдалд итгэх аргагүй гэж зөрүүдэлж эхэлсэн байна. Гэсэн хэдий ч, ГБХЗХГ-ын багийн мэдээллээр цагдаагийн хянан шалгах ажиллагаа эхэлж, улмаар хойд эцгийг баривчилж, ГБХЗХГ-ын багийн саналаар Сараа болон дүүг нь ЖСХ-ийн даван туулагчдад зориулсан аймгийн Нэг цэгийн үйлчилгээний төвд (НЦҮТ) аваачжээ. Үүнийг эсэргүүцсэн Алтан ГБХДХ-ийн тэдэнд туслах санаачилгуудаас татгалзаж эхэлснээр сүүлийн хэдэн сард гараад байсан ахиц дэвшил харамсалтайгаар байхгүй болов.

Алтан хүүхдүүдээ буцааж авна гэж хатуу шаардсаар байсан тул ГБХЗХГ-ын баг арга буюу зөвшөөрч, хүүхдүүдийг гэрт нь буцаан

хүргэсэн. Гэвч Алтангийн биеэ авч явах байдал өөрчлөгдсөнгүй. Хэтрүүлэн уудгаа үргэлжлүүлсээр байсан бөгөөд заримдаа гэртээ эрчүүдийг урьж хамт уудаг байлаа. Нэг удаа бүр Сарааг найзуудтай нь хамт уухыг ятгасан байна. НЦҮТ-ийн баг энэ тухай сонссон даруйдаа тусламж үйлчилгээ үзүүлсээр байжээ.


Үүний дараа НЦҮТ-ийн ажилтнууд болон «хамтарсан баг» (ХБ) Сараа болон дүүгийнх нь аюулгүй байдал хийгээд сайн сайхан байдлыг алсдаа баталгаажуулах алхмуудыг хийсэн байна. Тэд мөн Алтантай ойр ажиллаж, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулснаар зан араншин болон зан үйлд нь өөрчлөлт гарч эхэлсэн. Алтан төв дээр согтуу ирж, агсамнадаг байсан бол хэдэн удаагийн зөвлөгөөний дараагаас эрүүл ирдэг болж, төвийн ажилтнуудтай сайн харилцаа үүсгэж эхэлсэн байна. Алтан мөн Сараагийн төрсөн эцгийг олж чадсанаар НЦҮТ-ийн ажилтнууд өсвөр насны охинд аюулгүй, ая тухтай байдлаар эцэгтэйгээ харилцаа тогтооход нь тусалж эхэлжээ.

ЖСХ-ийн олон талт шинжийг, тэр дундаа ЖСХ-ийн суурь шалтгаан болон өдөөгч хүчин зүйлс, мөн үр нөлөөллийг цогцоор нь авч үзсэний үндсэн дээр аймгийн НЦҮТ нь төрийн болон төрийн бус байгууллага, мөн бизнесийн байгууллагуудтай харилцаа холбоотой байж, тэдний хувьд ихэвчлэн хязгаарлагдмал байдаг нөөц бололцоо

болон чадавхийг нөхөж ажиллахыг зорилгоо болгосон билээ. Аймаг даяар үүсгэсэн энэхүү бат бэх сүлжээ, хамтын ажиллагаа нь НЦҮТ-ийг Сараа болон түүний дүүгийн тохиолдлын нэгэн адил хүчирхийллийн даван туулагчдыг цогц тусламж үйлчилгээ авах боломжоор хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Тухайлбал, НЦҮТ нь залуу даван туулагчдыг боловсролын үйл ажиллагаанд оролцуулж, улмаар сургуульдаа үргэлжлүүлэн явах нөхцөлийг хангах хамтын ажиллагааг асрамжийн төвтэй эхлүүлээд байна. Мөн НЦҮТ-д ирдэг даван туулагч болон хүчирхийлэл үйлдэгчдийн дунд архины хамааралтай хүн олон байдаг учраас НЦҮТ нь гадаадын шашны байгууллагаас ажиллуулдаг архины сэргээн засах эмчилгээний төвтэй холбоотой ажиллаж байна. Өөр нэгэн үйлчлүүлэгчид туслах үедээ ХБ мөн аймаг дахь эмэгтэйчүүдийн онлайн бүлгэм зэрэг нийгмийн бүлгүүдтэй холбогдож, хандив болон бусад үндсэн хэрэгцээт зүйлсийн тусламж хүссэн бол НЦҮТ-

ийн ажилтнууд хүчирхийллийн даван туулагчдад төвөөс явсныхаа дараа амьжиргааны эх үүсвэрээ олоход нь туслахаар орон нутгийн компаниудтай холбогдон ажиллаж байна. ХБ-ууд мөн даван туулагчдыг аймгийн захиргаанаас хэрэгжүүлдэг ГБХДХ болон бусад хөтөлбөрт хамруулах боломжийг үргэлж эрэлхийлдэг. ГБХЗХГ, НЦҮТ болон ХБ-ын гишүүдийн уйгагүй зүтгэл, авхаалж, хөдөлмөрийн дүнд үйлчлүүлэгч нар хүчирхийлэлтэй нөхцөл байдлаас ангижрахад шаардлагатай дэмжлэгийг аваад зогсохгүй, нийгэмдээ эргэн орж, амьдралаа цааш жолоодон явах боломжтой болдог.



## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД ЗОРИУЛСАН НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН БҮТЦЭД НЭГДЭН ИНСТИТУТЧИЛЭГДСЭН АМЖИЛТААС

Иргэн нэг бүрийн, ялангуяа нийгэм дэх хамгийн эмзэг бүлгийнхний эрхийг хүндэтгэж, хамгаалдаг орчныг бүрдүүлэхэд дан ганц хүчирхэг бодлогын тогтолцоо бус, чадавхтай, зүтгэлтэй шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, үйлчилгээ үзүүлэгчид байх шаардлагатай. 2016 оны сүүлээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн (ГБХТТХ) шинэчилсэн найруулгыг баталсан явдал нь жендэрт суурилсан хүчирхийллийн (ЖСХ) даван туулагчдын хувьд хүчирхийллээс өөрсдийгөө болон хайртай хүмүүсээ хамгаалах, болон илааршихад шаардлагатай тусламжийг эрэлхийлэх боломж олгосон чухал үйл явдал болсон юм. ГБХТТХ-ийн шинэчилсэн найруулга батлагдахад Монгол улсад ЖСХ-тэй тэмцэх нь төслийн өргөн хүрээтэй нөлөөллийн үйл ажиллагаа тодорхой хувь нэмрээ оруулсан бөгөөд энэхүү хууль батлагдаж гэр бүлийн хүчирхийллийг (ГБХ) гэмт хэрэгт тооцох болсноос гадна даван туулагчдад нэн шаардлагатай, тэдний амь нас, амьдралыг аврахад

туслах үйлчилгээг үзүүлэх чиглэлээр засгийн газрын чиг үүргийг тодорхойлж өгсөн.

ГБХТТХ-ийн шинэчилсэн найруулга 2017 оны 2 сараас эхлэн хэрэгжсэн тэр үеэс эхлэн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс (ГБХЗХХ) энэхүү хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарч ирсэн. Монгол улсын аймаг, дүүрэг бүрд ГБХ-ийн даван туулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төв эсвэл түр хамгаалах байр болон даван туулагчдад нэн шаардлагатай үйлчилгээг үзүүлэх хамтарсан баг (ХБ) наад зах нь нэг байх ёстой гэсэн хуулийн заалтын дагуу дүүргийн ГБХЗХХ-ээс дүүрэгтээ түр хамгаалах байр барих саналыг Хан-Уул дүүргийн Засаг даргадаа өргөн барьсан юм.

Үнэнийг хэлэхэд, дүүргийн удирдлагууд эхэндээ ЖСХ-д хариу арга хэмжээ авахад хөрөнгө оруулах тал дээр эргэлзэнгүй хандаж байсан ч, ГБХЗХХ-ийн ажилтнууд асуудлыг тууштай тайлбарласаар байсан. Дүүргийн удирдлагуудад эмэгтэйчүүд, хүүхдүүд болон эрэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах хариуцлагыг нь ойлгуулахын зэрэгцээ хуульд заасан даван туулагчдыг хамгаалах механизмийг бий болгохын төлөө нөлөөллийн ажлуудыг хийсээр байсан юм. Эцэст нь дүүргийн Засаг дарга ЖСХ-д хариу арга хэмжээ авах, түүнээс урьдчилан сэргийлэхэд төр чухал үүрэг гүйцэтгэх ёстойг ойлгож, түр хамгаалах байр байгуулах саналыг дэмжсэнээр эхний ээлжинд хохирогчдын түр хамгаалах байрыг байгуулан

нэг жил хиртэй ажиллуулсны дараа ЖСХ-тэй тэмцэх төслийн дэмжлэгтэйгээр ГБХ-ийн хохирогчдод зориулсан НЦҮТ болгон өргөжүүлсэн. Ийнхүү Хан-Уул дүүргийн НЦҮТ 2018 оны сүүлээр үүдээ нээсэн билээ.

ГБХЗХХ-ийн ажилтнууд дүүрэгтээ НЦҮТ байгуулаад зогсохгүй, Засаг даргын дэмжлэгтэйгээр төвийн орон тоог ГБХЗХХ-ийн бүтцэд оруулж чадсан нь маш том амжилт болсон юм. Ингэснээр төвийн ажилтнууд бүгд төрийн албан хаагчийн статустай болж, төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах боломжтой болсноор боловсон хүчний тогтвор суурьшил, ажиллагсдын сэтгэл ханамжид чухал хувь нэмрээ оруулсан. Хан-Уул дүүргийн НЦҮТ бол Монголдоо ийм хэлбэрийн бүтэц зохион байгуулалтад орж, НЦҮТ-ийн үйл ажиллагааг институтчилсэн ганц төв юм.

Даван туулагчидтай ажиллах нь ажиллагсдаас мэргэжлийн хувьд ч, хувь хүний хувьд ч асар их зүйлийг шаарддаг энэ салбарт НЦҮТ-ийн ажилтнууд дээрх хамгаалал, халамжид хамрагдах болсноор ажлын байрны сэтгэл ханамж нь дээшилж, өөр олон төв болон түр хамгаалах байрны үйл ажиллагааг эрсдэлд оруулж байдаг гол үзэгдэл болох ажлын байрны шилжилт хөдөлгөөн багассан байна. Энэхүү боловсон хүчний тогтвор суурьшил даван туулагчдад үйлчилгээ үзүүлэхэд нэн чухал ач холбогдолтой. Учир нь даван туулагчийн итгэлийг олоход цаг хугацаа, хүчин зүтгэл шаардлагатай. Мөн даван туулагчаас өөр өөр ажилтнууд ахин дахин болсон явдлыг нь асууж яриулаад байвал сэтгэлийн гэмтлийг нь

сэдрээх магадлалтай байдаг. Түүнчлэн энэхүү салбарт ажиллан хүчирхийллийн хохирогчдод шаардлагатай бүхий л үйлчилгээг тэдний онцлогт тохируулан үр дүнтэй үзүүлэхийн тулд олон жилийн туршлага, мэдлэг шаардагддаг. Тийм учраас үе шаттай сургалтуудад хамрагдаж, туршлага хуримтлуулсан мэргэжилтнүүдийг олон жил тогтвортой ажиллуулах нь хүчирхийллийн даван туулагчдад чанартай үйлчилгээ үзүүлэхийн гол үндэс болно. Энэ чиглэлд Хан-Уул дүүргийн НЦҮТ-ийг ГБХЗХХ-ийн бүтцэд оруулан институтчилсэн нь чухал ач холбогдолтой туршлага юм.

Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн НЦҮТ-ийн ахлах мэргэжилтэн, «Даван туулагчдад нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг төрийн албан хаагчийн хувьд нэг цэгээс олон салбарын үйлчилгээг үзүүлэхийн ач холбогдлыг шийдвэр гаргагчдад ойлгуулах хүчин чармайлтыг байнга гаргаж байх хэрэгтэй. Манай нөлөөллийн ажлын ачаар бид ГБХЗХХ-ийн дэргэд даван туулагчдыг хамгаалах тогтолцоотой болж чадлаа. Энэ нь бидний хувьд үйл ажиллагааны зардлаа хаанаас санхүүжүүлэх вэ гэж байнга санаа зовохын оронд ажилтнуудынхаа чадавхийг бэхжүүлж, үйлчлүүлэгчиддээ боломжит хамгийн сайн үйлчилгээг үзүүлэхэд бүх анхаарлаа хандуулах боломжийг олгож байна» гэж ярьсан юм.

## АРИУНАА, ТУУЛ ХОЁРЫН ТҮҮХ

*\*Даван туулагчийг хамгаалах үүднээс нэр болон зарим баримтыг өөрчлөн бичсэн болно.*

Жендэрт суурилсан хүчирхийллийн (ЖСХ) суурь шалтгаан нь жендэрийн талаарх буруу хандлага, итгэл үнэмшил, түүнээс үүдэлтэй хүйс хооронд хийгээд хүйс дундын хүчний болон эрх мэдлийн тэнцвэргүй байдал мөн боловч эл асуудлыг хурцатгагч нь ядуурал зэрэг нийгэм дахиныг нөмөрсөн өвчлөл байдаг гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрөх болсон. Монгол улсын зарим бүс нутгуудад ядуурлын түвшин өндөр байгаа нь ЖСХ-ийн гаралт өндөр байхад нөлөөлж байна. Тэр дундаа, гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ) илүүтэй зонхилж байна.

2018 онд нийтлэгдсэн Үндэсний хэмжээний ЖСХ-ийн судалгаанаас үзэхэд дотны хамтрагчийн зүгээс үйлдсэн ЖСХ-ийн аливаа хэлбэрт амьдралынхаа аль нэг үед өртсөн (улсын дундаж болох 57.9%-тай харьцуулахад 68.6%) болон сүүлийн 12 сард өртсөн хүмүүсийн эзлэх хувиар (улсын дундаж болох 35%-тай харьцуулахад 45.4%) ... аймаг тэргүүлж байна. Тус аймаг мөн эцэг эх, ах дүү, төрөл төрөгсөд, найз нөхөд болон огт танихгүй хүн зэрэг хамтрагч бус хүний зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэл (16.9%) болон бэлгийн хүчирхийлэлд (16.4%) амьдралдаа өртсөн хүмүүсийн эзлэх хувиар улсдаа дөрөвт орж байна.

Эдгээр түгшүүр төрүүлсэн тоон үзүүлэлтүүд нь энэхүү аймгийг Монгол улсад ЖСХ-тэй тэмцэх нь төслийн 1-р шатны хэрэгжилтийн үед онцлон ажиллах газраар сонгох шалтгаан болсон. Онцлон ажиллах газар болохын хувьд аймгийн удирдлагуудад 2018 оны 11-р сард ЖСХ/ГБХ-ийн даван туулагчдад үйлчилгээ үзүүлэх “хамтарсан багууд” болон Нэг цэгийн үйлчилгээний төвийг (НЦҮТ) байгуулах зэргээр даван туулагчийг хамгаалах, шаардлагатай үйлчилгээ, хариу арга хэмжээ авах механизмийг бий болгох, ажиллагсдын чадавхийг бэхжүүлэхэд нь санхүүгийн болон техникийн олон талт дэмжлэг үзүүлсэн. Мөн төслийн дэмжлэгтэйгээр засгийн газраас ЖСХ-ийн асуудал, түүнийг илрүүлэх болон хариу арга хэмжээ авах талаар НЦҮТ-ийн ажилтнуудад болон үйлчилгээ үзүүлэгчдэд сургалт явуулсаар байна. Уг сургалтад одоогоор ажиллаж буй хоёр нийгмийн ажилтан, нэг сэтгэл зүйч, нэг нийгмийн хамгааллын ажилтан болон хамтарсан багийн гишүүд хамрагдсан юм.

ЖСХ/ГБХ-ийн эсрэг арга хэмжээ авахад бүх салбарын үүрэг хүлээгчдийг оролцуулан хамтын ажиллагааг бэхжүүлэхийн ач холбогдолыг Туул\* болон түүний охин дүү Ариунаа\* нарын түүхээс тодорхой харж болно. Өсвөр насны энэ хоёр охин өөр өөр газар буюу Ариунаа эмээгийн дээ, Туул ээжтэйгээ хамт амьдардаг байжээ. Гэвч тэр хоёр өсөж том болох явцдаа адилхан сэтгэл санааны гүн гэмтэл авсан байна. Аль аль нь өсөж торниход нь халамжилж, хамгаалах учиртай байсан асран хамгаалагчийнхаа хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийллийн хохирогч болжээ. Туул, Ариунаа хоёр хоёулаа туулж ирсэн зовлонгоо бусдад ярихаас айсандаа нууж байсан учраас хүчирхийлэл олон жил үргэлжилсэн байна. Хүчирхийлэл жаахан охидын сэтгэцийн эрүүл мэндэд асар их хохирол учруулж, Туул бүр амиа егүүтгэх талаар бодох болж, амиа хорлохыг завджээ.

Сургуулийн эрүүл мэндийн ээлжит үзлэгээр л сургуулийн багш нар үүнийг мэдсэнээр уг гэр бүлийн насанд хүрсэн гишүүнд мэдээлсэн байна. Охид насанд хүрээгүй байсан учраас сургуулийн эмч уг хэргийг орон нутгийн цагдаагийн газарт мэдэгдэх үүргийнхээ дагуу мэдээлснээр цагдаагийн газраас хянан шалгах ажиллагааг эхлүүлж, хэргийг улмаар аймгийн цагдаагийн газарт шилжүүлжээ. Орон нутгийн цагдаагийн газраас хэргийг хянан шалгах явцад нууцлалыг хадгалах шаардлагатай арга хэмжээнүүдийг авч, аймгийн төвийн НЦҮТ-д хүргэсэн.

Аймгийн цагдаагийн газраас хэргийг шалгаж үзээд хүчирхийлэл үйлдэгчдийг баривчилж, хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлжээ. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын (ГБХЗХГ) санхүүгийн дэмжлэгээр Туул, Ариунаа хоёр шүүх хурал дээр хоёр өмгөөлөгч болон аймгийн ГБХЗХГ-аас томилсон нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээг авах боломжтой болсон юм. Үүний дүнд гэмт хэрэгтнүүдийн Ариунаа болон Туулын эсрэг үйлдсэн хүчирхийллийн гэмт хэрэгт нь тус тус 18, 12 жилийн хорих ял оноожээ.

Үүний дараа ГБХЗГ-ын болон НЦҮТ-ийн ажилтнууд Туул, Ариунаа хоёрыг хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүүхэд хамгааллын төвтэй холбож өгсөн ба тэд тэнд 3 сарын турш байрлаж, ЖСХ-тэй тэмцэх нь төслийн түнш болох Хөөрхөн Зүрх ТББ-ын сэтгэл зүйн зөвлөгөө тусламж үйлчилгээг үргэлжлүүлэн авсан юм. Охидыг гэртээ харьж болох хэмжээнд эдгэрсний дараа буцаан аймгийн НЦҮТ-д авчирсан бөгөөд аймгийн ГБХЗХГ-аас охидын талаарх мэдээ сумын иргэдийн дунд тархсан байсан тул охидыг цаашдын эрсдэлээс хамгаалахын тулд гэр бүлийнхэн нь бүгдээрээ аймгийн төврүү нүүсэн тухай олж мэдсэн байна.



НЦҮТ-ийн ажилтнууд болон аймгийн ГБХЗХГ-ын ажилтнууд охидыг НЦҮТ-өөс явж гэртээ харьсных нь дараа ч гэсэн гэр бүлд нь амьдралаа шинээр эхлүүлэхэд нь үргэлжлүүлэн тусалсаар байв. НЦҮТ-ийн ажилтнуудын тусламжтайгаар тэд орон байртай болж мөн хүүхдүүдийн төрсөн эцгээс шүүхийн шийдвэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх болсон байна.

Туул, Ариунаа хоёр сургуулиа төгсөхийн зэрэгцээ нийгэм-сэтгэлзүйн дэмжлэгийг үргэлжлүүлэн авсаар байгаа. Туул одоо ирээдүйдээ итгэдэг болсон бөгөөд хэзээ нэгэн өдөр үсчин болж, гэр бүлдээ нэмэр болох мөрөөдөлтэй болсон.



## НЦҮТ-ҮҮД ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ДАВАН ТУУЛАГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАН, ИТГЭЛ НАЙДВАРЫГ НЬ СЭРГЭЭЖ БАЙНА: САРААГИЙН ТҮҮХ

*\*Даван туулагчийг хамгаалах үүднээс нэр болон зарим баримтыг өөрчлөн бичсэн болно.*

Төрсөн нутгаасаа Улаанбаатар хотод анх ирэхдээ, Сараа\* итгэл найдвар, хүсэл мөрөөдлөөр дүүрэн, сэргэлэн залуу бүсгүй байлаа. Гэрийнхэн дотроосоо их сургуульд суралцаж байгаа эхний хүн байсан учраас эл амжилтаараа бахархахын сацуу гэр бүлийнхнийхээ өмнө хүлээсэн хариуцлагаа биелүүлж, итгэлийг нь алдахгүй гэсэн багахан дарамтыг бас мэдэрч байв. Сараа сургуульдаа явж завгүй байхын зэрэгцээ нийслэл хотын түмэн сонголт, мянган боломжийг үзээд гайхан догдолж байлаа. Гэвч Сараа өдөр бүр төрсөн нутгаа санагалзаж байсан юм. Хот төрсөн нутаг шиг нь санагдахгүй л байлаа. Хотод сургуулийн багшаар ажилд орж, өөрийн гэсэн амьдрах газартай болсон ч гэртээ байгаа юм шиг мэдрэмж төрөхгүй байв.

Хэд хэдэн удаа болзоонд явж үзсэн ч огт өөр гаралтай, нийтлэг үнэт зүйлгүй хүнтэй сэтгэлээ нээж харилцаж чадахгүй байжээ.

Төрсөн нутгаа санагалзсан сэтгэл нь адилхан байсан учраас нутгийн залуу Болдоотой\* танилцсан даруйдаа ойлголцож, үерхэж эхэлжээ. Эхнэр нь нас барж, нялх хүүхдээ ганцаараа өсгөх болсон тэр үед Болдоо Сараатай танилцсан байна. Болдоогийн амьдралын нөхцөл байдал тун эмзэг байсны дээр Сараагийн нэгэн адил төрсөн нутгаа санан бэтгэрч байсан учраас Болдоо Сараа хоёр бүр дотносох болжээ. Сараа Болдоотой хамт амьдарч, хүүхдээ өсгөх хариуцлагыг нь хуваалцана гэдэгтэй итгэлтэй бөгөөд бэлэн байсан байна. Анх уулзсанаасаа хойш хэдхэн сарын дараа Сараа Болдоо хоёр гэрлэж, төрсөн нутагруугаа хамтын амьдралаа зохиохоор явжээ.

Харамсалтай нь амьдрал тэдний санасан шиг хялбар байсангүй. Боловсролын дипломтой байсан ч Болдоо ажил олох гэж нэлээн зүдэрч байв. Харин Сараа гэртээ үлдэж, хүүхдээ асрах болжээ. Амьдралын энэ хэцүү байдлыг даван туулахад бэлэн биш байсан нь Болдоог архи ууж эхлэхэд хүргэж, төд удалгүй Сараагийн мэддэг байснаас огт өөр хүн болж хувирч эхэлсэн байна. Хүүхдээ арай чүү тэжээх хэмжээнд амьдарч байсан учраас Сараа ажил хайж эхэлжээ. Болдоо Сарааг гэртээ байх хэрэгтэй гэж ятгаж байсан ч Сараа ажил хийж эхэлсэн байна.

Чухам л Сараа ажил хийж эхэлсэн энэ үед хүчирхийлэл эхэлжээ.

Болдоо Сарааг хардаж эхэлсэн бөгөөд эцэстээ цохиж, зодож эхэлжээ. Сараагийн доторх хүсэл мөрөөдлөөр дүүрэн Улаанбаатар хотод ирж байсан итгэл төгс залуу бүсгүй байхгүй болсон байлаа. Сараа айдсаар дүүрэн амьдарч, хүчирхийлэгч нөхрөөсөө зугтах боломжгүй гэдэгт бүрэн итгэсэн байсан юм. Хийсэн сонголтдоо өөрийгөө буруутгах болж, өөрийн муугаас л ингэж амьдарч байна гэж ташаа бодох болжээ. Зарим үед амиа хорлох тухай хүртэл бодол төрж байсан ч хүүхдээ хайрлах хайр нь дийлж байсан учраас тэр бодлоо орхин бэрхшээлээ даваад гардаг байв. Хүүхдээ дахиад жаахан том болтол нь хүлээж байгаад дахин ажил хайж эхэлсэн байна. Гэвч бие давхар болсноо мэдсэнээр энэ төлөвлөгөө нь нуржээ. Итгэл найдвараа алдахын оронд Сараа шинэ төрөх хүүхэд нь Болдоотой харилцах харилцааг нь сайжруулна гэж итгэж байлаа. Гэвч ер тийм зүйл болсонгүй.

Хүчирхийлэл өдөр өнгөрөх бүрд дордож, сүүлдээ аргаа барсан Сараа цагдаа дууддаг болсон ч, мөрдөн шалгах ажиллагаа эцсээ хүртэл үргэлжилдэггүй байжээ. Гэхдээ нэг өдөр хүчирхийлэл тэвчихийн аргагүй цэгт хүрэх үед Сараа түүний тэвчээр энд хүрээд дуусч байгааг ухааран цагдаагийн газарт очиж, Болдоогийн үйлдлүүдийн мөрөөр мөрдөн шалгуулахаар өргөдөл гаргасан байна. Үүний дүнд цагдаагийн газраас ГБХ-ийн асуудал хариуцсан цагдаа Болдоогийн гэр бүлийг шалгаж, эрсдэлийн нөхцөл байдлыг нь өндөр эрсдэлтэй гэж дүгнэсэн учраас Сарааг хоёр хүүхдийнх нь хамт Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй (ЖСХ) тэмцэх нь төслийн шугамаар 2018 онд байгуулагдсан ЖСХ-ийн даван туулагчдад

зориулсан Нэг цэгийн үйлчилгээний төвд (НЦҮТ) аваачсан байна. НЦҮТ-д байрлаж, аюулгүй байдлаа хамгаалуулахын зэрэгцээ төрөл бүрийн үйлчилгээ авах болсноор Сараагийн итгэл найдвар дахин сэргэж эхэлжээ. Тэрээр хүчирхийлэлтэй харилцаандаа цэг тавьснаар амьдрал нь тайван болж, сэтгэл санаа амарсан бөгөөд төвийн ажиллагсдын зүгээс үзүүлсэн олон үйлчилгээний үр дүнд нөхцөл байдлыг бодитойгоор дүгнэн цэгнэх боломжтой болсноор гэр бүлээ цуцлуулах өргөдөл өгөх шийдвэрийг гаргасан байна. Үүний дүнд хүүхдүүдтэйгээ хамт үргэлжлүүлэн өөрийн хүчээр амьдрах боломжтой болжээ.

Сараа хоёр хүүхдээ ганцаараа өсгөж чадах эсэхдээ үе үе эргэлзэж байсан ч НЦҮТ-өөс дэмжлэг авсны хүчинд өөртөө итгэх итгэл нь сэргэсэн юм. Төвд байх хугацаандаа ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөнд суухын хажуугаар бие сэтгэлийн гэмтлээ эдгээж, нөхөн сэргээж чадсан бөгөөд амьдрах ухааны чадавхаа сэргээхэд нь туслах дэмжих бүлгийн уулзалтуудад ч суужээ. Сараа мөн үнэгүй хууль эрх зүйн зөвлөгөө авч байсан бөгөөд нөхөн сэргэх үйл явцад нь туслах эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж байсан байна.


Сараагийн түүх хүчирхийллийн олон даван туулагчийн түүхийг төлөөлж чадна. ЖСХ, тэр дундаа дотны хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл нь даван туулагчдыг хяхаж, өөрийн давуу тал хийгээд үнэ цэнийг олж харж чадахааргүй харанхуйд түгжиж, улмаар хүчирхийллээс өөрийн хүслээр салахад нь саад болдог. Дотны хамтрагчийн зүгээс үйлдэгддэг хүчирхийлэл нь зөвхөн

бага орлоготой гэр бүлд эсвэл боловсрол муу хосуудад тохиолддог гэсэн түгээмэл буруу ойлголт бий. Гэхдээ бодит байдал дээр, хүчирхийллийг Болдоо шиг дээд боловсролтой хүмүүс хүртэл үйлдэх эсвэл хохирогч нь болох боломжтой юм.

Дотны хамтрагчийн зүгээс үйлдэх хүчирхийллийн уг шалтгаан нь нэг нь нөгөөгөө хүчирхийллээр хянаж өөрийн эрхшээлд оруулах замаар хүссэнээрээ удирдахыг зорьдог эрх мэдлийн тэнцвэргүй байдал, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн талаарх нийгмийн сөрөг итгэл үнэмшил, жендэрийн хэвшмэл буруу ойлголт (стереотип), мөн аливаа хүний жендэр болон хүйсийн талаарх сөрөг хандлага болон буруу ойлголт байдаг. Сараа, Болдоо хоёрын харилцааны хувьд, энэ бүх шалтгаан архидан согтууралт, ядуурал болон ажилгүйдлээр хурцадсан байна.

НЦҮТ-ийн үйлчилгээ болон дэмжлэгийн ачаар Сараа өөртөө болон ирээдүйдээ итгэх итгэлээ эргүүлэн олж авсан юм. Сараа ур чадвараа хөгжүүлэх урам зоригтой болсноос гадна, хамгийн гол нь, өөртөө итгэлтэй болсон байна. Өөрийн шаргуу зүтгэл болон ойр тойрны хүмүүсийнхээ дэмжлэгтэйгээр ийн чадавхжсан байдлаа Сараа алдалгүй хадгалах нь тун чухал. Ялангуяа НЦҮТ-ийн хууль эрх зүйн дэмжлэгтэйгээр нөхрөөсөө салахдаа хоёр хүүхэддээ орон байрыг нь авч үлдэж чадсан нь тэднийг амьдралаа хэвийн үргэлжлүүлэхэд чухал түлхэц болсон. Сараа одоо өөрийн байранд хоёр хүүхдийн хамт аз жаргалтай амьдарч байгаа бөгөөд аймгийнхаа нэгэн албан газарт бүтэн цагийн ажилтай болжээ.

Ажлын эхний өдрөө л гэхэд Сараа анх Улаанбаатар хотод гэрэлт ирээдүйгээ бүтээхээр ирж байсан залуу бүсгүй байсан үеийнхтэйгээ нэгэн адил догдлол, итгэл найдварыг мэдэрч байлаа.



## ЦАР ТАХЛЫН ИД ҮЕД АМЬДРАЛ АВРАХ ҮЙЛЧИЛГЭЭ: ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ТҮҮХ

Орон даяар байгуулагдсан Нэг цэгийн үйлчилгээний төвүүд (НЦҮТ) болон түр хамгаалах байрууд нь гэртээ хүчирхийллийн орчинд амьдарч буй эмэгтэйчүүд, хүүхдүүд болон эрэгтэйчүүдийн хувьд амьдрах уу, эс амьдрах уу гэдгийг нь хүртэл шийдвэрлэх нөлөөтэй байна.

НЦҮТ-үүд хийгээд түр хамгаалах байрууд нь жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) болон гэр бүлийн хүчирхийллийн (ГБХ) даван туулагчдыг аюулгүй, хамгаалалттай орон байр төдийгүй эрүүл мэндийн, нийгэм-сэтгэлзүйн болон эрх зүйн, мөн бусад шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах зэрэг амин чухал үйлчилгээг үзүүлдэг. Цаг үеийн байдал тогтуун үед эдгээр үйлчилгээ нь даван туулагчдад хүчирхийлэлтэй орон гэрээс зугтаж, бие сэтгэлээ анагаах бэрх аялалд нь том дэмжлэг болдог. Харин цар тахлын үе зэрэг онц байдал зарласан нөхцөлд нийгмийг хамарсан хямрал нь хүчирхийллийн шинэ өдөөгчдийг бий болгоод зогсохгүй хүчирхийлэлд өртөгсдийг тусламж эрэхэд нэн хүндрэлтэй болгож, ЖСХ-ийн нөхцөл байдлыг хурцатгадаг учраас эл үйлчилгээ бүр илүү чухал болдог.

Монгол улсын Засгийн газрын КОВИД-19-ийн эрүүл мэндэд учруулах хямралаас сэргийлэх хатуу арга хэмжээ ихээхэн амжилттай байгаа боловч цар тахлын улмаас дэлхийн бусад орнуудад нүүрлээд байгаа нийгэм, эдийн засгийн нөлөөллийг Монгол улс тойрч гарах боломжгүй юм. Цар тахлын талаар дэлхий дахин ойлгож эхэлж, сэргийлэх арга хэмжээг хамгийн өндөржүүлсэн байдлаар авч байсан оны эхний хагаст гэхэд ЖСХ-ийн тохиолдол өмнөх оны мөн үетэй харьцуулахад огцом өссөн (30%-иар өссөн) үзүүлэлттэй байна.

“[Хэсэгчилсэн] хөл хорио тогтоосноор илүү олон хүн гэртээ суух болсон бөгөөд тэдний багагүй хувь нь өөр хийх ажил байхгүй юм чинь гээд ууж согтуурдаг болсон. Энэ нь тэр бүр илрээд байдаггүй

ГБХ-ийг гааруулж байна. Тухайлбал, цар тахал гарахаас өмнө өрхийн эмч, сургуулийн багш эсвэл орон нутгийн нийгмийн ажилтан нь хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүүхэдтэй тогтмол харилцах үедээ хүчирхийллийн шинж тэмдгийг олж илрүүлэх боломжтой байлаа. Гэвч хөл хорио тогтоосноор тэдгээр хохирогчдыг илрүүлж, тусламж үзүүлэхэд нэн бэрх болж байна” гэж Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн (ХЭҮТ) түр хамгаалах байрны нийгмийн ажилтан хэлсэн юм.

ХЭҮТ нь ЖСХ болон ГБХ-ийн асуудал дээр ажилладаг гол төрийн бус байгууллага бөгөөд Монгол улсад ЖСХ-тэй тэмцэх нь төслийг хэрэгжүүлж эхэлсэн цагаас хойш чухал түнш байсаар ирсэн билээ. ХЭҮТ-ийн Баянхонгор аймаг дахь салбарын дэргэдэх НЦҮТ болон Улаанбаатар хотод байрлах түр хамгаалах байруудад төслийн зүгээс дэмжлэг үзүүлэн ажилласан. Цар тахал дэгдсэнээс хойш уг төвүүдэд тусламж эрж ирэх үйлчлүүлэгчийн тоо эрс нэмэгдсэний зэрэгцээ шууд утсаар ирэх дуудлагын тоо өсөж, тэд энэ бүх эрэлтийг хангаж ажиллах боломжгүй болсон юм.

Цар тахлаас үүдсэн эдийн засгийн хямрал нь мөн ЖСХ-ийн тохиолдол нэмэгдэхэд нөлөө үзүүлсэн. ХЭҮТ-ийн шинэ үйлчлүүлэгчдийн багагүй хувь нь саяхан ажлаа алдсан эмэгтэйчүүд байсан байна. Ажилгүйдэл нэмэгдэхтэй зэрэгцээд үнэ өсөж, өрхийн хэрэглээ хумигдсанаар айл гэрийн уур амьсгал тогтворгүйтэж, олон даван туулагчдыг хүчирхийлэгч хамтрагчаасаа улам бүр хараат болгоход хүргэж байна. ХЭҮТ-өөс мөн өсвөр насны охид болон

хүүхдүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нэмэгдсээр байгааг цохон тэмдэглэсэн юм. Сургуулиудыг удаан хугацаанд хааснаар хүүхдүүд гэртээ ганцаараа үлдэх эсвэл хөдөө орон нутагт байдаг холын хамаатныдаа очих болсон нь тэдний хүчирхийлэлд өртөх эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Шинээр ирэх үйлчлүүлэгчдийн тоо өсөхийн зэрэгцээ цар тахлын улмаас хувийн болон ажил мэргэжлийн амьдрал нь тодорхой бус байдалд орсон энэ цаг үед НЦҮТ-үүд болон түр хамгаалах байрнуудын үйлчилгээ үзүүлэгчид энэхүү амин чухал, амьдрал аврах үйлчилгээгээ тасалдуулалгүй үзүүлэхийн сацуу үйлчлүүлэгчид болон өөрсдийгөө халдварт өвчнөөс хамгаалах хоёрыг тэнцвэржүүлэх гэдэг бэрхшээлтэй нүүр тулаад байна. Тухайлбал, цар тахлын эхэн үед ЖСХ-ийн даван туулагчдад зориулсан НЦҮТ-үүд болон түр хамгаалах байрнууд зэрэг тусламж үйлчилгээний байгууллагууд нь COVID-19-ийн халдвараас сэргийлж, шинээр үйлчлүүлэгч хүлээн авахаас татгалзаж байв. Улаанбаатар хот дахь ХЭҮТ-ийн ажилтан хэлэхдээ олноор цуглах болон шилжилт хөдөлгөөн хийхийг хатуу хориглосноор даван туулагчдад хэрэгтэй үйлчилгээг нь үзүүлэх, цаашлаад хэргийг нь шийдвэрлэх ажил удаашралтай болсон гэсэн юм. НЦҮТ болон түр хамгаалах байрны ажилтнууд үйлчлүүлэгчдээ эрүүл мэндийн төв, цагдаагийн газар болон төрийн байгууллагуу явахад нь хамт явах боломжгүй байснаас гадна хамтарсан багууд болон бусад үйлчилгээ үзүүлэгч хоорондын уулзалтуудыг хойшлуулах шаардлагатай болсон байна.

Өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицохын тулд ХЭҮТ шууд утасныхаа ажиллах цагийг төслийн дэмжлэгтэйгээр сунгасан юм. Одоогоор шууд утас нь өдөр бүр, 24 цагийн турш ажиллаж, даван туулагчдад мэдээлэл өгөхөөс гадна шаардлагатай үед хямралын үеийн зөвлөгөө өгч ажиллаж байна. КОВИД-19-ийн цар тахлын үед НЦҮТ-үүд болон түр хамгаалах байрнуудын үйлчилгээ үзүүлэх удирдамжтай болсноор ХЭҮТ үйлчилгээгээ, ялангуяа дотоод халдвар тархсан тохиолдолд, тасралтгүй, аюулгүй байдлаар үргэлжлүүлэн үзүүлсээр байхад ажилтнууд болон материаллаг баазаа бэлдэж чаджээ. ХЭҮТ-өөс мөн өөрийн төвүүдийг амны хаалт, бээлий зэрэг хувийн хамгаалах хэрэгсэл болон эрүүл ахуй, ариутгалын хэрэгслээр хангасан байна. Даван туулагч төвтэй энэ

бүх санаачилгыг ХЭҮТ-ийн ажилтнууд цар тахлын улмаас өөрсдийнх нь болон гэр бүлийнхнийх нь амь нас эрсдэлд орж байсан ч энэ тэргүүний зорилгоо болгон ажилласаар байна.

ХЭҮТ-ийн түр хамгаалах байрны нийгмийн ажилтан мөн хэлэхдээ, «ЖСХ-ийн даван туулагчдыг би ер нь дайны тэргүүн фронт шиг нөхцөлд амьдарч байгаа хүмүүс гэж боддог. Энэ цар тахлын үе шиг хямралын нөхцөлд миний хэлж байгаа бүр үнэн болно. Бид үйлчилгээ үзүүлэгчийн хувиар дайны бүсээс холуур тойрохын зэрэгцээ тэдгээр хүмүүст амьдралдаа амар амгаланг олоход нь туслах үүрэгтэй» гэсэн юм.

**ГЭР БҮЛД МАШ ОЛОН АСУУДАЛ ТУЛГАРДАГ.  
ХЭРЭВ ТА БУХИМДАЖ, ХЭЦҮҮ БАЙДАЛД БАЙГАА БОЛ  
ТУСЛАМЖ ХҮСЭХЭЭС САНАА ЗОВОХ ХЭРЭГГҮЙ.**

**ТА ГЭР БҮЛИЙН БОЛОН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД  
ӨРТСӨН БОЛОН ӨРТӨЖ БОЛЗОШГҮЙ БОЛ:**



**Үнэ төлбөргүй**  
(таны утас нэгжгүй байсан ч залгах боломжтой)

**24 цаг / 7 хоног**

**ТАНЫ НУУЦЛАЛЫГ ЧАНДЛАН ХАДГАЛНА.**

## УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ОГЦОМ ӨСӨЛТИЙН ҮЕД ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРДЛЭХ НЬ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТУРШЛАГА

Сүүлийн арван жилд Монгол улсын эдийн засаг олборлох салбарын огцом өсөлтийн үр дүнд ихээхэн өссөн сайн үзүүлэлттэй байгаа юм. Дэлхий дээрх мэдэгдэж буй нүүрсний нөөцийн 10%-ийг агуулдаг, мөн алт, зэсийн ихээхэн нөөцтэй Монгол улс дотоодын болон гадаадын олборлох үйлдвэрлэлийн компаниудын анхаарлыг татаж, том, жижиг уул уурхайн үйл ажиллагаа огцом нэмэгдсэнээр хурдтай боловч тогтворгүй эдийн засгийн өсөлтийг авчирч, эдийн засаг даруй 20 гаруй хувиар өсөж эхэлсэн юм.

- 1 Изабел Кэйн, А.Тэрбиш, О.Бямбасүрэн (2014), "Монголын Уурхайн салбар дахь Жендэрт Суурилсан Хүчирхийлэл ба Уул Уурхайн Дэд Бүтцийн Зураглал"
- 2 Үндэсний Статистикийн Хороо, НУБХАС (2018), "Хүчирхийллийн нүцгэн үнэн: Монгол улс дахь Жендэрт Суурилсан Хүчирхийллийн Үндэсний Хэмжээний Судалгаа – 2017"

Монгол улс дахь уул уурхайн салбарын огцом өсөлтийн эдийн засагт үзүүлэх үр нөлөө нь хэдийгээр эерэг байсаар ирсэн ч хүн амын нийгэм-соёлын амьдралд үзүүлэх үр нөлөөллийн талаархи судалгаагаар ЖСХ, түүний дотор Гэр бүлийн хүчирхийлэл өсөхөд нөлөөлж буй нь тогтоогджээ<sup>1</sup>. Аливаа салбарын огцом өсөлт ихэвчлэн нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийг дагуулдаг. Тухайлбал, хурдтай үйлдвэржилт болон хүн амын олноор түр шилжин суурьших хөдөлгөөн нь орон нутгийн соёл, хүн амын амьжиргааны хэвийн байдалд ихээхэн нөлөөлдөг. Энэ асуудал нь уул уурхайн компаниудын үйл ажиллагааны нарийн төвөгтэй ажлын нөхцөл, ялангуяа 21 хоног ажиллаад 7 хоног амрах хөдөлмөрийн хуваарьтай хосолсноор гэр бүлийн харилцаанд өөрчлөлт оруулахын зэрэгцээ стресс тайлах нэрийдлээр архидан согтуурах үзэгдлийг ихсэхэд нөлөөлж байна.

Эрдэс баялгийн нөөц арвинтай Өмнөговь аймаг сүүлийн арван жилд уул уурхайн салбарын огцом өсөлтийн гол төв болж байна. Монгол орны Говь цөлийн өмнөд хэсгийг эзлэн 165,380 ам дөрвөлжин километр газар нутагт оршдог Өмнөговь аймаг нь Монголын хамгийн том аймаг бөгөөд хүн ам нь бараг 70,000 хүрч байна. Үүний дотор голчлон уул уурхайн салбарт ажиллахаар түр шилжин суурьшигч хүн ам багагүй байгаа юм. Өмнөговь аймаг нь мөн амьдралынхаа аль нэг үед дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн үзүүлэлтээр (63.3%<sup>2</sup>) улсдаа гуравдугаарт орсон юм. Энэ асуудлыг Өмнөговь аймаг дахь ЖСХ-ийн даван туулагчидтай ажилладаг мэргэжилтнүүд уул уурхайн салбарын огцом өсөлттэй холбож үзэж байна.



Тусламж эрж ирсэн олон олон даван туулагчид нөхөр нь уурхайд ажилладаг бөгөөд олон өдрийн ээлжээ дуусгаад гэртээ ирэхдээ хүчирхийлэнгүй, түрэмгий болсон байдаг тухай ярьсан юм. Мөн хүчирхийллийн хохирогч, даван туулагчидтай ажилладаг орон нутгийн мэргэжилтнүүд гурван долоо хоног бүтэн ажиллаад ирсэн уурхайчид богинохон үргэлжлэх амралтын өдрүүдээрээ найзуудтайгаа бар, клубээр аль болох их орж, согтууруулах ундаа хэрэглэж ядаргаагаа тайлах нь элбэг байдаг бөгөөд энэхүү байнгын согтуурхал дээр нь эзгүй хойгуур нь эхнэр нь юу хийж байсан бол гэж хардаж, сэрдэж байсан мэдрэмжийг нь сэдрээхэд нөлөөлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх сэдэл болж байгааг анзаарсан байна.

Цагдаагийн ерөнхий газар болон Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ), түр хамгаалах байрнуудын тоо мэдээнээс харахад КОВИД-19-ийн цар тахал дэгдсэнээс хойш ЖСХ-ийн нөхцөл байдал бүр дордсон байна. Цар тахал зарим уурхайг хаагдахад хүргэж, зарим хүний амь зуулга, цалин орлого буурсан эсвэл бүр байхгүй болсон бөгөөд олон хүн ажилгүй болоод гэртээ эргэж ирсэн. Энэ нь гэр бүлийн харилцаанд асуудал, зөрчил үүсгэх шалтгаан болж байна. Мөн олон нийтийг гадагш гарч, олон нийтийн газруудаар цагаа өнгөрөөхийг хязгаарлах арга хэмжээ болгож орон нутгийн захиргаанаас бар, ресторануудаар архи, согтууруулах ундаа худалдаалахыг хориглосон нь архи, согтууруулах ундааны хэрэглээг бүрэн хорьж чадаагүй. Харин ч хүмүүс орон гэртээ архи ууж, согтуурах нь ихэссэн байна. Энэ зөрчил дээр санхүүгийн дарамт нэмэгдсэн нь хүчирхийллийг өдөөх хүчин зүйл болж байна. Иймд Өмнөговь аймагт ЖСХ, ялангуяа бэлгийн болон сэтгэл зүйн хүчирхийлэл сүүлийн үед өсөж байна.

Аймгийн НЦҮТ эдгээр өдрүүдэд илүү олон үйлчлүүлэгч хүлээж авах болсон ч үүний шалтгаан нь нэг талаараа хүмүүс хүчирхийллийг харьцангуй бага тэвчдэг болж, олон нийт хүчирхийллийг мэдээлэх нь ихэссэнтэй бас холбоотой юм.

### **Даван туулагчдыг хамгаалахын зэрэгцээ ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх нь**

Тус аймагт ЖСХ-ийн тархалт өндөр байгаа учир ЖСХ-ийн даван туулагчдыг цаашид тохиолдож болох хор хохирлоос хамгаалахад туслах, түүнчлэн гэмт хэрэгтнүүдийг хийсэн үйлдлээр нь хариуцлагад татах механизм зайлшгүй хэрэгтэй байсан. Гэхдээ ЖСХ-ийн асуудал нь аймгийн хэмжээнд авч шийдвэрлэх шаардлагатай чухал асуудал биш гэсэн итгэл үнэмшлийн улмаас эл асуудлыг шийдвэрлэхэд хөрөнгө оруулах тал дээр олон шийдвэр гаргагч анхандаа тээнэгэлзэнгүй ханддаг байсан юм.

Урьд нь ЖСХ зэрэг жендэрийн асуудлыг хангалттай хэмжээнд огт анхаардаггүй байв. Гэр Бүлийн Хүчирхийлэлтэй Тэмцэх тухай Хуулиар (ГБХТТХ) үүрэг хүлээсэн талуудад ЖСХ-д хариу арга хэмжээ авах талаар нөлөөллийн ажил болон цогц сургалтууд зохион байгуулснаар шийдвэр гаргагчдын ЖСХ-ийн талаарх хандлага өөрчлөгдсөн. Үүний үрээр ЖСХ-д хариу арга хэмжээ авахад зориулж төсөв хуваарилах болсон бөгөөд энэ нь шийдвэр гаргагчид энэ асуудалд хүчин зүтгэл гаргах болсны тод илрэл юм. Энэхүү төслийн дэмжлэгээр бий болсон хамгийн том нөлөөллийн ажлын нэг нь үүрэг хүлээгчдийн анхаарлыг энэ асуудалд хандуулж чадсан явдал

бөгөөд ЖСХ-д хариу арга хэмжээ авах механизмийг өргөтгөснөөр энэ асуудлын талаарх олон нийтийн ойлголт ч мөн дээшилсэн байна.

Хамгийн эхний, хамгийн чухал санаачилгуудын нэг нь гэр бүлийн хүчирхийллийн даван туулагчдад зориулсан түр хамгаалах байрыг байгуулж, даван туулагчдад олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг аймгийн НЦҮТ-тэй болсон явдал байв. Уг НЦҮТ-ийг байгуулахад “Монгол улсад ЖСХ-тэй Тэмцэх нь” төсөл арга зүй болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд цаашдын үйл ажиллагааг нь тогтвортой авч явахын тулд аймгийн захиргаанаас төвд хөрөнгө оруулсаар байх шаардлагатай байсан юм. Гэвч нутгийн захиргааны нөөц боломж маш хязгаарлагдмал байсан бөгөөд ялангуяа шийдвэр гаргагчид орон нутагт НЦҮТ байгуулах шаардлагатай гэдгийг бүрэн ойлгоогүй байсан эхэн үед бэрхшэтэй байлаа.

Ийм учраас орон нутгийн холбогдох газар, агентлагууд бүгд хамтран ажиллаж, бэрхшээлээ даван туулах шинэлэг, зардал багатай шийдлүүдийг эрэлхийлэх шаардлагатай болсон юм. Тухайлбал аймгийн захиргааны шийдвэрээр НЦҮТ-ийг цагдаагийн хэлтсийн дэргэд байгуулахаар болсон бөгөөд НЦҮТ-ийнхний хүсэлтээр цагдаагийн газрын шөнийн эргүүлээр НЦҮТ-ийн газрыг мөн хариуцуулахаар болсон байна. Ингэснээр төвийг ямар ч нэмэлт зардалгүйгээр 7 хоногийн 24 цаг харуул, хамгаалалттай болгож чадсан юм.

НЦҮТ-ийн ажилтнууд орон нутгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын (ГБХЗХГ) дэмжлэгтэйгээр хувийн хэвшлийнхэнтэй

мөн түншлэл үүсгэж, нөөц бололцоог нь дайчлан ажилласаар ирсэн байна. Энэхүү түншлэл нь НЦҮТ-д хоол хүнс болон эм хангамжийн байнгын хандивын эх үүсвэрийг бий болгосон. Мөн төслийн дэмжлэгтэйгээр саяхан НЦҮТ-ийн дэргэд 9 төрлийн жимс, хүнсний ногоо тарих хүлэмж байгуулж, төвд байрлаж буй хүмүүс болон ажилчдыг тогтмол хүнсээр хангах болсон байна.

НЦҮТ нь мөн үйлчлүүлэгчдийнхээ тусгай хэрэгцээ шаардлагад илүү сайн нийцэж ажиллахын тулд чадах бүхнээ хийж байна. Нэгэн жишээг дурьдвал, хөдөө орон нутагт гэрт амьдарч дассан олон үйлчлүүлэгч нь төвд байрлах өрөө байсан ч гэсэн байранд дасан зохицож амьдрахад бэрхшээлтэй байдгийг анзаарснаар төвөөс нэг гэр худалдан авч, цэлгэр хашаандаа барьснаар үйлчлүүлэгчид нь хамгийн тав тухтай гэж үзсэн сууцаа сонгон байрлах боломжтой болжээ. Төвийн ажилтнууд мөн үйлчлүүлэгчдэдээ маск оёхыг зааж өгснөөр үйлчлүүлэгчид нь өөрсдийгөө КОВИД-19-ээс хамгаалахын зэрэгцээ нэмэлт орлого олох боломжтой болжээ.

Түүнчлэн, НЦҮТ-ийн ажилтнууд үйлчлүүлэгчдээ НЦҮТ-өөс гарсныхаа дараа амьдралд бэлдэхэд нь туслах олон зүйлийг хийдэг. НЦҮТ-өөс олон удаа тусламж хүсч ирсэн ЖСХ-ийн нэгэн даван туулагчийн түүхийг тус төвийн зохицуулагч ярьж байлаа. Уг үйлчлүүлэгч хүчирхийлэгч нөхрөө орхихоор олон удаа оролдож байсан ч амьдралаа залгуулах боломж, амьдрах байргүйн улмаас эргээд нөхөр дээрээ очдог байжээ. Ийм учраас НЦҮТ-өөс түүнд гэр худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх донор олж өгч, төрөл садангуудтайгаа ойр амьдрахад нь тусалжээ.

Энэхүү НЦҮТ-ийнхөн ЖСХ-ийн даван туулагчдаас гадна эмзэг бүлгийнхэнд ч бас үйлчилгээ үзүүлдэг. Тухайлбал, КОВИД-19-ийн улмаас сургуулиуд хаагдах үед өнчин хүүхдийн асрамжийн газраас оюутан болсон нэгэн их сургуулийн оюутан залуу байрлах байргүй болсон байна. Уг оюутан өнчин хүүхдийн асрамжийн газар руугаа буцахыг хүсээгүй тул НЦҮТ-өөс тусламж хүсжээ. Тэгэхэд нь төвийн ажилтнууд бие даан амьдрах хүртэл нь дэмжлэг үзүүлэхээр шийдэж, оюутан байлгах айл хайгаад нэгэн найзынхаа гэрт түр зуур байрлуулахаар болсон төдийгүй тэр хугацаанд амьдралаа залгуулахад нь тусалж орон нутгийн компанид ажилд ороход нь тусалсан байна.

Гэсэн хэдий ч тус НЦҮТ хүний нөөцдөө зориулсан санхүүжилтээ баталгаатай болгоход бэрхшээлтэй тулгарсаар байгаа юм. Одоогоор тус НЦҮТ-д бүтэн цагаар ажилладаг гуравхан ажилтан байгаа бөгөөд тэд төвийг 7 хоногийн 24 цагаар ажиллуулахын тулд амралтгүйгээр ээлжлэн ажиллах хэрэгтэй болдог. Харамсалтай нь анх ажилтан нэмж авахад зориулж төлөвлөсөн байсан төсөв нь аймгийн захиргаагаар батлагдаагүй юм. Гэсэн хэдий ч НЦҮТ-ийн ажилтнууд болон ГБХЗХГ-ынхан санхүүжилтээ нэмүүлэхээр захиргаанд нөлөөлөх ажлаа зогсолтгүй үргэлжлүүлсээр байна.



Энэ хооронд аймгийн ГБХЗХГ болон ЖСХ-тэй тэмцэх нь төслийн дэмжлэгтэйгээр уг 3 ажилтныг тогтмол сургалтад хамруулж, чадавхжуулж, даван туулагчдад илүү үр дүнтэй туслах мэдлэг, ур чадварыг нь хөгжүүлсээр байна. Төслийн шугамаар НЦҮТ-ийн ажилтнууд нийслэл Улаанбаатар хот руу үйлчилгээний байдалтай танилцах аяллаар явж, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн ажлын байран дээрх сургалтанд хамрагдсан байна. Төвийн ажилтнууд мөн хуульч, нийгмийн ажилтан, бүр урлагийн сэтгэл засалчийн явуулсан олон талт үйлчилгээ үзүүлэх тухай сургалтад сууж, үйлчилгээ үзүүлэх практик зөвлөмж авах боломж гарсан юм.

Түүнчлэн, аймгийн ГБХЗХГ аймгийн төв Даланзадгад хот дахь НЦҮТ-ийн ажилтнууд болон хамтарсан багийн гишүүдийг сургахаас гадна, аймгийнхаа бүх сумаар явж, хамтарсан багуудыг холбогдох хууль тогтоомж болон үйлчилгээ үзүүлэх талаар сургалтад хамруулсан байна. Үүрэг хүлээгчдийг тасралтгүй сургах, бас урамшуулах зорилгоор ГБХЗХГ-аас хамгийн амжилттай ажилласан хамтарсан багийг мотоциклоор шагнах уралдаан хүртэл зохиожээ. ГБХЗХГ-аас аймгийн хэмжээнд бүх багт (зарим баг нь аймгийн төвөөс 500 км хүртэл хол байрладаг) ЖСХ-ийн даван туулагчдад холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгох зорилгоор багийн иргэдийн төлөөлөгчидтэй хамтын ажиллагаагаа нягтруулахын төлөө идэвхтэй ажиллаж байна.

Энэ бүх санаачилгууд, НЦҮТ-ийн ажилтнууд болон орон нутгийн удирдлагуудын хичээл зүтгэлийн үр дүнд НЦҮТ-өөс тусламж хүссэн үйлчлүүлэгчдийн сэтгэгдэл маш өндөр байна. Тус НЦҮТ нь үйлчилгээгээ цогц, иж бүрэн байдлаар үзүүлж, төрөл бүрийн үүрэг хүлээгчдэд НЦҮТ болон түүний үзүүлдэг үйлчилгээний талаар ойлгуулахын тулд бусад салбарууд болон хамтарсан багуудын гишүүдтэй нягт түншлэн ажиллаж байна. Үүний дүнд тэд даван туулагчдын хувийн нууцыг задруулахгүйгээр НЦҮТ-д зуучилдаг болох юм. Орон нутгийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Зөвлөл (ГХУСАЗЗ) нь олон салбарын хамтын ажиллагааг дэмжихийн тулд кэйс хурал (case conference) тогтмол зохион байгуулдаг. Олон нийтийн энэхүү маш эерэг сэтгэгдэл нь шийдвэр гаргагчдын зүгээс ирэх дэмжлэгийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Гэсэн хэдий ч НЦҮТ-ийн ажилтнууд олон нийттэй харилцаж, эмзэг бүлгүүдэд хүрч ажиллаж, хүчирхийлэлд өртөж байгаа хүмүүст хаанаас, хэрхэн тусламж эрэлхийлэх талаар мэдээлэл өгөхөөс гадна хамгийн гол нь, ЖСХ бол тэвчиж болохгүй хүний эрхийн зөрчил гэсэн ойлголтыг бүх нийтэд өгөх хэрэгтэй байгаагаа илүүтэй ухамсарлаж байгаа билээ. Олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхийн сацуу НЦҮТ болон түүний үйлчлүүлэгчдийн аюулгүй байдал болон нууцлалыг хангахын тулд НЦҮТ болон ГБХЗХГ-аас тусламжийн шууд утасны дугаарыг бичсэн түлхүүрийн оосор, хөргөгчний соронзтой наалт болон бусад хэрэглэгдэхүүнийг гаргаж, олон нийтэд тарааж эхэлжээ.

Энэ бүх нөлөөллийн санаачилгын ачаар хүмүүс ЖСХ нь олон хэлбэртэй байдгийг ойлгож, өөрсдийгөө хүчирхийлэлд өртөж байгаа эсэхээ зөв үнэлэх боломжтой болсон. Гэхдээ алслагдмал газар амьдардаг олон хүн ЖСХ-ийн талаар мэдээлэлгүй, эсвэл хүчирхийллийг амьдралынхаа нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн байх нь олонтаа байдаг байна.

Энэ бүхэнд үндэслээд аймгийн зүгээс ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон хэлбэрийн үйл ажиллагаа явуулж байгаагийн нэг нь ГБХЗХГ-аас уул уурхайн компаниудын 21 хоног ажиллуулаад, 7 хоног амраадаг ажлын хуваарийг 14 хоног ажиллуулаад 7 хоног амраадаг илүү зохимжтой хуваарьт шилжүүлэх шаардлагыг хүргүүлснээр уг саналыг эхний ээлжинд нэг компани хүлээн авч хэрэгжүүлээд байна. ГБХЗХГ-аас дахин 3 компанитай хэлэлцэж байна. Ингэснээр уул уурхайн салбарын ажилтнуудын стрессийг бууруулахад туслах бөгөөд ЖСХ-ийн өдөөгч болон эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад тустай гэж үзэж байгаа юм.

Түүнчлэн, ГБХЗХГ-аас ажилчдынхаа нийгмийн халамжийн асуудалд анхаарах, байгууллагынхаа хүрээнд ЖСХ-г шийдвэрлэх үүрэгтэй аймгийн түвшний байгууллагууд дээр эцэг эхийн зөвлөл байгуулж, ЖСХ-ээс сэргийлэх үйл хэрэгт өөрийн оролцоогоо нэмэгдүүлэхэд эцэг эхчүүдтэй хамтран ажиллах ажлыг эхлүүлээд байна. Эцэг эхийн зөвлөлийн гишүүд ЖСХ-ийн асуудлууд, хүүхдийн халамж болон бусад холбогдох сэдвээр мэдээлэл авч, өөрийн хүүхдэд жендэрийн эрх

тэгш байдлын ойлголт, итгэл үнэмшлийг төлөвшүүлэх, зөвлөлийн гишүүний хувьд мөн бусдад нөлөөлөх чадавхитай болоход туслах ажлыг өрнүүлсэн.

Аймагт ЖСХ-ийн хариу арга хэмжээ болон урьдчилан сэргийлэх хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх хамгийн гол арга хэмжээ нь шинээр байгуулагдсан засгийн газрын бүх түвшинд эл асуудлыг ойлгуулж, хэрэгжиж буй санаачилгуудыг тогтвортой үргэлжлүүлж, болж өгвөл бүр өргөжүүлэх юм. Мөн НЦҮТ-ийн ажилтнууд НЦҮТ-ийн барилга, материаллаг баазыг сайжруулах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү хүртээмжтэй болгох тал дээр анхаарах, мөн ЖСХ-ээс урьдчилан сэргийлэхийн тулд хүчирхийлэл үйлдэгчидтэй ч бас хамтран ажиллах шаардлагатай талаар ярьж байв.

Үйлчлүүлэгчдэд НЦҮТ-өөс гарсныхаа дараа хэвийн амьдралдаа эргэн ороход нь туслах үйлчилгээнүүдэд илүү их хөрөнгө хуваарилах шаардлагатай юм. Үүнийг үүрэг хүлээгчид ч, төвийн үйлчлүүлэгчид ч анзаарч энэ талаар саналаа хэлдэг. Тухайлбал, даван туулагчдыг цаашид сэтгэл зүйн гэмтлээ анагаахад нь тусалдаг дэмжих бүлгүүдийг байгуулж болно. Мөн даван туулагчдыг чадавхжуулж, санхүүгийн хувьд хараат бус болоход нь тусалдаг амьжиргааны ур чадварын сургалт явуулж болно. Энэ нь тэднийг амь зуухын эрхэнд хүчирхийлэгч хамтрагч дээрээ эргэн очихоос өөр аргагүй болох байдлаас сэргийлэхэд туслах юм.

## ХӨРСӨНД БУУСАН САЙН ТУРШЛАГА

«Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй (ЖСХ) тэмцэх нь» төслийн хүрээнд өнгөрсөн жилүүдэд олон чухал санаачилга хэрэгжсэний дотор төслийн хэрэгжилтийн эхний дөрвөн жилд ЖСХ тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх хүчин чармайлтад чухал түлхэц болсон хоёр чухал үйл явдал болсон юм. ГБХ-ийг гэмт хэрэгт тооцож, ЖСХ-тэй тэмцэх төрийн хариуцлагыг тодорхойлж өгсөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулсан болон орон даяар ЖСХ-ийн бодит байдал, тархалт ямар байгааг олон нийтэд ил болгосон үндэсний хэмжээний ЖСХ-ийн судалгааны үр дүн юм.

Түүнээс хойш Монгол улс ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр олон далайцтай ажлуудыг хийсний нилээд нь энэ чиглэлд хэрэгжсэн анхны бөгөөд хамгийн цогц хүчин чармайлтуудын нэг болох ЖСХ-тэй тэмцэх нь төслийн дэмжлэгтэйгээр хийгдсэн юм. Үүний дотор хамгийн цохон тэмдэглүүштэй нь, улсын болон орон нутгийн түвшинд даван туулагчдыг хамгаалах механизмуудыг бий болгож, ЖСХ-ийн даван туулагчдыг нэн даруй, хангалттай тусламж, үйлчилгээ хүртэх, хүчирхийлэлийн нөхцөл байдлаас холдох, сэтгэл санааны гэмтлээ анагаах, илааршуулах, улмаар нийгэмдээ эргэн өөртөө итгэлтэйгээр хөл тавих боломжоор хангасан явдал юм.

ЖСХ-тэй тэмцэх нь төслийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн нэг нь ЖСХ-ийн даван туулагчдад зориулсан Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг (НЦҮТ) байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулахад байнгын дэмжлэг үзүүлж ажилласан явдал байлаа. НЦҮТ-үүд нь ЖСХ-ийн даван туулагчдыг байрлах аюулгүй байраар хангаж, эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль зүй, зөвлөх болон хамгаалах үйлчилгээ үзүүлдэг. Төслийн шугамаар 2016-2020 оны хооронд нийт 11 НЦҮТ байгуулсан бөгөөд өмнө үйл ажиллагаа явуулж байсан 6 НЦҮТ, хоёр түр хамгаалах байранд мөн техник арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Энэхүү хүчин чармайлт Монгол улсын хувьд харьцангуй шинэ зүйл учраас ЖСХ-тэй Тэмцэх нь төслөөс НЦҮТ-ийн ажилтнууд болон бусад үүрэг хүлээгчдэд ур чадвараа дээшлүүлж, үр дүнтэй, хохирогч, даван

туулагчдын онцлогт тохирсон байдлаар үйлчилгээ үзүүлэх чадавхаа бэхжүүлэх боломжийг тогтмол олгож ажилласан юм.

Эдгээр олон боломжуудын нэг нь 2019 оны 6-р сард төслөөс орон нутгийн туршлага солилцох танилцах аялалыг өмнө нь байгуулагдаад, олон жилийн туршлага хуримтлуулсан аймгуудын НЦҮТ-үүдэд зохион байгуулсан явдал байв. Энэ нь шинээр байгуулагдсан төвүүдийн ажилтнуудад тэдгээр төвүүдээс суралцах боломж олгосон билээ.

Энд онцолж буй НЦҮТ 2013 онд орон нутгийн захиргаа болон НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан юм. ЖСХ-тэй тэмцэх нь төслөөр 2016 оноос хойш уг төвийн дотоод чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь тогтвортой үргэлжлүүлэхийн тулд санхүүгийн болон техник арга зүйн дэмжлэг тогтмол үзүүлж ирсэн. Аймгийн НЦҮТ гурван үндсэн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг. Үүнд: (1) салбар хоорондын олон талт хамтын ажиллагааны механизмийг бэхжүүлэх, (2) сэтгэл зүйн үйлчилгээг хохирогч, даван туулагчид, хүчирхийлэл үйлдэгчдэд үзүүлэх, мөн (3) даван туулагчдад хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлэх явдал юм.

Хамгийн түрүүнд цохон тэмдэглүүштэй нь, тус НЦҮТ-өөс оролцогч талуудтай байнгын харилцаа холбоотой ажиллаж, ЖСХ-тэй тэмцэх чадавхийг нь бэхжүүлж, үүрэг хариуцлагыг нь тодорхой ойлгуулах замаар салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг илүү үр дүнтэй болгох хүчин чармайлтыг тасралтгүй гаргасаар ирсэн байна. 2018 онд аймгийн Засаг даргын тушаалаар НЦҮТ-ийн Удирдах

зөвлөлийг байгуулсан юм. Аймгийн Засаг даргын орлогчоор удирдуулсан уг Удирдах зөвлөл нь тогтмол хуралдаж, төвийн жилийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, гүйцэтгэлийн үр дүнг тайлагнадаг бөгөөд хамгийн сүүлд уг зөвлөлөөс үйл явцыг сайжруулж, оновчтой болгохын тулд салбар хоорондын олон талт хамтын ажиллагааны удирдамжийг боловсруулсан байна.

Түүнчлэн, тус төвөөс НЦҮТ-ийн үйлчлүүлэгчдэд олон салбарын үйлчилгээг үнэгүй хүргэхийн тулд аймаг дахь гол хамтрагч талуудтай гэрээ байгуулсан байна. Тодруулбал, Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн газар, Прокурорын газар, Эрүүл мэндийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Боловсрол соёлын газар, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон Өмгөөлөгчдийн зөвлөлтэй түншлэл үүсгэжээ. Тус төвийн ажилтнууд мөн дээрх байгууллагын ажилтнуудыг жендэрийн асуудал болон ЖСХ-ийн талаар сургалтад хамруулж, хангалттай мэдлэг ойлголттой болгоход анхаарч ажилласан юм. Тэгснээр тэдний үйлчилгээ илүү үр дүнтэй, жендэрийн мэдрэмжтэй болоход тусалсан байна.

Аймгийн НЦҮТ-ийн бас нэгэн амжилт бол аймагтаа ЖСХ-тэй тэмцэхэд олон нийтийг оролцуулах тасралтгүй хүчин чармайлт гаргаж ажилласан явдал билээ. Тухайлбал, 2019 оны 3-р сарын 8-нд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр уг төвийн ажилтнууд аймаг даяар гудамж талбайд сурталчилгааны ажил зохион байгуулсан юм. Аймгийн төвд нийт 3,000 хүн уг

сурталчилгааны ажилд оролцсон байна. Харин сумдаар нийт 1,600 хүн оролцжээ. Энэ үйл ажиллагаагаараа НЦҮТ-ийн хамт олон жендэрийн талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхээс гадна үйл ажиллагаагаа хэр далайцтай явуулж байгаагаа илэрхий харуулж чадсан учраас аймгийн Засаг даргын анхаарлыг татаж чадсан байна. Тэгснээр Засаг дарга НЦҮТ-ийн үйлчлүүлэгчид болон эмзэг бүлгийн 400 эмэгтэйтэй уулзаж, амьдрал, асуудал бэрхшээлийг нь сонсжээ. Үүний дүнд Засаг даргын тамгын газраас НЦҮТ-ийн үйл ажиллагаанд зориулж 15 сая төгрөг хуваарилсан байна. Тус төв мөн Улаан загалмай, Дэлхийн Зөн зэрэг ТББ-ууд, мөн хувийн компаниуд болон бизнес эрхлэгчидтэй түншилж, төвийнхөө хэрэгцээт хангамжийг (хувийн ариун цэврийн зүйлс, хувцас, хүнс гэх мэт) үнэгүй эсвэл хямдруулсан үнээр авах болжээ.

Аймгийн НЦҮТ-ийн амжилттай хэрэгжүүлсэн дараагийн ажил бол үйлчлүүлэгчиддээ хууль эрх зүйн тусламж үзүүлэх тогтолцоог хэвшүүлсэн явдал юм. Олон даван туулагч хэрэг үүсгэхээс татгалзах, хэргийн дундаас мэдүүлгээсээ буцан хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох талтай байдаг. Зарим тохиолдолд энэ нь өмгөөлөгч, хуульчийн төлбөр болон хууль эрх зүйн бусад зардлыг төлж дийлэхгүйтэй холбоотой байдаг. Бусад тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийн төрөл садангууд нь мөн даван туулагчийн төрөл садан байдаг учраас даван туулагчид шахалт үзүүлж, хүчирхийллийг зүгээр л “уучлах” хэрэгтэй, цагдаа, шүүхээр явах хэрэггүй гэж ятгаж, дарамталдагтай холбоотой байдаг байна. Ураг төрлийн холбоотой, өөрөөс нь ахмад настай төрөл садангийнхаа

зүгээс үйлдсэн хүчирхийллийн хохирогч болсон өсвөр насны охидын хувьд энэ нь түгээмэл байдаг. Бүр ээж нь хүртэл охиндоо хүчирхийлэгчийн эсрэг хууль ёсны арга хэмжээ авахуулахад нь саад хийх нь бий. Ийм тохиолдолд НЦҮТ даван туулагчийг хүчирхийллийн болон дарамт шахалт үзүүлж байгаа орчноос тусгаарлан аюулгүй байраар хангаж, хууль ёсны арга хэмжээг авч дуусах хүртэл сэтгэл зүйн болон хуулийн зөвлөгөөг өгч, хуулийн үйл явцыг нөлөөллөөс ангид явуулах, мөн хохирогчийг бусад төрлийн хохирлоос хамгаалж ажилладаг.

Тус НЦҮТ нь хүчирхийлэл үйлдэгчдэд зохих ялыг нь бүрэн оноохын тулд, үйлчлүүлэгчдэд нотлох баримт бүрдүүлэх, мөрдөн байцаагч, прокурор болон хуульч/өмгөөлөгч нартаа мэдүүлэг өгөхөд дэмжлэг үзүүлж, ойр хамтран ажилладаг орон тооны хуулийн зөвлөлтэй. НЦҮТ-ийн Хуулийн зөвлөх НЦҮТ саяхан аймаг дахь Өмгөөлөгчдийн зөвлөлтэй түншлэл үүсгэж, ЖСХ-ийн даван туулагч эмэгтэйчүүд болон хүүхдүүдэд үнэгүй хуулийн зөвлөгөө, өмгөөлөх үйлчилгээ үзүүлэх замаар мэргэжлийн үйлчилгээнийхээ чанарыг ахиулж, академик кредит авах боломжийг хуульч, өмгөөлөгч нарт олгох хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн тухайгаа ярьсан юм. Энэхүү түншлэл нь өнгөрсөн үетэй харьцуулахад илүү олон гэмт хэргийн тохиолдлыг нотолж, зохих хуулийн хариуцлагыг хүлээлгэн, гэмт хэрэгтэн ял завшин дахин хүчирхийлэл үйлдэж олон хүнийг хохироохоос сэргийлж чадсан байна. Учир нь олон даван туулагч хуульчийн зардлыг төлж дийлэхгүйн улмаас урьд нь хэргийн дундаас өргөдөл, гомдлоо буцаадаг байжээ.



Аймгийн НЦҮТ мөн аймгийн Прокурорын газартай түншлэл үүсгэсэн бөгөөд Төвийн ажилтнууд болон хамтарсан багуудын урьд нь хариуцан ажиллаж байсан хэргүүдийг нягталж, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэхдээ ямар ямар гол бэрхшээл, сорилттой тулгардаг байсныг судалж тогтоохоор ажиллаж байна. Энэхүү судалгаан дээр үндэслээд Прокурорын газраас мөн ХБ-уудыг тодорхой хэргүүд дээр нөлөөлж ажиллахын тулд шаардах бичгийг сайтар боловсруулан бичих ур чадварт сургаж байгаа юм. Эдгээр хүчин чармайлт нь амжилттай шийдвэрлэсэн хэргийн эзлэх хувийг нэмэгдүүлж, гэмт хэрэг үйлдээд ял шийтгэл авахгүй өнгөрдөг байдлыг аймгийн хэмжээнд бууруулсаар байна.

Эцэст нь хэлэхэд, аймгийн НЦҮТ нь даван туулагчдад сэтгэл зүйн мэргэжлийн тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлдэгээрээ бусад төвүүдээс илүү онцлогтой байдаг. Төвөөс явсан хойноо сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үргэлжлүүлэн аваагүй зарим үйлчлүүлэгч нь амиа егүүтгэх оролдлого хийх, эсвэл биеэ үнэлэх болон архинд орох зэрэг бусад хортой зан үйлд автах харамсалтай хандлагатай байгааг төвийн ажилтнууд анзаарч харсан учраас ийнхүү урт хугацааны сэтгэл зүйн үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэхэд анхаарах болсон байна.

Аймгийн НЦҮТ-ийн сэтгэлзүйч хэлэхдээ төвд удаан хугацаагаар байрлах тусам нөхөн сэргэх үр дүн нь сайжирдаг бөгөөд сэтгэл зүйн зөвлөгөө авах хугацааны хувьд ч мөн адил байдаг гэсэн юм. Сэтгэл зүйчид мөн даван туулагч нэг бүртэй зөвлөлдсөний үндсэн дээр хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулдаг бөгөөд тэгснээр сэтгэл зүйн зөвлөгөө зэрэг эмчилгээ нь тухайн даван туулагчийн хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд илүү сайн тохирсон байж чаддаг.

Өөрсдөд нь тохиолдсон зүйлийг бүрэн ойлгох чадвар дутмаг байдаг учраас бага насны даван туулагчдын (4-8 насны) байдал түргэн сайжирдаг. Харин өсвөр насныхны хувьд эдгэрэх зам нь хамгийн тогтворгүй байдаг. Төвөөс урлагийн засал эмчилгээг стресс гадагшлуулах (катарзис) нэгэн хэлбэр болгож ашиглахаас гадна өөрт тохиолдсон үйл явдлаа үгээр илэрхийлж чадахгүй байгаа залуу охидод өөрийгөө илэрхийлэх арга болгож ашиглаж байгаа нь үр дүнтэй байна гэж НЦҮТ-ийн сэтгэлзүйч ярьсан юм.

Аймгийн НЦҮТ-ийн ажилтнууд шаргуу зүтгэлээ хадгалж, бүтээлч, үр дүнтэй санаачилгыг тууштай хэрэгжүүлсээр НЦҮТ-ийн менежментийн сайн туршлагын жишиг болж чадсан юм. Тэдний хичээл зүтгэл аймагтаа ЖСХ-д хариу арга хэмжээ авах механизмийг мэдэгдэхүйц сайжруулж, улмаар тусламж эрж ирсэн даван туулагчдын амьдралыг дээшлүүлсээр байна.

Даван туулагчдын нэг болох Аз НЦҮТ-өөс тусламж эрсэн хувийн туршлагаа хуваалцсан юм. Бага насны охин нь нөхрийнх нь зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөнийг мэдсэнийхээ дараа тэрээр охиноо аваад гэрээсээ зугтаж, Цагдаагийн газарт тусламж эрж очсон байна. Тийнхүү НЦҮТ-тэй холбогджээ. Төвд байх хугацаандаа бүх үндсэн үйлчилгээг нь авч байсан бөгөөд түүний дотроос сэтгэл зүйн зөвлөгөө болон үнэгүй хууль эрх зүйн үйлчилгээ гэсэн хоёр үйлчилгээ маш их хэрэг болжээ.

Аз ярихдаа, «Анх Төвд ирэхэд миний сэтгэцийн байдал маш тогтворгүй байсан. Сэтгэл гутралд орж, бүх ой санамж маань эмх замбараагүй болсон байлаа. Эргэн тойронд маань юу болоод байгааг ч ойлгох чадваргүй болсон байсан. Ийм учраас л би энэ төвд ирсэндээ их баяртай байгаа. Эндхийн сэтгэл зүйч нар надад сэтгэцийн тогтвортой байдлаа эргүүлэн олж авахад их тус болсон» гэсэн юм.

Аз, охинтойгоо хамт төвийн мэргэжилтнээс сэтгэл зүйн зөвлөгөө тогтмол авсан байна. Тэрээр 3-4 удаагийн зөвлөгөөний дараа л гэхэд хэдийнээ оюун санааных нь төлөв байдалд өөрчлөлт гарсныг мэдэрч байснаа онцолж ярьсан юм. Охиных нь хувьд ч гэсэн мөн

адил сайн өөрчлөлт гарсныг анзаарсан байна. Аз төвөөс явсан хойноо ч сэтгэл зүйчтэйгээ уулзаж, зөвлөгөө авсан хэвээр байгаа тухайгаа мөн ярьсан юм.

Сэтгэл зүйн үйлчилгээнээс гадна үнэгүй хууль эрх зүйн үйлчилгээ амьдралд нь маш том тус болсон тухай Аз ярихдаа, “Өмгөөлөгчийн зардлыг төлж дийлэхээргүй байсан. Хамгийн багадаа 800,000 төгрөг байдаг бөгөөд миний хувьд тийм зардлыг төлөх ямар ч боломж байгаагүй” гэсэн юм.

Аз нөхрийнхөө эсрэг эрүүгийн хэрэг үүсгэхээр шийдэх үед төвөөс үнэгүй өмгөөлөгч олж өгсөн байна. Олон сар ажилласны эцэст эхний шүүх хурал 5-р сард болж, нөхөрт нь 18 жилийн хорих ял оноожээ. Гэвч нөхрийнх нь тал давж заалдахаар гомдол гаргасан байна. Азын тууштай байдал, мөн НЦҮТ-ийн ажилтнууд болон өмгөөллийн багийнхны шаргуу хөдөлмөр, дэмжлэгийн ачаар шүүхээс 6-р сард уг 18 жилийн хорих ялыг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн байна.

Энэ бүх хүчин зүтгэл Аз, охин хоёрт илааршихад нь тусалсан юм. Аз нэгэнтээ, “Бидэнд ямар ч айх аюулгүй мэдрэмж төрж байна. Бас хүмүүс бидэнд санаа тавьдаг гэдгийг ойлгосон. Засаг дарга хүртэл бидэнтэй ирж уулзсан нь маш гэнэтийн бэлэг байсан учраас би баярласандаа бүр уйлчихсан” гэж ярьсан билээ.

## ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ НЬ

Нэг цэгийн үйлчилгээний төвийн (НЦҮТ) сэтгэлзүйчийн хувьд ажлын өдөр бүр нь өвөрмөц байдаг. Зарим өдөр нь жендэрт суурилсан хүчирхийллийн (ЖСХ) даван туулагчидтай хамт сууж, нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө үзүүлдэг бол бусад өдөр нь айлуудаар явж, эрсдэлийн түвшинг нь үнэлж, өрхийн гишүүдийн дунд хүчирхийлэл болон бусад эмзэг байдлын шинж тэмдэг байгаа эсэхийг судалдаг. Тэрээр мөн үе үе нэлээн хүнд нөхцөлд ажилладаг. Түүнийг Цагдаагийн газар дээр гэрчийн мэдүүлэг өгч байхад нь нэгэн дунд эргэм насны эмэгтэй их айж сандарсан, ухаан нь самуурсан байдалтай хэлтэсрүү гүйн орж иржээ. Тэр эмэгтэй тусламж эрэн орилж, таньдаг хүн нь өсвөр насны охинд нь бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэж бархирч байжээ. Даван туулагчид болон гэр бүлийнхэнтэй нь ажилладаг туршлага, ур чадвартай тул сэтгэлзүйч мөнөөх эмэгтэйд ойртон очиж, охинд нь хэрхэн тусалж болох тухай, мөн НЦҮТ-өөс үзүүлдэг үйлчилгээнд хамрагдах боломжийн талаар ярьсан байна.

Аймаг дахь НЦҮТ 2020 оны 1-р сард үүдээ нээснээс хойш хариуцаж ажилласан олон хэргүүдийн зөвхөн нэг жишээ нь энэ юм. Монгол улсад ЖСХ-тэй тэмцэх нь төслийн хүрээнд аймгуудад байгуулагдсан хамгийн отгон НЦҮТ хэдий ч, уг төв нь хэдийнээ цагдаагийн газар зэрэг үүрэг хүлээгчид болон нутгийн иргэдийн итгэлийг олж авсан байна. Ихэнх үйлчлүүлэгчид нь цагдаагийн газраас авсан мэдээллийн дагуу НЦҮТ-д ирдэг боловч төвийн ажилтнууд өөрсдийн санаачилгаар иргэдэд хүрч ажиллаж, зарим даван туулагчдыг төвдөө авч ирдэг байна. КОВИД-19-ийн цар тахал анх дэгдэх үед НЦҮТ-ийн ажилтнууд орон нутгийн иргэдэд хүрч ажиллах хүчин чармайлтаа ихээхэн нэмэгдүүлж, сүүлийн хэдхэн сарын хугацаанд гэхэд гэр бүлийн дотоод дахь эрсдэлийг үнэлж, НЦҮТ-өөс үзүүлдэг амин чухал, амьдрал аврах үйлчилгээг танилцуулах гурван удаагийн өрх айлуудаар явах санаачилгыг хэрэгжүүлээд амжсан байна.

Анх 2015 онд аймгийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газраас (ГБХЗХГ) гэр бүлийн хүчирхийллийн даван туулагчдад зориулсан түр хамгаалах байрыг байгуулж байсан юм. 8 ор бүхий уг байр нь үйлчлүүлэгчдээ зөвхөн байр сууц болон зуучлах үйлчилгээгээр хангадаг байв. Гэвч орон нутгийн удирдлагууд энэ төрлийн байр болон үйлчилгээг өргөтгөж, илүү олон даван туулагчдад хүрч ажиллах шаардлагатайг ойлгосон юм.

ЖСХ-тэй тэмцэх нь төслийн зорилтот газруудын нэг болохын хувьд уг аймгийн НЦҮТ-д зориулж шинэ барилга барьж, аюулгүй байр, эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль эрх зүй болон хамгаалах үйлчилгээ зэрэг


цогц үйлчилгээ үзүүлж ажиллах, түүнчлэн илүү нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай үед зуучлах үйлчилгээ үзүүлж ажиллах боломжоор хангасан юм. Уг шинэ барилга нь мөн ЖСХ-ийн даван туулагчдыг хамгаалах олон улсын стандартын шаардлагад нийцсэн бөгөөд нэг удаад 16 даван туулагчийг аюулгүй байрлуулах хүчин чадалтай ажиллаж байна.

НЦҮТ-ийг өргөтгөсөн явдал нь илүү олон даван туулагчийг байрлуулж, илүү хэрэгцээт үйлчилгээг дотроосоо үзүүлэх боломжтой болгосны дээр шинэ төслүүдэд зориулсан санхүүжилтийн боломжуудыг нэмэгдүүлсэн юм. Түүнчлэн, даван туулагчдыг чадавхжуулах янз бүрийн үйл ажиллагаа, сургалтуудыг зохион байгуулах илүү том орон зайг бий болгосон юм. Төслөөс олгосон илүү том байр хийгээд хэрэгцээт тоног төхөөрөмжүүдийн ачаар тус НЦҮТ нь өдгөө оёдол, гар урлал зэрэг даван туулагчдын чадавхийг бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулж байна. Энэхүү НЦҮТ нь мөн даван туулагчдад хүнсний ногоо тарихад суралцах боломжийг олгосон хүлэмж барьсан юм. Ингэснээр хэрэгцээний хүнсний ногоогоо өртөг багатай авдаг болжээ. Энэ бүх үйл ажиллагаа нь даван туулагчдад ур чадвараа сайжруулж, ажилд ороход нь туслахын зэрэгцээ өөртөө итгэх итгэлээ эргүүлэн олж авч, төвөөс явсныхаа дараа илүү сайхан амьдрал бүтээхэд нь туслах зорилготой юм.


НЦҮТ-ийн сэтгэлзүйч ярихдаа, «Манай аймаг дахь даван туулагчдыг хамгаалах газар нь түр хамгаалах байр байсныг өргөтгөж, НЦҮТ болгосноор бидэнд ч, даван туулагчдад ч олон боломж нээгдэж байна» гэсэн юм. Тэрээр НЦҮТ-ийн статустай болсноор төрийн байгууллагуудаас ч, донор байгууллагуудаас ч дэмжлэг, санхүүжилт хүсэх боломжтой болсныг онцолж, «Урьд нь бид санхүүжилт хүсэж олон газарт ханддаг байлаа. Гэвч дэндүү жижиг байгууллага гээд хэрэгтэй санхүүжилтээ авч чаддаггүй байсан. Харин одоо аймгийн НЦҮТ болж өргөжсөн учраас донор болон түнш байгууллагуудаас нэлээн нааштай хариу сонсож эхэлсэн шүү» гэж ярьсан юм.

Аймгийн НЦҮТ саяхан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 13 сая төгрөгийн тэтгэлэг авахаар болсон юм. Энэхүү тэтгэлгийг сургалтын модуль боловсруулж, сурах бичиг, сургалтын материалаар хангах замаар үйлчилгээгээ сайжруулах НЦҮТ-ийн хүсэлтэд олгосон байна. Нутгийн иргэдийн хамгийн эмзэг бүлгийнхнийг аварч, амьдралыг нь сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж буйгаа ойлгосон энэ төвийн ажилтнууд санхүүжилтээ нэмэгдүүлэх, чадавхаа бэхжүүлэх, түүнчлэн даван туулагчдад илүү чадавхиж, амьдралаа цаашид хүчирхийллээс ангид авч явах чадавхийг олгох боломжуудыг үргэлжлүүлэн эрэлхийлсээр байна.

## ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН БИЕ МАХБОДЫН БОЛОН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР



## ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЛИЙН АЛЬ НЭГ ХЭЛБЭРТ ӨРТСӨН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР



## ТЭРГҮҮН ТУРШЛАГА БОЛОН СУРГАМЖ

ЖСХ-тэй тэмцэх нь төсөл нь энэ чиглэлд хэрэгжсэн анхны том хэмжээний, өргөн хүрээг хамарсан цогц төсөл юм. Энэхүү төсөл нь өмнөө тавьсан зорилгодоо бүрэн хүрсэн бөгөөд төслийн хүрээнд ЖСХ/ГБХ-ийн тоо мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үр дүнтэй бодлого, эрх зүйн орчныг бий болгоход нөлөөлөх, шийдвэр гаргагчдын болон олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлснээр дэмжлэг бүхий орчныг бүрдүүлэх, хохирогч хамгааллын болон нөхөн сэргээх үйлчилгээний үр дүнтэй тогтолцоог бий болгох чиглэлд ихээхэн ахиц гарсан юм. Төслийг хэрэгжүүлэх явцад гарсан тэргүүн туршлага болон сургамжуудыг доор сийрүүллээ.

1. НЦҮТ-ийн ажилтнуудад зориулсан харилцан туршлага солилцох орон нутгийн танилцах аялал болон ажлын байран дээрх сургалтууд нь үйл ажиллагааг газар дээр нь бодитой байдлаар судалж, харилцан ярилцах, тодруулах замаар суралцах боломжийг олгодог утгаараа мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, аргачлал ур чадварт суралцах хамгийн үр дүнтэй үйл ажиллагаа болсон. Танилцах аялалын үеэр оролцогчид нийтлэг бэрхшээлүүд тулгамдсан асуудлууд түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаараа ярилцаж, үр дүнтэй шийдлийг хамтран эрэлхийлж, сайн туршлагуудаа хуваалцсан юм. Эдгээр үйл ажиллагаанууд нь лекц болон танхимын хэлбэрээр явагддаг сургалтуудаас илүүтэй тэргүүн туршлага санаачлагыг нүдээр харж, чихээрээ

сонсон, биеэрээ мэдрэх боломжийг олгосон. Улмаар НЦҮТ-ийн ажилтнууд өөр хоорондоо танилцаж, сайн харилцаа тогтоож, цаашид илүү ойр хамтран ажиллах боломжийг бас олгосон.

2. Төслийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэгтэй Мэргэжлийн хороо, олон нийтэд хандсан сургалт сурталчилгааны үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүрэгтэй Мэдээлэл сурталчилгааны дэд хороог төслийн дэргэд төслийг хэрэгжүүлэгч байгууллагуудын мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсан нь төслийн хэрэгжилт болон олон нийтийг хамарсан үйл ажиллагааны нэгдсэн зарчим, зорилго, мессежийг боловсруулан олон нийтэд нэгдсэн нэг мэдээлэл хүргэх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, салбар бүрийн мэргэжлийн давуу талаас харилцан суралцах боломжийг бүрдүүлсэн нь төсөл амжилттай хэрэгжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн.
3. Олон нийтэд хандсан мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагааны олон нийтэд хүргэхийг хүссэн мессеж нэгдмэл, өөр хоорондоо зөрчилдөхгүй байх нь олон нийтийг төөрөлдүүлэхгүй, зөв ойлголт өгснөөр илүү үр дүнтэй байх боломжтой. Үндэсний хэмжээнд олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны аяныг шинэлэг хэлбэрээр явуулж эхлүүлсэн төслийн туршлагаас үзэхэд салбаруудын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх, нөөц боломж, оролцогч талуудын давуу

талуудыг нэг чигт төвлөрүүлснээр хавьгүй илүү үр дүнд хүрэх боломж байгааг харуулсан.

4. КОВИД-19-ийн цар тахлын улмаас хөл хорио тогтоож, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг цуцалсан нь төслийн үйл ажиллагаанд бэрхшээл учруулсан. Гэвч үүссэн энэхүү нөхцөл байдлыг ойлгож, төслийн үйл ажиллагааг тасалдуулахгүй, ялангуяа олон нийтийг хамарсан сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг онлайн хэлбэрээр хийх, мөн хүчирхийллийн хохирогчдод зайнаас үйлчилгээ үзүүлэх арга замуудыг сонгосон нь чухал үр дүнтэй болсон. Хэдийгээр эдгээр онлайн платформууд нь биечлэн уулзаж ярилцах, харилцах сургалтын нүүр тулсан хэлбэрүүдийг бүрэн орлож чадахгүй ч тодорхой хүчин зүйлсийн нөлөөгөөр үйл ажиллагаа хязгаарлагдмал байдалд орсон цаг үед үйл ажиллагааг үргэлжлүүлэх, уулзалт, сургалтуудыг зохион байгуулах, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэх өртөг багатай, үр дүнтэй арга байж чадсан юм.
5. Төрийн албан хаагчдын халаа сэлгээ их байх, түүнчлэн хэрэгжүүлэгч байгууллагуудын шийдвэр гаргагчид өөрчлөгдөх нь өмнө эхэлсэн шинэлэг санаачилгуудыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж, хэрэгжилтийг удаашруулах эрсдэлийг бий болгодог. Учир нь шинээр томилогдсон ажилтнуудад төслийн талаар болон төслийн хүрээнд шийдвэрлэхийг зорьж байгаа асуудлын нарийн онцлогыг ойлгуулах, чадавхийг нь бэхжүүлэх

ажлыг дахин эхнээс нь эхлэх шаардлага гардаг нь төслийн хэрэгжилтэд нөлөөлдөг чухал хүчин зүйл байдаг. Ийм учраас шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, үйлчилгээ үзүүлэгч нарыг ЖСХ-ийн асуудлаархи болон хохирогчид болон хүчирхийлэгчидтэй ажиллах арга зүйн асуудлаархи сургалтад тогтмол, системтэй сургадаг тогтолцоог бий болгох нь маш чухал. Энэ нь албан тушаалтнууд болон асуудал хариуцсан ажилтан солигдох үед үүсдэг бэрхшээлийг бууруулах ач холбогдолтойгоос гадна бүх үүрэг хүлээгчдэд жендэр болон ЖСХ-ийн асуудлын талаар системтэй суурь мэдлэг олгосноор засгийн газраас явуулж байгаа үйл ажиллагаа, үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгоход чухал ач холбогдолтой. Яам, агентлагуудаас зохион байгуулдаг тогтмол сургалтуудад, мөн кредит олгох мэргэжлийн сургалтууд, их дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт ЖСХ-ийн модулийг оруулж өгөх замаар энэхүү тогтолцоог төлөвшүүлэхэд тустай болно.

6. Хүчирхийллийн даван туулагчид болон хүчирхийлэл үйлдэгчдэд шаардлагатай үйлчилгээг чанартай, тасралтгүй үзүүлэхэд дан ганц үйл ажиллагааны зардлыг бус, дэд бүтэц, хүний нөөц болон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах зардлыг олгох хангалттай бөгөөд тогтвортой санхүүжилтийн тогтолцоо шаардлагатай. Өөрөөр хэлбэл эрх баригч нам солигдох эсэхээс үл хамаарч, ЖСХ зэрэг жендэрийн асуудлуудад зориулан тогтвортой төсөв хуваарилдаг санхүүжилтийн механизмийг хэвшүүлэх нь чухал



юм. Ийм учраас судалгаа, туршлагад үндэслэсэн, бодитой, тодорхой хэмжээний төсвийг засгийн газар болон орон нутгийн захиргаанаас хуваарилахын чухлыг хуульчилж өгсөн жендэрийн мэдрэмжтэй санхүүжилтийн эрх зүйн тогтолцоог батлах хэрэгтэй байна.

7. Тоо мэдээлэл нь ухуулга нөлөөллийн ажлыг дэмжиж, үйл ажиллагааны хэрэгжилтийг чиглүүлдэг утгаараа төслийн үйл ажиллагааны нэг гол чиглэл нь тоо мэдээллийн тогтолцоог бий болгох явдал байв. Төслийн хүрээнд ЖСХ-ийн үндэсний хэмжээний тархалтын тоо мэдээлэлтэй болж, ГБХ-ийн захиргааны статистикийн мэдээллийн сан болон үйлчилгээний мэдээллийн сан үүсч, бүрэн ажиллагаанд орсон нь эхний шатны гол амжилтуудын нэг хэдий ч цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, бодлого хөтөлбөрт ашиглах ашиглалтыг сайжруулах шаардлага байсаар байна. Одоогоор байгаа тогтолцоо нь мэдээллийг нэгтгэхэд тохиромжтой биш бөгөөд холбогдох агентлагуудын хооронд мэдээлэл хуваалцах ажлыг гар аргаар, хязгаарлагдмал хүрээнд хийдэг нь хүчирхийллийн тохиолдлуудыг давхардуулан тоолоход хүргэхийн зэрэгцээ дүн шинжилгээ хийх, чиг хандлага тодорхойлох ажилд бэрхшээл учруулсаар байна. Мэдээллийн санг нэгтгэхэд тулгарч буй бэрхшээлийг даван туулах шийдлүүдийг эрэлхийлж байгаа боловч, Монгол дахь ЖСХ-ийн нөхцөл байдлыг илүү бүрэн цогцоор ойлгож, улмаар үр дүнтэй шийдвэрлэхийн тулд

холбогдох салбар, байгууллага хоорондын тоо мэдээллийг нэгтгэн, нэгдсэн дүгнэлт хийх шаардлагатай хэвээр байна.

8. ЖСХ-тэй тэмцэх төслийн хүрээнд бодлогын болон зохион байгуулалтын түвшинд ЖСХ-ийг шийдвэрлэх бүтцийг бэхжүүлэх, инновацийг хэрэгжүүлэх ажлууд хийгдсэн. Төслийн ихэнх шалгуур үзүүлэлтүүдээс дээрх түвшинд гарсан ахиц дэвшлийг харах боломжтой. Хэдийгээр ЖСХ нь хувь хүмүүсийн хүрээнд гарч, тэдний амьдралд шууд нөлөөлдөг боловч энэ үзэгдэл нь нийгмийн амьдрал, өрх гэрийн амьдралд дам байдлаар нөлөөлдөг учраас энэ чиглэлээр хийгдэж байгаа үйл ажиллагаа бодлогууд эцсийн дүндээ хүмүүсийн амьдралыг сайжруулахад чиглэсэн байдаг. Ийм учраас төслийн болон бодлого шийдвэрийн хэрэгжилт зорилтот бүлгийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж чадаж буй эсэхийг мэдэхийн тулд даван туулагчдын түвшинд хэр үр нөлөөтэй байгааг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг төслийн хүрээд оруулж өгөх нь зөв юм. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг хэмжихдээ үйл ажиллагааны бодит үр нөлөө ямар байсныг илүү нарийн тодорхойлж чадах өөрөө өөртөө хийх өөрчлөлтийн үнэлгээ зэрэг чанарын аргыг ашиглаж болно.
9. ЖСХ-ийн суурь шалтгаан нь жендэрийн хэвшмэл ойлголтууд, нийгмийн хэм хэмжээ, хүлээлт, итгэл үнэмшлийн улмаас бий болдог жендэрийн тэгш бус байдал бөгөөд ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, үр дүнтэй таслан зогсоохын тулд нийгмийн бүх

гишүүдтэй ажиллаж, оюун санааны томоохон шилжилт хийх шаардлагатай юм. Түүнчлэн, Монгол улсад ЖСХ үйлдэгчдийн дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа учраас эрэгтэйчүүд болон хөвгүүдийг энэ чиглэлийн үйл ажиллагаанд оролцуулж, жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголтыг хүн бүрт хүргэх, ЖСХ-ийг таслан зогсооход хүн бүрийн оролцоо чухлыг ойлгуулах нь маш чухал юм.

10. Хамгийн сайн төлөвлөгөө ч урьдаас харах боломжгүй гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр саатах нь бий. КОВИД-19-ийн цар тахал дэлхий даяар тархсан 2020 онд төслийн хэрэгжилтэд яг ийм бэрхшээл тохиосон билээ. Энэхүү цар тахлыг дотооддоо алдахгүйн тулд авч хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх хатуу арга хэмжээ нь манай төслийн хэрэгжилтэд нөлөөлсөн юм. Тухайлбал, олон нийтийг хамруулан зохиох байсан арга хэмжээ

болон бусад үйл ажиллагааг цуцлахад хүргэж; анх ЖСХ-тэй тэмцэхэд зориулж хуваарилаад байсан хөрөнгийг цар тахалтай тэмцэх ажилд шилжүүлэх болж; улс орон дахь ЖСХ-ийн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөр түүнтэй тэмцэх арга хэмжээнүүдийг мөн адил өөрчлөх шаардлага тулгарсан юм. Ийм учраас аливаа томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэхдээ урьдаас таамаглах боломжгүй нөхцөл байдлыг харгалзан үзэж, уян хатан өөрчлөлт хийх боломжийг олж харах нь чухал байдаг. Төсөл энэ үүргээ маш сайн гүйцэтгэж, засгийн газрын байгууллагууд болон донор байгууллагатайгаа хэлэлцэн ярилцсаны үр дүнд төслийн төлөвлөгөөнд шуурхай өөрчлөлтийг хийж, тухайн нөхцөл байдалд шаардлагатай байсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төслийн мөнгийг хуваарилсан нь цаг үеэ олсон үйл ажиллагаа байсан.